

Шинэ сэргэлтийн бодлогыг хэрэгжүүлэх эхний үе шатны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт

дд	Үйл ажиллагаа, арга хэмжээ	Хүрэх үр дүн	Санхүүжүүлэх эх үүсвэр	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ /тэрбум төгрөг/	Хэрэгжилт	Хариуцах үндсэн байгууллага	Хэрэгжилт-ийн хувь
НЭГ.БООМТЫН СЭРГЭЛТ							
Зорилт 1.1. Боомтуудын хатуу, зөөлөн дэд бүтцийг хөгжүүлэн ачаа болон зорчигч нэвтрүүлэх хүчин чадлыг дээшлүүлж, экспортыг нэмэгдүүлнэ.							
1	1.1.1. Боомтуудыг хөгжүүлэх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг тодотгох, шинээр нэмж боловсруулах замаар боомтуудын хөгжлийг хөрш орнуудын боомттой ижил түвшинд хүргэж, дэд бүтэц, тээвэр зохион байгуулалтыг олон улсын стандартад нийцүүлэх	Бүх боомтын хөгжлийн төлөвлөгөө боловсруулагдсан байна.	-	-	Манай улс хилийн асуудлаар хөрш орнуудтай байгуулсан олон улсын гэрээ, хэлэлцээрийн дагуу нийт 39 боомттойгоос байнгын ажиллагаатай 27 боомт байна. Уг байнгын ажиллагаатай 27 боомтоос хөгжлийн ерөнхий төлөвлөгөө хийгдсэн 11, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө хийгдсэн 6 боомт байна. Засгийн газрын тогтоол болон Хилийн боомтын үндэсний зөвлөлийн тогтоолоор баталсан 11 хилийн боомтын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг Газар зохион байгуулалт, төлөвлөлтийн цахимд системд бүртгэн оруулсан. Үүнд: 1. Нийт 6 боомтод өргөтгөл, шинэчлэлийн ажил хийгдэж байгаа бөгөөд Замын-Үүд, Алтанбулаг, Боршоо боомтын өргөтгөл шинэчлэлийн бүтээн байгуулалт 60-0%-ийн гүйцэтгэлтэй, Гашуунсухайт боомтын өргөтгөл шинэчлэлийн ажил 10 орчим хувийн гүйцэтгэлтэй буюу удаашралтай, Цагаан дэл-Уул боомтын зураг төсөл, бүтээн байгуулалтын ажил удаашралтай байгаа бөгөөд тус боомтын асуудлыг Өмнийн говийн бүсийн хөгжлийн зөвлөлөөр хэлэлцүүлэхээр төлөвлөж байна. Бичигт боомтын өргөтгөл шинэчлэлийн зураг төсөл боловсруулагдсан боловч гүйцэтгэгч компани шалгараагүй байна. Нийт 10 боомтын зураг төслийг шинээр боловсруулж байгаа бөгөөд 12 сард дуусгахаар төлөвлөж байна. 2. Азийн хөгжлийн банктай хамтран “Монгол Улсад ухаалаг хил боомтыг хөгжүүлэх нь” дугуй ширээний уулзалт-ыг 2022 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр зохион байгуулсан. Боомтын өргөтгөл шинэчлэлийн ажлыг эрчимжүүлж олон улсын жишигт нийцсэн архитектур дизайны шийдэл бүхий төлөвлөлтийг хийж, боомтын чиглэлээр мэргэшсэн олон улсын зөвлөхүүдтэй мэдлэг хуваалцаж, боомтын хөгжилд тулгарч буй асуудлыг тодорхойлон цаашид хамтран ажиллах талаар хэлэлцүүлэг зохион байгуулсан. 3. Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 8 дугаар сарын 10-ны өдрийн хурлаар Хилийн боомтын хөгжлийн ерөнхий төлөвлөлт чиглэлээр танилцуулга хийсэн. Хилийн боомтын хөгжлийн ерөнхий төлөвлөлтийг хөрш орнуудын бодлоготой уялдуулан боловсруулах, боомтын бүтээн байгуулалтын орон зайн төлөвлөлтийг харгалзан үзэх, боомтуудыг төрөл, чиглэлээр нь ангилан эрэмбэлэх, боомтыг эдийн засгийн эргэлтэд оруулах хууль эрх зүйн орчныг сайжруулах, боомтын нэгдсэн удирдлага бий болгох зэрэг саналуудыг танилцуулсан. 4. Өмнийн говийн бүсийн хөгжлийн зөвлөлийг Засгийн газрын 2022 оны 8 дугаар сарын 3-ны өдрийн 294 дүгээр тогтоолоор баталсан. 2022 оны 9 дүгээр сарын 14-ний өдрийн Засгийн газрын 344 дүгээр тогтоолоор бүрэлдэхүүнд нэмэлт оруулсан. Зөвлөлийн ажиллах журмын төслийг боловсруулсан. 5.Цагаан дэл-Уул боомтыг нээн ажиллуулахад тулгамдаж буй асуудлыг Өмнийн говийн бүсийн хөгжлийн зөвлөлийн хуралдаанаар	ЭЗХЯ БХБЯ	90.0

					хэлэлцүүлж санал дүгнэлт гаргуулах үүрэг бүхий ажлын хэсгийг Ерөнхий сайдын 2022 оны 7 дугаар сарын 20-ны өдрийн 107 дугаар захирамжаар Эдийн засаг, хөгжлийн сайдын үүрэг хариуцагч Б.Жавхлангаар ахлуулан байгуулсан. Мөн тус захирамжтай уялдуулан Эдийн засаг, хөгжлийн сайдын 2022 оны 8 дугаар сарын 10-ны өдрийн А-71 тоот тушаалаар Ажлын дэд хэсгийг Төрийн нарийн бичгийн дарга Х.Батжаргалаар ахлуулан байгуулсан. Тус ажлын хүрээнд "Өмнийн говийн бүсийн хөгжлийн зөвлөлийг Засгийн газрын 2022 оны 8 дугаар сарын 3-ны өдрийн 294 дүгээр тогтоолоор батлуулж, 2022 оны 9 дүгээр сарын 14-ний өдрийн Засгийн газрын 344 дүгээр тогтоолоор бүрэлдэхүүнд нэмэлт оруулсан. Зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчилсэнтэй холбогдуулан зөвлөлийн анхдугаар хуралдааныг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдөр Төрийн ордонд зохион байгуулсан. Хурлаас Цагаан дэл-Уул боомтын асуудлаар дахиж хэлэлцэх шаардлагатай гэсэн чиглэл гараад байна.		
2	1.1.2. Хилийн боомтоор бүх төрлийн бараа бүтээгдэхүүн нэвтрүүлэх асуудлыг хөрш орнуудтай дипломат шугамаар харилцан, шийдвэрлэх	Саналыг хөрш орнуудтай дипломат шугамаар хэлэлцэж шийдвэрлэсэн байна.	-	-	Монгол Улс "Дэлхийн худалдааны байгууллага байгуулах тухай Марракешийн хэлэлцээрт Монгол Улс нэгдэн орох тухай Протокол"-оор шаталсан хугацаа бүхий үүрэг амлалт авсны дагуу тооны хязгаарлалтыг импорт, экспортод тогтоохоор болсон. Экспортын лицензийг зөвхөн түүх дурсгалын болон археологийн олдвор, буу, зэвсэг, цус болон цусан бүтээгдэхүүн, радио идэвхт бодис зэрэг тусгайлан бараанд шаарддаг. Иймд экспортын бүтээгдэхүүний нийт хэмжээ болон боомтоор экспортлох бүтээгдэхүүний хэмжээг худалдан авагч талтай Засгийн газрын түвшинд тохиролцож, гэрээ байгуулах асуудлыг хариуцсан яамдын санал, дүгнэлтэд нийцүүлэн хэрэгжүүлж байна. Эрээн хотын Онцгой комиссоос 2022 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр 99 тоот мэдэгдэл гаргаж, Замын-Үүд-Эрээн боомтоор эхний ээлжид дулааны аргаар боловсруулсан үхэр, хонины махны экспортыг сэргээсэн. Энэ дагуу 9 дүгээр сард дулааны аргаар боловсруулсан мах, махан бүтээгдэхүүний экспортыг эхлүүлэх хүсэлт болон ачилтын хуваарийг Хятадын талд хүргүүлсэн. 2022 онд ГХЯ-аас БНХАУ-ын ГХЯ-нд шатахуун, бензин, эм, эмнэлгийн хэрэгсэл, барьцалдуулагч, хүнсний гол нэр төрлийн бүтээгдэхүүн, өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд хэрэгцээт эрчим хүчний салбарын ачаа, стратегийн бүтээн байгуулалтын төслийн ачаа зэрэг 9,000 гаруй вагоны захиалгын мэдээллийг тухай бүр хүргүүлж ажилласан.	ГХЯ	100.0
3	1.1.3. Боомтуудын ажиллах цагийг уртасгах чиглэлээр хөрш орнуудад дипломат шугамаар санал тавьж, шийдвэрлэх	Гэрээ, хэлэлцээр байгуулсан байна.	-	-	Монгол, Хятадын хилийн боомт, тэдгээрийн дэглэмийн тухай Засгийн газар хоорондын хэлэлцээрийн 5.1 дэх хэсэгт заасны дагуу БНХАУ-ын ГХЯ-ны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн [2021] Хил №60, Монголын талын 2022 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн А-37/2022 ноот бичгээр хоёр улсын хилийн авто замын Булган-Такашикэн боомтыг Бямба, Ням гарагт 10.00-19.00 цагт, Шивээхүрэн-Сэхээ боомтыг 7 хоногийн 1-5 дахь өдөр 17.00-20.00, Бямба гарагт 08.00-20.00 цагт, Гашуунсухайт-Ганцмод боомтыг 1-5 дахь өдөр 17.00-20.00, Бямба гарагт 08.00-20.00 цагт, Ханги-Мандал боомтыг 1-5 дахь өдөр, 17.00-20.00, Бямба гарагт 08.00-20.00 цагт, Бичигт-Зүүнхатавч боомтыг 1-7 дахь өдөр 17.00-20.00 цагт, Баянхошуу-Өвдөг боомтыг Бямба, Ням гарагт 08.00-17.00 цагт ажиллах, Хятадын талын 2022 оны 09 дүгээр сарын 23-ны [2022] Хил-59, Монголын талын 2022 оны 11 дүгээр сарын 03-ны А-517/2022 тоот ноот бичгээр Бургастай-Лаоемя боомтыг Бямба, Ням гарагт 10.00-18.00 цагт тус тус нэмэлт цагийн хуваарийн дагуу ажиллуулахаар тохиролцож, улс хоорондын экспорт-импортыг нэмэгдүүлэх суурь нөхцөлийг бүрдүүлсэн.	ГХЯ	100.0
4	1.1.4. Экспортын бараанд	Гэрээ, хэлэлцээр	-	-	Салбарын судлаачдын хийсэн судалгаанд үндэслэн Экспортын	ХХААХҮЯ	30.0

	ногдож байгаа тарифын болон тарифын бус саадыг бууруулах чиглэлээр гэрээ, хэлэлцээр хийж, хэрэгжүүлэх	байгуулсан байна.			бараанд ногдож буй тарифын болон тарифын бус саад, бэрхшээлийг бууруулах талаар холбогдох саналыг боловсруулан, Засгийн газрын 2022 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн хуралдаанд танилцуулж, хэлэлцүүлээ. Тус хуралдаанаас гарсан чиглэлийн дагуу экспортын бараанд ноогдож буй тарифын болон тарифын бус саад бэрхшээл, хүндрэлтэй асуудлыг ангилж авч үзэн, холбогдох тусгай зөвшөөрөл, эрх олгох, стандарт тогтоох асуудлыг цөөлөх, бууруулах талаар судалгаа хийх, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг боловсруулан, Засгийн газарт танилцуулахаар болсонтой холбогдуулан холбогдох мэдээлэл авахаар Монгол Улсын Шадар сайд, Эдийн засаг, хөгжлийн сайд, Сангийн сайд, Гадаад харилцааны сайд нарт 2022 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн 01/984 албан тоот хүргүүлсний дагуу холбогдох яам, агентлагаас ирүүлсэн саналыг нэгтгэн, Засгийн газраар хэлэлцүүлэхээр ажиллаж байна.		
5	1.1.5. Боомтуудын үндсэн байгууламж /эрчим хүч, дулаан, усан хангамж, ариутгах татуурга, интернэтийн сүлжээ, гаалийн лаборатори, зорчигч болон ачаа тээврийн терминал/-ийг өргөтгөн шинэчилж, зорчигч аялах, албан хаагчдын ажиллах ая тухтай орчныг бүрдүүлэх	Зорчигч болон ачаа нэвтрүүлэх хүчин чадал 3 дахин нэмэгдсэн байна.	-	-	1. Замын-Үүдийн эдийн засгийн чөлөөт бүсэд зориулсан дулааны станц, ус хангамжийн эх үүсвэр, ус цэвэршүүлэх үйлдвэр, цэвэрлэх байгууламжийг барьж ашиглалтад оруулсан. 2. АХБ-ны хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлж буй Эдийн засгийн хамтын ажиллагааны бүсийг хөгжүүлэх төсөл-МОН 3936 төслийн хүрээнд "Замын-Үүд" чөлөөт бүсийн 1-р үе шатны дэд бүтэц, гүний гарцын шалган нэвтрүүлэх нэг цэгийн үйлчилгээний цогцолбор барилга байгууламжийн нарийвчилсан инженерийн зураг төсөл боловсруулах зөвлөхөөр шалгарсан "Сонголт Дизайн" ХХК-тай 2022 оны 03 дугаар сарын 25-нд гэрээ байгуулсан. "Сонголт Дизайн" ХХК чөлөөт бүсийн нарийвчилсан инженерийн зураг төсөл боловсруулах ажлын хуваарь, бүтээгдэхүүн хүргэлтийн хуваарь, гүйцэтгэх ажлууд болон Замын-үүд чөлөөт бүсэд өмнө баригдсан инженерийн шугам сүлжээний өнөөгийн нөхцөл байдал, байр зүйн зургийн судалгааг багтаасан эхлэлийн тайланг төслийн нэгжид ирүүлснийг хянаж, зөвлөмж чиглэл өгч, 2022оны 08 дугаар сарын 29, 2022 оны 10 дугаар сарын 24-ний өдөр тус тус баталгаажуулан хүлээн авсан. "Замын-Үүд" чөлөөт бүсийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө /тодотгол/, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө /300га/-г Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж батлуулахаар Шадар сайдын ажлын алба болон ЭЗХЯ-нд 2022 оны 4 дүгээр сард хүргүүлсэн бөгөөд холбогдох шийдвэр гараагүй байна. Замын-Үүд чөлөөт бүсийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө /тодотгол/, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө /300га/-тэй уялдуулан чөлөөт бүсийн 2 дугаар хэлхээний ажлын зураг төсөл боловсруулах даалгаврын төслийг боловсруулж, ЗТХЯ, Хил, Гааль, Мэргэжлийн хяналт, харьяатын алба, хорио цээрийн зэрэг холбогдох мэргэжлийн байгууллагуудаас санал авч тусган батлуулахад бэлэн болсон. "Сонголт дизайн" ХХК-ийн санхүүжилтийн хүсэлтийг АХБ-нд уламжилсан. Төслийн явцыг эрчимжүүлэх талаар Монгол Улсын Засгийн газар, АХБ хооронд 2022 оны 08 дугаар сарын 19-нд Харилцан ойлголцлын санамж бичиг байгуулсан. 3. Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумын Эдийн засгийн чөлөөт бүсийн ариутгах татуургын шугам сүлжээний зураг төсөл, угсралтын ажлын гүйцэтгэчийг сонгон шалгаруулах тендерийг 2022 оны 02 дугаар сарын 10-нд зарласан. Тендерийн нээлтийг 2022 оны 03 дугаар сарын 14-нд зохион байгуулсан. Үнэлгээний хороо хуралдаж, шийдвэрээ гарган 2022 оны 03 дугаар сарын .22-нд шалгарсан компанид албан бичиг хүргүүлсэн. Шалгарсан "Нягт холбоос" ХХК-тай гэрээ байгуулж ажиллах талаар Барилгын хөгжлийн төвд 2022 оны 03 дугаар сарын 30-ны 3/1346 тоот албан бичгийг хүргүүлж,	БХБЯ, ЭЗХЯ	90.0

					гэрээ байгуулсан. Захиалагчийн хяналтыг Барилгын хөгжлийн төв хэрэгжүүлэн ажиллаж байна. Хилийн боомтуудын дэд бүтцийн бүтээн байгуулалт, барилга байгууламж барих ажлын хүрээнд: Гашуунсухайт боомтын барилга бүтээн байгуулалтын ажил явагдаж байна. -Бүтээн байгуулалтыг хийж дуусгах хугацаа 2023 оны 08 сар, -Санхүүжилт 107.7 сая юань буцалтгүй тусламж, -Гүйцэтгэгч "Жунмэй инженеринг групп" ХХК Төслийн хүрээнд Эрдэс баялгийн 16 эгнээ бүхий хүнд даацын авто зам /Экспорт-10, импорт-6/, Зорчигч ачаа тээврийн хэрэгслийг нэвтрүүлэх хэсэгт 6 эгнээ авто зам /Орох-3, гарах-3/, боомтын барилга байгууламж, ажилчдын орон сууц, гадна инженерийн шугам сүлжээний ажил хийгдэж байна. -Боршоо боомтын барилга байгууламж, бүтээн байгуулалтын ажил явагдаж байна. - зорчигч тээврийн 21 барилга, ногоон байгууламж 6000м2, иж бүрэн инженерийн шугам сүлжээ, Авто замын зогсоол-30000м2 Нийт гүйцэтгэлийн хувь 87%. -Шивээхүрэн, Хавирга, Булган боомтын ТЭЗҮ, Байгаль орчны үнэлгээ, ажлын нарийвчилсан зураг төсөл хийгдэж байна. -Арц суурь, Бага илэнх боомтын суурь судалгаа, төлөвлөлт концепц хийгдэж байна. Замын-Үүд, Алтанбулаг, Боршоо боомтын өргөтгөл шинэчлэлийн бүтээн байгуулалт 60-80%-ийн гүйцэтгэлтэй, Гашуунсухайт боомтын өргөтгөл шинэчлэлийн ажил 10% гүйцэтгэлтэй байна. Эдгээр бүтээн байгуулалт хийгдсэнээр боомтын үндсэн байгууламж бүрэн шийдэгдэж ая тухтай орчин бүрдэнэ. Сүхбаатар төмөр замын боомтын нэг цэгийн үйлчилгээний барилга байгууламж 90%-ийн гүйцэтгэлтэй байгаа бөгөөд тус барилга ашиглалтад орсноор гааль, мэргэжлийн хяналт, хилийн цэрэг, гадаадын иргэн харьяатын зэрэг байгууллагуудын ажиллах орчин нөхцөл сайжрах ачаа иргэд нэг цэгийн үйлчилгээ авах боломж нэмэгдэх юм. Гашуунсухайт хилийн боомтод чингэлэгт тээврийн терминал байгуулсан. Уг бүтээн байгуулалтын санхүүжилтийн 60 хувийг “Эрдэнэс Таван Толгой” ХК, 15 хувийг “Таван-толгой” ХК, 25 хувийг “Энержи Ресурс” ХХК гаргажээ. Төслийн гүйцэтгэгчээр “Энержи Ресурс” компани ажилласан байна. Шивээхүрэн боомтод чингэлэг тээврийн нэмэлт терминал байгуулах ажил 80 гаруй хувьтай үргэлжилж байна. уг терминалыг “Энержи ресурс” ХХК, “Эрдэнэс Тавантолгой” ХК, “Тавантолгой” ХК-ийн хөрөнгөөр байгуулж буй юм. Мөн Шивээхүрэн боомтын гаалийн хяналтын нэмэлт гарцыг “Монголын Алт” (МАК) ХХК барьж, Хил хамгаалах ерөнхий газарт хүлээлгэн өгсөн бөгөөд чингэлэгт тээврийн терминалын зам талбайн ажил эхэлжээ.		
6	1.1.6. Уул уурхайн бүтээгдэхүүний экспортын голлох боомтуудад чингэлэгт тээврийн терминал, ачиж буулгах терминал, шилжүүлэн ачих терминалуудыг барих	Терминалуудыг барьж байгуулсан байна.			Монгол Улсын Ерөнхий сайд 2022 оны 2 дугаар сарын 3-8-ны өдрүүдэд БНХАУ-д айлчилж, Өвлийн олимпын наадмын нээлтэд оролцох үеэр МУ-ын Ерөнхий сайд БНХАУ-ын Төрийн зөвлөлийн Ерөнхий сайд Ли Көчянтай албан ёсны уулзалт хийж, талууд короновируст цар тахлын эсрэг хэрэгжүүлж буй Монгол, Хятадын хамтын ажиллагааг өндрөөр үнэлж, хүндрэл бэрхшээлийг хамтдаа даван туулж, харилцан дэмжлэг үзүүлэхээр санал нэгдсэн. Монгол Улсын Ерөнхий сайдын 2021 оны 196 дугаар захирамжаар байгуулагдсан Ажлын хэсэгт хилийн боомтын үйл ажиллагааг сайжруулж, экспорт, импортын барааны ачаа тээврийг эрчимжүүлэх	ЗТХЯ	30.0

					чиглэлээр нөхцөл байдлын газар дээр нь үзэж шалган, бодлогын санал, дүгнэлт гаргаж дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий Ажлын дэд хэсэг Шадар сайдын 2022 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн 08 тоот тушаалаар байгуулагдан ажиллаж байна. Хилийн Шивээхүрэн боомтын төмөр зам, ачаа ачих байгууламж барих, тус төслийг хэрэгжүүлэх “Шивээхүрэн төмөр зам” ХХК байгуулах асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, шийдвэрлүүлэхээр Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулан санал авахаар Засгийн газрын гишүүдэд 2022 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 01/222 тоот албан бичгээр хүргүүлсэн.		
7	1.1.7. Боомтуудын ачаа нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх нэмэлт байгууламж /дүүжин тээвэр, автомат удирдлагат тээвэр/-уудыг судалж, барих	Боомтуудын ачаа нэвтрүүлэх хүчин чадал 2-3 дахин нэмэгдсэн байна.	-	-	ЗТХЯ: Монгол, Хятадын хилийн Гашуунсухайт-Ганцмод хооронд чингэлэг тээвэрлэх жолоочгүй ухаалаг тээврийн төрөл нэвтрүүлэх асуудлыг Хилийн боомтын үндэсний зөвлөлийн 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн хуралд, Засгийн газрын 2022 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн хуралдаанд тус тус танилцуулсан. Автомат удирдлагатай тээврийн ухаалаг систем болон тулгуурт гүүрэн байгууламж бүхий хилийн шилжүүлэн ачих терминалуудын Техник-эдийн засгийн урьдчилсан судалгааг хийж гүйцэтгэн, Засгийн газрын хуралдаанаар газрын асуудлыг шийдвэрлүүлэхээр тогтоолын төслийг бэлтгэж яамдаас санал авахаар хүргүүлсэн. ЭЗХЯ: 1. Гашуунсухайт хилийн боомтод чингэлэг тээврийн терминалыг “Эрдэнэс-Тавантолгой” ХК, “Тавантолгой” ХК, “Энержи Ресурс” ХК хамтарч 30 га талбайд төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд барьж ашиглалтад оруулаад байна. 2. Гашуунсухайт хилийн боомтод AGV (Automatic Guided Vehicle) буюу автомат удирдлагатай тээврийн хэрэгслийг 2022 оны 7 дугаар сарын 16-ны өдрөөс амжилттай туршин экспортын нүүрсийг гаргаж эхэлсэн. Шивээхүрэн хилийн боомтод чингэлэг тээврийн терминал болон автомат удирдлагатай чингэлэг тээврийн терминал “Шивээхүрэн терминал” ХХК хариуцан 17 га талбайд барьж байгуулахаар ажиллаж байгаа бөгөөд гүйцэтгэл 80 гаруй хувьтай байна. 2022 онд багтаан бүрэн хүчин чадлаар ашиглалтад оруулахаар төлөвлөн ажиллаж байна. Засгийн газрын 2022 оны 95 дугаар тогтоолоор Гашуунсухайт боомт орчим 66 га газарт автомат удирдлагатай чингэлэг тээврийн терминал байгуулах, түүний зориулалтаар газар ашиглахыг “Хилийн боомтын онцгой бүрэн эрхт захиргаа”-нд зөвшөөрсөн шийдвэр гарсан.	ЗТХЯ, ЭЗХЯ	70.0
8	1.1.8. Гаалийн хяналтын бүсүүдэд ухаалаг гарц, орчин үеийн өндөр хүчин чадал бүхий рентген болон хяналтын тоног төхөөрөмж, лаборатори байгуулах	Боомтуудад орчин үеийн өндөр хүчин чадал бүхий рентген, дээж авагч тоног төхөөрөмж, гаалийн лаборатори суурилуулсан байна.	-	-	Хилээр нэвтэрч байгаа тээврийн хэрэгслийн бүртгэлийг цахимжуулах зорилгоор Гашуунсухайт, Замын-Үүд, Бичигт, Боршоо, Алтанбулаг, Шивээхүрэн боомтуудад ухаалаг гарц RFID (Radio frequency identification data-радио давтамжит долгионоор тээврийн хэрэгслийг бүртгэх, хянах технологи) системийг суурилуулахаар төлөвлөн, байршлыг урьдчилсан байдлаар тогтоосон. Чингэлэг шилжүүлэн ачих үйл ажиллагаатай холбогдуулан тухайн өдөр Хятадын талаас хилээр оруулах Хятад тээврийн хэрэгсэл, жолооч, чингэлгийн дугааруудыг экспортлогч аж ахуйн нэгж нь гаалийн байгууллагад урьдчилан ирүүлсний дагуу терминал руу орох тээврийн хэрэгслийн дээрх мэдээллийг бүрэн бүртгэж, RFID хаалт нээгдэх байдлаар программд оруулж, бүртгэлийг сайжруулсан. Чингэлгийн хөдөлгөөнд хяналт тавьж ажиллах зорилгоор экспортлогч аж ахуйн нэгжтэй хамтран ажиллаж, Гашуунсухайт боомтын ойролцоо байгуулагдсан чингэлэг тээврийн терминал гаалийн хяналтын бүсэд ухаалаг гарцын системийг суурилуулан бүртгэлийн программыг туршилтаар эхлүүлээд байна. Гашуунсухайт боомтын Чингэлэг тээврийн терминалд суурилуулалт	СЯ	100.0

					хийгдсэн ухаалаг гарцын үйл ажиллагаа болон гаалийн байгууллагаас тавьж буй шаардлагуудад Азийн хөгжлийн банкны /АХБ/ мэргэжлийн шинжээч оруулах талаарх саналыг 2022 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 01-1/418 албан бичгээр хүргүүлсэн. Алтанбулаг, Бичигт, Боршоо боомтуудад суурилагдах ухаалаг гарцын тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалтыг гаалийн байгууллагаас АХБ-д хүсэлт тавьж шийдвэрлүүлэхтэй холбогдуулан тухайн боомтуудад байрших ухаалаг гарцын тоног төхөөрөмжийн тооцооллыг урьдчилсан байдлаар гарган, боловсруулж байна. 2022 оны 4 дүгээр сарын 06-ны өдөр ухаалаг гарц системийн тоног төхөөрөмжийг нийлүүлэх, угсрах, суурилуулах Мэйжүрмэнт ХХК-тай ГЕГ-ын ГХШГ, БХХ, СХОХ-ийн албан хаагч нар хамтарсан уулзалт зохион байгуулсан. Дээрх уулзалтаар Замын-Үүд авто замын шалган нэвтрүүлэх цогцолборын ухаалаг гарцын системийн тоног төхөөрөмжийн байршлыг эцсийн байдлаар тулган, тоо хэмжээг нягталсан. Шивээхүрэн боомтуудад суурилагдах ухаалаг гарцын тоног төхөөрөмжийн тооцооллыг урьдчилсан байдлаар гаргаж Татах хүч ХХК саналаа хүргүүлээд байна. Мэйжүрмэнт ХХК Шивээхүрэн боомтуудад суурилагдах ухаалаг гарцын тоног төхөөрөмжийн ачаа тээврийн хэсгийн экспорт талын боомтоос гарах хаалганы арал дээр тоног төхөөрөмжийн сувагчлалын хоолой татах хэсгийг бэлдэж бетон зүсэлт хийв. Мөн ачаа тээврийн хэсгийн импорт талын боомт руу орох хаалганы арал дээр тоног төхөөрөмжийн сувагчлалын хоолой татах хэсгийг бэлдэж бетон зүсэлт хийсэн. Ажлын явц 23 хувьтай явагдаж байна. БНХАУ-ын буцалтгүй тусламжийн хөрөнгөөр Замын-үүд, Гашуунсухайт боомт, Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтээр Алтанбулаг, Сүхбаатар, Боршоо, Бичигт боомтуудад гаалийн хяналт, шалгалтад ашиглах “ухаалаг гарц”, “рентген төхөөрөмж”, “дээж авагч” төхөөрөмжүүдийг санхүүжүүлж суурилуулахад хүндрэл үүссэнтэй холбоотойгоор Хөгжлийн хөтөч-дэд бүтэц төсөл, Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн төсөлд удаа дараа хандсан боловч шийдвэрлэгдээгүй. Иймд дээрх асуудлыг шийдвэрлүүлэхээр Сангийн яамны Төрийн нарийн бичгийн даргад 2022 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр 01/1014 дугаартай албан бичиг хүргүүлсэн. 2022 оны 05 дугаар сарын 11-ний өдөр Өмнөговь аймаг дахь Гашуунсухайт боомтын Чингэлэгт тээврийн терминал гаалийн хяналтын бүсэд “Ухаалаг гарц” системийн тоног төхөөрөмжийг нийлүүлж, угсарч суурилуулах ажлын гүйцэтгэл, туршиж тохируулсан байдлыг шалгах, хөрөнгийн тооцоо нийлж, бүртгэлжүүлэх зорилгоор 2022 оны 4 дүгээр сарын 25-27-ны өдрүүдэд Гаалийн ерөнхий газрын ГХШГ, СХОХ-ийн албан хаагч нар тус боомтод албан томилолтоор ажилласан. Гаалийн ерөнхий газрын даргын 2022 оны 5 дугаар сарын 19-ний өдрийн А/88 дугаартай тушаалаар гаалийн хяналт, шалгалтын рентген, дээж авагч, ухаалаг гарцын иж бүрдэл тоног төхөөрөмжүүдийг нийлүүлэх, угсарч суурилуулах ажлын гэрээний хэрэгжилтийг зохион байгуулах, хилийн боомтуудын бүтээн байгуулалтын ажилтай уялдуулах, гүйцэтгэлд хяналт тавих, туршиж шалгах, хүлээн авах ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна. DIIP төслийн нэгжийн холбогдох албан хаагч нар, Сангийн яамны ТЗУГ-ын дарга, төслийн удирдах хорооны даргатай 2022 оны 5 дугаар сарын 16-ны өдөр уулзалт зохион байгуулж, БНХАУ-ын Засгийн газрын буцалтгүй тусламжаар: • Замын-Үүд боомтын ачаа тээврийн цогцолбор, зорчигч шалган нэвтрүүлэх цогцолборт суурилуулахаар төлөвлөгдсөн 150 тонн 2, 40	
--	--	--	--	--	---	--

					тонн 2 автопүүг хасуулж, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 6 автопүү суурилуулах; • Гашуунсухайт боомтын эрдсийн хэсэг, зорчигчийн цогцолборын импорт талд суурилуулахаар төлөвлөж байсан 6 автопүүг хасуулж, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 5 автопүүг тус тус суурилуулахтай холбогдуулан рентген болон ухаалаг гарцын тоног төхөөрөмжийн инженерийн дэд бүтцийг БНХАУ-ын гүйцэтгэгч компаниар гүйцэтгүүлэх саналаа танилцуулсан. Дээрх саналтай холбоотойгоор ухаалаг гарцын системийн тоног төхөөрөмжийн тоо хэмжээ, байршилд холбогдох өөрчлөлтийг оруулан, шинэчилж, 2022 оны 5 дугаар сарын 19-ний өдрийн 03/1421, 03/1422 дугаартай албан бичгээр Хөгжлийн хөтөч-дэд бүтэц төслийн нэгжид хүргүүлсэн. ГЕГ-ийн даргын 2022 оны 5 дугаар сарын 19-ний өдрийн А/88 дугаартай тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг Замын-Үүд автозамын боомтод 2022 оны 5 дугаар сарын 25-ны өдрөөс 30-ны өдрүүдэд томилолтоор ажиллаж дараах асуудлыг шийдвэрлэсэн: • Ухаалаг гарцын системийн иж бүрдэл тоног төхөөрөмжийг нийлүүлэх, угсрах, суурилуулах ажлын гүйцэтгэгч Мэйжүрмэнт ХХК-ийн Шивээхүрэн боомтод хийж байгаа ажлыг тус боомтын бүтээн байгуулалт эхлэх хүртэл хугацаагаар хойшлуулах; • “Ухаалаг гарц” системийн иж бүрдэл тоног төхөөрөмжийг нийлүүлэх, угсрах, суурилуулах гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах; • Замын-Үүд боомтод ухаалаг гарцын системийн иж бүрдэл тоног төхөөрөмжийг нийлүүлэх, угсрах, суурилуулах ажлыг тус боомтын бүтээн байгуулалт, зам талбайн ажилтай уялдуулж яаралтай эхлүүлэх. Гаалийн шинэчлэлийн хүрээнд Алтанбулаг боомтод хяналтын тоног, төхөөрөмж суурилуулах үйл ажиллагааг боомтын бүтээн байгуулалттай уялдуулж, эрчимжүүлэх зорилгоор ажлын хэсэг томилогдон тус боомтод 2022 оны 6 дугаар сарын 03-ны өдрөөс 05-ны өдрүүдэд ажилласан. Төслийн гүйцэтгэгч Монкон ХХК-иас боомтын бүтээн байгуулалтын үе шат, төлөвлөлтийн талаар ГЕГ-ын ажлын хэсэг, ИСБА ХХК -д мэдээлэл өгч, гаалийн хяналт шалгалтын тоног төхөөрөмжийг суурилуулахад шаардагдах инженерийн дэд бүтцийг шийдвэрлэж, боомтын бүтээн байгуулалтын төлөвлөгөөтэй уялдуулах, мөн зайлшгүй хийгдэх нэмэлт ажлуудыг хэрхэн хэрэгжүүлэх талаар санал солилцсон. ГЕГ-аас 2022 оны 6 дугаар сард 02-1/1551 дугаартай албан бичгээр БНХАУ-ын буцалтгүй тусламжийн хөрөнгөөр Замын-Үүд боомтод хийгдэж байгаа бүтээн байгуулалтын ажилтай уялдуулан ухаалаг гарцын системийн тоног төхөөрөмжийг суурилуулах ажлыг эхлүүлэх хүсэлт болон тус боомтод суурилуулах тоног төхөөрөмжийн тоо хэмжээг шинэчлэн Мэйжүрмэнт ХХК-д хүргүүлсэн. Дээрх хүсэлтийн дагуу Мэйжүрмэнт ХХК-иас ухаалаг гарцын тоног төхөөрөмжийн суурь сувагчлалын ажлыг Замын-Үүд боомтын зорчигч тээврийн терминалын гарах талд 89.7 хувийн, орох талд 85.5 хувийн гүйцэтгэлтэй хийсэн байна. Замын-Үүд боомтын ачаа тээврийн хэсгийн зам талбайн си ти пи хучилтыг эхлүүлмэгц тус талбайд ухаалаг гарцын тоног төхөөрөмжийн суурь сувагчлалын ажлыг эхлүүлэхээр бэлтгэл ханган ажиллаж байна. Автозамын хилийн боомтуудад тээврийн хэрэгсэлд ачигдсан нүүрснээс дээж авч, нүүрсний үнслэг, чийглэг, илчлэг болон хэмжигдэхүйц химийн элементийн агууламжийг автоматаар тодорхойлох 7 ширхэг (AUSTRIA төхөөрөмж+TEXAS төхөөрөмж)		
--	--	--	--	--	---	--	--

					дээж авагчийг Гашуунсухайт, Булган, Ханги, Шивээхүрэн, Бичигт, Цагаандэл-Уул боомтод, тээврийн хэрэгсэлд ачигдсан бараанд нуусан эд зүйлийг тээврийн хэрэгслийн хөдөлгөөний явцад илрүүлэх хүчин чадалтай 14 ширхэг рентгенийг автозамын хилийн 11 боомтод суурилуулахаар төлөвлөн ажиллаж байна. Эхний 1 иж бүрдэл рентген төхөөрөмж Шивээхүрэн боомтод суурилагдан туршилт явуулсан. Зарим алдаа дутагдлыг засуулахаар нийлүүлэгчид мэдэгдсэн бөгөөд 2022 оны 03 дугаар сард багтаан засаж зарлуулах баталгааг нийлүүлэгч тал бичгээр гаргасан. Шивээхүрэн боомтод суурилагдсан ИСБ-А /хяналтын систем/-ийг нийлүүлэгч талын ерөнхий захирал, удирдлагууд 2022 оны 02 дугаар сарын 21-22-ны өдрүүдэд Шивээхүрэн боомтод очиж, рентген тоног төхөөрөмжийн угсралт, суурилуулалтын байдлыг шалган ажиллаж байна. Эдгээр нийлүүлэгч талын удирдлагууд 2022 оны 02 дугаар сарын 24-ний өдөр Гаалийн ерөнхий газрын удирдлагуудтай уулзалт зохион байгуулсан. Үүний дагуу засварын ажил дуусмагц 2022 оны 04 дүгээр сард туршилтыг дахин хийх санал гаргасан. 2022 оны 05 дугаар сарыг 11-ний өдөр ОХУ-ын нийлүүлэгч компаниас мэргэжилтнүүд ирж, Шивээхүрэн боомтод суурилуулсан рентгенийг гаалийн байгууллагад хүлээлгэн өгөхөөр бэлтгэл ажлаа ханган ажиллаж байна. ГЕГ-ын даргын 2022 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн А/86 дугаартай тушаалаар Гаалийн шинэчлэлийн хүрээнд хяналтын зориулалтаар Шивээхүрэн боомтод суурилуулсан ИСБ-А рентген төхөөрөмжийг хүлээн авах ажлын хэсэг байгуулагдан бэлтгэл ажлаа ханган ажиллаж байна. Шивээхүрэн боомтод суурилуулсан гаалийн хяналт, шалгалтын зориулалттай нэг иж бүрдэл ИСБ-А маркийн № 005 серийн дугаартай рентгений бүрэн бүтэн байдал, чанарын баталгаа, иж бүрдэл зэргийг бүрэн хэмжээгээр шалгаж, хүлээн авах зорилготой ажлын хэсгийнхэн тус боомтод 2022 оны 5 дугаар сарын 26-ны өдрөөс 30-ны өдрийн хооронд туршилт хийж, үр дүнг нь удирдлагад танилцуулахаар бэлтгэж байна. Боршоо боомтод суурилуулах рентген төхөөрөмжийн байршлыг “Нью урбанизм” ХХК-ийн 2020 онд боловсруулж, баталгаажуулсан ЕГ Шифр НУ-А/102018/2019 бүхий “Увс аймаг, Давст сум, Боршоо хилийн боомтын өргөтгөл, шинэчлэлийн зураг”-ийн ЕТ-11 тоот хуудсанд заасан Рентген төхөөрөмжийн эдэлбэр газрын эргэлтийн координат /1. 434019.7645; 5615968.3193 2. 434029.2781; 5615929.4671 3. 434009.8520; 5615924.7103 4. 434000.3384; 5615963.5625/-ыг тус боомтын автозамын онцлог, хөдөлгөөний урсгалын хэвийн ажиллагааг хангах, цаашдын төлөвлөлтийг харгалзан 20м*40м талбайн байршлыг бодит байдал дээр нь тогтоож, тээврийн хэрэгсэл нэвтрүүлж, туршилт хийсэн.		
9	1.1.9. Гаалийн хяналт, бүрдүүлэлт, лабораторийн үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлж, хилийн хяналт шалгалтад зарцуулах хугацааг бууруулах	Хилийн хяналт шалгалтад зарцуулах хугацаа 26-гаас доошгүй хувиар буурсан байна.	-	-	Гаалийн байгууллагын стратеги төлөвлөгөөний дагуу 2023 онд гаалийн бүрдүүлэлтэд цаг хугацааны хэмжилт хийхээр төлөвлөн ажиллаж байна. Гаалийн байгууллагыг хилийн мэргэжлийн хяналтын байгууллагатай нэгтгэсэнтэй холбогдуулан гаалийн болон хорио цээрийн хяналт шалгалтыг уялдуулах, давхардлыг арилгах зориогоор ГЕГ-ын даргын 2022 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн А/19 дүгээр тушаалаар “Улсын хилээр нэвтрүүлэх зорчигч, бараа, тээврийн хэрэгсэлд хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын хяналт хэрэгжүүлэх түр заавар”-ыг баталсан. Энэ зааврын дагуу Гаалийн хяналт, бүрдүүлэлтийн CAIS программд гаалийн хорио цээрийн ГУБ системээс хуваарилах, ургамал, амьтан	СЯ	70.0

					хүнс зэрэг олон төрлийн бараанд эрсдэлийн түвшний дагуу зөвхөн 1 байцаагч томилогддог байхаар зохицуулалт хийж хүний оролцоог багасгасан. 2022 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн А21 дугаар тушаалаар Ажлын хэсэг байгуулж, экспорт импортын гэрчилгээ олгох журмыг шинэчилж, гэрчилгээг цахимаар олгох, худалдаа эрхлэгчдээс шаардах бичиг баримтын тоог бууруулах чиглэлээр ажиллаж байна. 2022 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн А21 дугаар тушаалаар лабораторийн үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр ажлын хэсэг байгуулан ажиллаж байна. ГЕГ-ын дэд даргын 2022 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр баталсан Эрх зүйн актын хэрэгжилтийг судлах ажлын хэсгийн удирдамжийн дагуу УБГГ, УХШИГГ-т ажиллаж, ГЕГ-ын даргын 2022 оны 19 дүгээр тушаалаар батлагдсан “Улсын хилээр нэвтрүүлэх зорчигч, бараа, тээврийн хэрэгсэлд хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын хяналт хэрэгжүүлэх түр заавар”-ын хэрэгжилт, лабораторийн дээж авах үйл ажиллагаатай танилцаж, хүндрэлтэй асуудлуудын талаар санал солилцож, гаалийн ерөнхий газраас хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар танилцуулга хийсэн. Ажлын хэсгээс цаашид үйл ажиллагааг сайжруулах, худалдааг хөнгөвчлөх санал боловсруулсан. Дээрх саналд үндэслэн АХБ-аас хэрэгжүүлж байгаа “Ургамал, малын эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлыг хангах арга хэрэгслийг сайжруулах” /МОН-3313/ төслийн хүрээнд “Ургамал, малын эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлын хяналтын удирдлагын систем”-ийг гаалийн автоматжуулсан мэдээллийн системтэй уялдуулан хөгжүүлэх 12 төрлийн программын ажлын даалгавар боловсруулж, төслийг гүйцэтгэгч Интерактив ХХК-д өгсөн бөгөөд сайжруулсан программаар эрсдэлийн удирдлагын системийн боловсронгуй болгож, гараар хийгдэж байгаа бичиг цаасыг цахимжуулж, хяналт шалгалтын тоог багасган худалдааг хөнгөвчлөхөөр ажиллаж байна. Хорио цээрийн хяналт шалгалтыг гаалийн байгууллагад нэгтгэж, үйл ажиллагааг программчилсантай 3 дугаар сарын 15-ны өдрөөс 9 дүгээр сарын 15-ны өдрийн хооронд хийсэн гаалийн бүрдүүлэлтийн үйл ажиллагаанд 11 дүгээр сард дүн шинжилгээ хийж, хорио цээрийн хяналт шалгалтын асуудал хариуцсан ГУБ нарын ачааллыг тодорхойлон, хяналт шалгалт хийх шаардлагагүй болон хяналтын чиглэл өөрчлөх БТКУС-ын ангиллын кодыг тодорхой болгож, өөрчлөлтүүдийг программд оруулахаар ажиллаж байна.		
10	1.1.10. Уул уурхайн бүтээгдэхүүнийг тээвэрлэх, хилээр нэвтрүүлэх тээврийн зохион байгуулалтыг боомт тус бүрээр төлөвлөх	Уул уурхайн бүтээгдэхүүний экспортод зарцуулах хугацаа буурсан байна.	-	-	Уул уурхайн бүтээгдэхүүн тээвэрлэх, хилээр нэвтрүүлэх тээврийн зохион байгуулалтын оновчтой схемийг хилийн боомт дээр төлөвлөх зорилгоор Хөгжлийн хөтөч-Дэд бүтэц төслийн нэгж Шивээхүрэн, Ханги, Бургастай, Булган, Цагааннуур, Ханх, Ульхан, Баянхошуу, Хавирга, Сүмбэр гэсэн 10 боомтыг хөгжүүлэх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний зураг төсөв, ТЭЗҮ боловсруулах ажлыг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийлгэхээр зураг төслийн компаниудын дунд тендер зарлаж, шалгаруулан, зураг төслийн ажлыг эхлүүлсэн. Үүний дагуу Хөгжлийн хөтөч-Дэд бүтэц төслийн нэгж болон дээрх боомтуудын зураг төсвийн ажлыг гүйцэтгэж байгаа компаниудын ажилтнууд, ГЕГ-ын холбогдох мэргэжилтнүүд оролцсон хамтарсан хуралдааныг 15 удаа зохион байгуулж, зураг төсвийн ажлын даалгаврын саналыг боловсруулж өгч, зураг төслийн явцтай тухай бүр танилцан саналаа өгч, боомтын үйл ажиллагааны зарчимд нийцүүлэн сайжруулж ажилласан. Энэ ажлын үр дүнд эхний хагас жилд багтаан Шивээхүрэн, Бургастай, Цагааннуур, Ханх, Ульхан, Баянхошуу, Хавирга, Сүмбэр боомтуудын ерөнхий	СЯ	90.0

					төлөвлөгөөний эскиз зураг төслийг боловсруулж дуусган батлуулсан. Булган, Ханги боомтын ерөнхий төлөвлөгөөний эскиз зураг төслийн ажил бүрэн дуусаагүй байна.		
Зорилт 1.2.Хилийн боомтуудыг төмөр зам болон хатуу хучилттай авто замаар үе шаттайгаар бүрэн холбон, тээвэр, логистикийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэн ачаа тээврийн урсгалыг сайжруулж, цаашид транзит улс болох суурь нөхцөлийг бүрдүүлнэ.							
11	1.2.1.Боомт хүртэлх зам харилцааг сайжруулж, тээврийн хүчин чадлыг нэмэгдүүлэх	2650 км хатуу хучилттай авто зам, 4600 км төмөр зам барина. Шинээр 11 боомтыг авто замаар, 4 боомтыг төмөр замаар холбоно.	-	-	Хил дамнасан байгууламж байгуулахад хөрш улстай зөвшилцөх шаардлагатай бөгөөд 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр цахим хэлбэрээр зохион байгуулагдсан Монгол, Хятадын хилийн боомт, тэдгээрийн дэглэмийн тухай Засгийн газар хоорондын хэлэлцээрийн хэрэгжилтийг хангах Гадаад харилцааны яамд хоорондын Газрын даргын түвшний VIII удаагийн уулзалтаар AGV тээврийн систем, дүүжин тээврийг аль боомтод хэрэгжүүлэх боломжийн талаар санал солилцсон. Хятадын талаас AGV тээврийн системийг хилийн Гашуунсухайт-Ганцмод боомтод, дүүжин тээврийг Ханги-Мандал боомтод байгуулах асуудлыг судлан үзэхээ мэдэгдсэн. Мөн Хятадын "СИ АР АР СИ" компанийн агаарын төмөр замын танилцуулга уулзалтыг 2022 оны 01 дүгээр сарын 28-ны өдөр зохион байгуулсан. "Тавантолгой төмөр зам" ХХК нь "Чайна Энержи Интернэйшнл Девелопмент" ХХК, "Баошэн төмөр зам" ХХК-тай цахим уулзалтыг 2 дугаар сарын 9-ний өдөр зохион байгуулж, Монгол улсын Засгийн газраас баримталж буй бодлогыг танилцуулж, тухайн тохиролцсон цэгээр холбох байгууламжийг барих, цариг гэх мэт асуудлыг хэлэлцэв. Хятадын тал холбогдох байгууллагадаа уламжилж тухайн эрх хэмжээнд хамаарах шийдвэрийг дээд түвшинд танилцуулахаар болсон. Монгол Улсын Сангийн сайд Б.Жавхлан 2022 оны 2 дугаар сарын 15-ны өдөр БНХАУ-ын Үндэсний хөгжил шинэтгэлийн хорооны удирдлагуудтай дээрх асуудлаар уулзалт зохион байгуулж, хурлаас гарсан шийдвэрийн дагуу "Тавантолгой төмөр зам" ХХК нь "Чайна Энержи Интернэйшнл Девелопмент" ХХК-тай хийх цахим уулзалтыг 2022 оны 2 дугаар сарын 21-ний өдөр зохион байгуулсан.	ЗТХЯ	50.0
12	1.2.2. Үндэсний төмөр замын сүлжээг өргөтгөж, цаашид транзит улс болох суурь нөхцөлийг бүрдүүлнэ.	Баруун болон зүүн босоо тэнхлэгийн төмөр замын төслүүдийг эрчимжүүлнэ.	-	-	Арцсуурь-Шивээхүрэн-Нарийнсухайт чиглэлийн төмөр зам, Бичигт-Хөөт, Хөөт-Чойбалсан чиглэлийн төмөр замыг "Монголын төмөр зам" ТӨХК хариуцан гүйцэтгүүлэх талаар Засгийн газрын 2022 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн хуралдаанд танилцуулж, 5 дугаар тэмдэглэл гарсан. Засгийн газрын 2022 оны 105 дугаар тогтоолоор Арцсуурь-Нарийнсухайт-Шивээхүрэн, Сайншанд-Баруун-Урт-хөөт чиглэлийн төмөр замуудыг зураг төсөл боловсруулах-барих-ашиглах-шилжүүлэх концессын төрлөөр шууд гэрээ байгуулахаар шийдвэр гарсан. Засгийн газрын 2022 оны 116 дугаар тогтоолоор Зүүн, баруун босоо тэнхлэгийн төмөр замын төслийг хэрэгжүүлэх тусгай зориулалтын компаниудыг байгуулах, төслийг хэрэгжүүлэх хөрөнгө оруулж, хамтран ажиллах компаниудыг сонгох ажлыг зохион байгуулах талаар шийдвэр гарсан. Энэ тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Зам, тээврийн хөгжлийн сайдын 2022 оны А/88 дугаар тушаалаар Ажлын хэсэг байгуулагдсан. Мөн "Монголын төмөр зам" ТӨХК-ийн гүйцэтгэх захирлын 2022 оны А/73 дугаар тушаалаар Дэд ажлын хэсэг байгуулан ажиллаж байна. Арцсуурь-Шивээхүрэн-Нарийнсухайт чиглэлийн төмөр зам, Бичигт-Хөөт, Хөөт-Чойбалсан чиглэлийн төмөр замын төсөлд оролцох хүсэлтэй ААН-ийг сонгох зарыг олон нийтэд зарлан ажиллаж байна.	ЗТХЯ	30.0
13	1.2.3. Ази-Европыг холбосон бүс нутгийн логистикийн төв байгуулж, дамжин өнгөрөх ачаа тээврийг нэмэгдүүлэх	Дамжин өнгөрөх ачаа тээврийн хэмжээ нэмэгдсэн байна.	-	-	Хөшигийн хөндийн тээвэр логистикийн ерөнхий төлөвлөгөөг Барилга, хот байгуулалтын яамнаас захиалан боловсруулж байна. ТЭЗҮ боловсруулах, санхүүжилтийг шийдвэрлэх асуудлууд хүлээгдэж байна.	ЗТХЯ /ИНБХЗГ/	30.0

Зорилт 1.3.Монгол Улсын агаарын зайн зохион байгуулалт, агаарын замын ашиглалтыг сайжруулан дамжин өнгөрөх агаарын хөлгийн тоог нэмэгдүүлж, агаарын тээврийн либералчлалыг үе шаттайгаар үргэлжлүүлэх замаар ачаа тээврийн зангилаа төвийг бий болгож, аялал жуулчлалын салбарыг дэмжинэ.								
14	1.3.1. Агаарын замын байнгын ажиллагаатай олон улсын боомтын тоог нэмэгдүүлж, карго тээвэр, аялал жуулчлалыг хөгжүүлэх	Орон нутгийн нисэх буудлын хүчин чадлыг сайжруулж, 6 нисэх буудлыг зорчигч, ачаа тээврийн харилцааны хилийн олон улсын боомт болгосон байна.	-	-	1.Засгийн газрын 2013 оны 317 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалт”-д Ховд, Чойбалсан, Мөрөн, Хатгал, Дэглий цагаан, Хархорин, Хужирт нисэх буудлуудын хүчин чадлыг нэмэгдүүлэх төслийг "шинэчлэн сайжруулах-ашиглах-шилжүүлэх" төрлөөр оруулах асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх хүсэлт 2022 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 01/133 тоотойр ТХААГ-т, 2022 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 01/875 тоотойр ЭЗХЯ-нд тус тус хүргүүлэн, Засгийн газрын 2022 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн ээлжит хуралдаанаар орон нутгийн нисэх буудлын хүчин чадал, ашиглалтыг сайжруулах төслийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх, түүнчлэн Дэглий цагаан, Өндөрхаан нисэх буудалд хилийн агаарын замын олон улсын боомт байгуулах, нисэх буудлын ашиглалтыг сайжруулах арга хэмжээ авахаар шийдвэрлэсэн. Засгийн газрын 2022 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн ээлжит хуралдаанаар орон нутгийн нисэх буудлуудыг өргөтгөхөд шаардлагатай хөрөнгийг шийдвэрлэх арга зам, эх үүсвэрийн талаар Сангийн яам, ЭЗХЯ-тай хамтран судалж, саналаа Засгийн газрын хуралдаанд дахин танилцуулахыг даалгасны дагуу ИНЕГ Мөрөн, Ховд, Чойбалсан, Гурвансайхан, Дэглий цагаан, Өндөрхаан, Хатгал, Хужирт, Хархорин нисэх буудлуудын хүчин чадлыг сайжруулах төслийн хөрөнгө оруулалт, борлуулалт, зардал, үр ашгийн тооцоолол, Өлгий, Дэлүүнболдог болон бусад нисэх буудлуудын цаашдын ашиглалтыг сайжруулах судалгаа хийж, тайлан, танилцуулгыг 2022 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн 01/1353 тоот албан бичгээр ирүүлсэн бөгөөд Зам, тээврийн хөгжлийн яамнаас тооцооллыг хянаж байна. 2. Засгийн газрын 2010 оны 344 дүгээр тогтоолоор Ховд, Мөрөн, Чойбалсан, Гурвансайхан нисэх буудлыг зорчигч, ачаа тээврийн харилцааны хилийн олон улсын боомт байхаар тогтоосон. “Дэглий цагаан” нисэх буудлын хилийн хяналтын бүсийг шинээр тогтоосон бөгөөд Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр хүлээгдэж байна. “Ховд”, “Мөрөн” нисэх буудлуудыг нисэхийн мэдээллийн эмхэтгэлээр 2022 оны 05 дугаар сарын 20-ны өдрөөс Олон улсын нисэх буудлаар зарлаж хүчин төгөлдөр болсон. Одоогийн байдлаар нисэхийн мэдээллийн эмхэтгэлээр “Чингис хаан”, “Буянт-Ухаа”, “Чойбалсан” “Ховд”, “Мөрөн” “Гурвансайхан” гэсэн 6 нисэх буудал олон улсын статустай байна.	ЗТХЯ /ИНБХЗГ	70.0	
Зорилт 1.4.Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд тулгуурлан эдийн засгийн чөлөөт бүс, хуурай боомтуудыг үе шаттайгаар байгуулах замаар худалдааны эргэлтийг нэмэгдүүлнэ.								
15	1.4.1. Хилийн зарим боомтыг нэмж чөлөөт бүс болгон хөгжүүлэх асуудлыг судалж, шийдвэрлүүлэх	Чөлөөт бүс шинээр нэмж байгуулсан байна.	-	-	Хилийн боомтын суурь судалгаа, байгаль орчны нарийвчилсан үнэлгээ, техник эдийн засгийн үнэлгээ, нарийвчилсан зураг төсөл боловсруулах ажлын хүрээнд зарим боомтод чөлөөт бүс байгуулах боломжийн талаар дүгнэлт гаргахаар ажиллаж байна. Чөлөөт бүс байгуулах асуудал нь хөрш орны бодлоготой уялдуулан харилцан тохиролцсон байх шаардлагатай байна. Иймд ОХУ болон БНХАУ-ын урт хугацааны хөгжлийн бодлогыг судлан хилийн боомт болон чөлөөт бүсийн төлөвлөлтийг уялдуулах чиглэлээр судалж байна. Улсын Их Хурлын чуулганы 2022 оны 04 дүгээр сарын 07-ны нэгдсэн хуралдаанаар Хөшигийн хөндийн эдийн засгийн чөлөөт бүс байгуулах тухай асуудлыг хэлэлцүүлж, 10 дугаар тогтоолоор батлуулав. Хөшигийн хөндийн Эдийн засгийн чөлөөт бүсийн ерөнхий төлөвлөгөөний зураг төслийн ажил 80.0 хувьтай байна. Засгийн	ЭЗХЯ, ХБҮХ	100.0	

					газрын 2022 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн хуралдаанаар Цагааннуур чөлөөт бүсийг байнгын ажиллагаанд шилжүүлэх Засгийн газрын тогтоолын төслийг хэлэлцүүлж дэмжигдсэн.		
16	1.4.2. Зарим боомтыг түшиглэн хил орчмын аялал жуулчлалыг хөгжүүлэх	Зургаан боомтыг аялал жуулчлалын боомт болгон хөгжүүлж, боомтын зэрэглэлийг нэмэгдүүлсэн байна.	-	-	ГХЯ: Хил орчмын аялал жуулчлалыг хөгжүүлэх, зорчих нөхцөлийг хөнгөвчлөхөд анхаарч, хил орчмын нутгаар аялж жуулчлах, зорчих иргэдэд "Хил орчмын аялал жуулчлалаар ирэх бүлэг жуулчин (КЗ) ангиллын виз олгох эрх зүйн үндэс бүрдсэн. Энэ хүрээнд, Монгол Улс, БНХАУ-ын БОАЖЯ-тай хамтран ажиллаж, аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагуудыг сонгон шалгаруулах, аяллын маршрут, хөтөлбөрийг харилцан тохиролцохоор бэлтгэж байна. ЭЗХЯ: Монгол Улсын Ерөнхий сайдын 2022 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн 04 дүгээр албан даалгаврын 8.2-т Чөлөөт бүсийн үйл ажиллагааг эрчимжүүлэх бүс нутгийн онцлогт тохирсон аялал жуулчлалын хөтөлбөрийг боловсруулж, төсөл хэрэгжүүлэх боломжийг судалж танилцуулахаар тусгагдсан. Үүний дагуу зургаан боомтыг /Замын-Үүд, Ханги, Гашуунсухайт, Шивээхүрэн, Хавирга, Ульхан/ аялал жуулчлалын боомт болгон хөгжүүлж, боомтын зэрэглэлийг нэмэгдүүлэхээр ажиллаж байна. Хил орчмын аялал жуулчлалыг хөгжүүлэх хүрээнд Сүмбэр боомтыг байнгын ажиллагаатай, Даян боомтын олон улсын зэрэглэлтэй болгох, Сүмбэр, Боршоо, Даян боомтуудын аялал жуулчлалд шаардлагатай дэд бүтэц, бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэх, хил орчмын жуулчдын авто машинтайгаа аялах боломжийг нэмэгдүүлэх талаар судалж байна. Аялал жуулчлалын салбарын орлогыг нэмэгдүүлэх чиглэлээр авах арга хэмжээний тухай Засгийн газрын тогтоолын төсөлд тусгахаар ажиллаж байна. Мөн Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2022 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн А/384 дугаар тушаалаар байгуулагдсан "Хил орчмын аялал жуулчлалын хөтөлбөр болон тур оператор компанид тавих шаардлагыг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг"-ийн гишүүнээр ажиллаж хилийн боомтын бодлого төлөвлөлт, хөрш орнуудын хилийн боомт, ялангуяа аялал жуулчлал чиглэлээр авч хэрэгжүүлэхээр төлөвлөсөн боомтууд, аяллын хөтөлбөрийн талаар мэдээлэл өгч хамтран ажилласан. Монгол Улсын Ерөнхий сайдын 2022 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 190 дугаар захирамжаар байгуулагдсан "Өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх асуудлыг судалж, арга хэмжээ авах хэмжээний санал боловсруулан танилцуулах үүрэг бүхий ажлын хэсэг"-т гишүүнээр ажиллаж хил орчмын аялал жуулчлал болон өвлийн аялал жуулчлалтай холбоотой саналаа өгч ажилласан.	ГХЯ, ЭЗХЯ	70.0
17	1.4.3. "Хуурай боомтын тухай" Ази, номхон далайн эдийн засаг, нийгмийн комиссын гишүүн улсын Засгийн газрын хоорондын 2013 оны хэлэлцээрийн дагуу Алтанбулаг, Замын-Үүд, Сайншанд, Улаанбаатарт хуурай боомтуудыг үе шаттайгаар байгуулах	Олон улсын худалдаанд тээвэрлэж байгаа барааг ачиж буулгах, хадгалах, холбогдох хяналт шалгалт, үзлэг хийх нэг ба түүнээс дээш тээврийн горимоор далайн боомттой холбогдсон логистикийн төв байгуулсан байна.	-	-	Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн хуралдааны 34 дүгээр тэмдэглэлд Хуурай боомтын боомтын асуудал хариуцсан нэгж байгуулахтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий сайдын 2018 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн 104 дүгээр захирамжаар байгуулсан Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг шинэчлэх, олон улсын хуурай боомт байгуулах үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж танилцуулахыг даалгасны дагуу Эдийн засаг, хөгжлийн яамнаас холбогдох яам, төрийн байгууллага, төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодод тус ажлын хэсэгт ажиллах төлөөллийн нэр ирүүлэхийг хүссэн албан тоотыг хүргүүлсэн бөгөөд байгууллагуудаас саналыг авч нэгтгэн "Ажлын хэсэг байгуулах тухай" Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулсан. Олон улсын хуурай боомтын асуудал хариуцсан ажлын хэсгийн үйл	ЗТХЯ	30.0

					ажиллагааны төлөвлөгөө боловсруулж байгаа бөгөөд олон улсын хуурай боомт байгуулах эрх зүйн үндсийг бүрдүүлэх, хөрөнгө оруулалтын асуудлыг судалж санал боловсруулах, олон улсын хуурай боомт байгуулахад төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг хангах зэрэг ажлуудыг тусгахаар төлөвлөж байна.		
ХОЁР.ЭРЧИМ ХҮЧНИЙ СЭРГЭЛТ							
Зорилт 2.1.Эрчим хүчний эх үүсвэр, дамжуулах, түгээх шугам сүлжээг шинээр барьж байгуулан хүчин чадлыг өргөтгөн нэмэгдүүлж, эрчим хүчний үйлдвэрлэл, хангамжийн найдвартай байдлыг дээшлүүлнэ.							
18	2.1.1. Тавантолгой 450 МВт-ын хүчин чадалтай дулааны цахилгаан станц, 220 кВ-ын өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах агаарын шугам барьж, өмнөд бүсийн стратегийн орд газрууд болон үйлдвэрлэл технологийн паркуудын эрчим хүчний хэрэглээг хангах	Жилд 3,150.0 сая кВт.ц цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх ба Оюутолгойн өсөн нэмэгдэх 2,242.5 сая кВт.ц хэрэглээ болон Тавантолгойн орд газрууд, бусад стратегийн ач холбогдол бүхий өмнөд бүсийн уул уурхайн төслүүдийн цахилгаан эрчим хүчний хэрэглээг дотоодоос хангасан байна	-	-	Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн хуралдаанаар ТТДЦС ТӨХХК-ийн хувь эзэмшлийн асуудлыг шийдвэрлэж, ЭТТ ХК-д 30.0 хувийг эзэмшүүлэх замаар хөрөнгө оруулалтын 30.0 хувийг шийдвэрлэсэн. Байгаль орчны үнэлгээ хийсэн зөвлөх компани төслийн БОННУ-г боловсруулж, орон нутгийн иргэд нийтийн хурлаар хэлэлцүүлэн үнэлгээний тайланг 2022 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, батлагдсан. Батлагдсан үнэлгээг БОАЖЯ-ны мэдээллийн санд байршуулсан. Тавантолгой ДЦС барих төслийн талбайг эзэмших 34044, 34045 дугаартай газар эзэмших гэрчилгээ гарсан. Оюутолгойн уурхайн эрчим хүчний хэрэглээг Монгол Улсын эрчим хүчний нэгдсэн сүлжээнээс хангах гэрээний хэлцлийг хийж, Оюу толгой ХК-тай цахилгаан эрчим хүчээр хангах урт хугацааны гэрээг 2022 оны 01 дүгээр сарын 26-ны өдөр байгуулсан. Мөн тус төслийн 30.0 хувийн хувьцаа эзэмшигч “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн зүгээс нүүрс баяжуулах үйлдвэрийн ус хангамжийн шугамын төлөвлөлтөд Тавантолгой дулааны цахилгаан станцын ус хангамжийн хэрэглээг нэмж тооцож, цахилгаан станцын усны хэрэглээг Загийн усны хоолой, Цагаан цавын усны орд,газраас хангахаар шийдвэрлэсэн. Тавантолгойн ДЦС-аас нийлүүлэх ЦЭХ-ний гарааны үнийн тарифын саналыг аргачлалын дагуу тооцож, ЭХЗХ-нд хүргүүлсэн. Эрчим хүчний сайдын тушаалаар “Цахилгаан эрчим хүч худалдах, худалдан авах гэрээ” байгуулах эрхийг “ДҮТ” ХХК, “ӨБЦТС” ТӨХК болон ТТДЦС ТӨХХК-ийн гүйцэтгэх захирлуудад олгосон ба захирлууд тушаал гарган Ажлын хэсэг байгуулан ажиллаж байна. Төслийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог ТНБД-ын 2021 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн А/32 тоот тушаалаар байгуулж, олон улсын нээлттэй тендерийг 2 удаа зарласан боловч, тендерт оролцсон компани тендерийн баримт бичгийн шаардлагыг хангаагүй. Хуулийн дагуу дараагийн шатны сонгон шалгаруулалтыг зохион байгуулахаар бэлтгэл ажлыг хангаж байна. Мөн төслийн бэлтгэл ажлын хүрээнд “Эрдэнэс тавантолгой” ХК-тай хувьцаа эзэмшигчдийн гэрээ, нүүрс нийлүүлэлтийн гэрээ байгуулагдсан. Хөрөнгө оруулалтын гэрээ, санхүүжилтийн гэрээний төслүүдэд 2 талаас хамтран ажиллаж байна.	ЭХЯ	50.0
19	2.1.2. Чойбалсангийн дулааны цахилгаан станцын хүчин чадлыг 50 МВт-аар өргөтгөж, зүүн бүсийн уул уурхай, аялал жуулчлалын төслүүдийн эрчим хүчний хэрэглээг хангах	Зүүн бүсийн өсөн нэмэгдэж байгаа цахилгаан эрчим хүчний хэрэглээ ба Дорнод, Сүхбаатар аймгийн сум, суурин газар, уул	-	-	Төсөл нийт 79.5 сая ам.доллараар хэрэгжих бөгөөд үүнээс Монгол Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 52 тэрбум төгрөг /19.5 сая ам.доллар/, Монгол Улсын Хөгжлийн банкны санхүүжилтээр 420 сая юань /60 сая ам.доллар/-аар санхүүжигдэнэ. Төслийг БНХАУ-ын “ТБЕА” ХХК гүйцэтгэж байна. 2022 оны барилга угсралтын ажлыг үргэлжлүүлэх 2022/Д-17 тоот "Эрчим хүчний барилга байгууламж барих ажил үргэлжлүүлэх	ЭХЯ	50.0

		уурхайн ордын баяжуулах, олборлох үйлдвэрүүд, аялал жуулчлалын цогцолборуудыг тасралтгүй, найдвартай эрчим хүчээр хангасан байна.			зөвшөөрлийн гэрчилгээ"-г 03 дугаар сарын 29-ний өдөр олгосон. Хил гаалийн хорио цээрийн улмаас 2020-2021 онуудад барилга угсралтын ажлыг хэвийн гүйцэтгэх боломжгүй хязгаарлагдмал нөхцөл байдалд ажиллаж, төслийн хэрэгжилт удааширч гэрээт хугацаандаа хэрэгжих боломжгүй болсон тул гүйцэтгэгчтэй байгуулсан ЭХА-012/2019 тоот гэрээг сунгасан. Төслийн барилга угсралтын ажлын гүйцэтгэл 51.0 хувь, тоног төхөөрөмжийн үйлдвэрлэл захиалга 96.0 хувьтай байна.		
20	2.1.3. Амгалан дулааны станцыг өргөтгөн Улаанбаатар хотын зүүн бүсийн дулааны хэрэглээний өсөлтийг хангах	Улаанбаатар хотын зүүн бүсэд Баянзүрх дүүрэг, Улиастай орчмын дахин төлөвлөлтийн хүрээнд бий болох орон сууцны шинэ хорооллуудыг дулаанаар хангасан байна	-	-	Амгалан дулааны станцыг 116 МВт (100 Гкал/ц) хүчин чадалтай нэг зуухаар өргөтгөх ТЭЗҮ хийгдсэн. Төслийн барилга угсралтын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, БНХАУ-ын “Хунан индустриал экүйпмент инсталеишн” ХХК-тай 2022 оны 06 дугаар сарын 07-ны өдөр түлхүүр гардуулах нөхцөлтэй барилга угсралтын ажлын гэрээг байгуулсан. Уг гэрээний дагуу гүйцэтгэгч компаниас зураг төслийн ажлыг хэсэгчилсэн байдлаар хийж байна. Төслийн санхүүжилтийг шийдвэрлэх ажлын хүрээнд Хөгжлийн банкны охин компани болох “Ди Би Эм лизинг” ХХК-тай хамтран санхүүгийн түрээсийн судалгааг хийж гүйцэтгэн, дуусгасан. “Ди Би Эм лизинг” ХХК-ийн зүгээс төслийн санхүүжилтийн асуудлыг Хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөлөөр хэлэлцүүлж, зөвшилцсөн. Хөгжлийн банкны охин компани “Ди Би Эм лизинг” ХХК, Амгалан ДС, гүйцэтгэгч компанитай 2022 оны 10 дугаар сарын 26-ны өдөр уулзалт зохион байгуулж, төслийн 85.0 хувийн санхүүжилт болох санхүүгийн түрээсийн гэрээ байгуулах бэлтгэл хангагдсан. Гэрээг холбогдох байгууллагуудаар албажуулж байна.	ЭХЯ	70.0
21	2.1.4. Дулааны 3 дугаар цахилгаан станцын дэд бүтцийг түшиглэн 325 МВт-ын хүчин чадалтай шинэ эх үүсвэр барих	Станцын хүчин чадал цахилгаанаар 400 МВт, дулаанаар 370 Гкал/цагаар нэмэгдэж, Улаанбаатар хотын төвийн дүүргүүдэд өсөн нэмэгдэж байгаа дулаан, цахилгааны эрчим хүчний хэрэглээг хангасан байна.	-	-	“ДЦС-3” ТӨХК болон Интер РАО Экспорт компанийн хооронд байгуулсан хамтран ажиллах санамж бичгийн дагуу Интер РАО Экспорт компанийн зүгээс төслийн ТЭЗҮ-ийг 2022 оны 06 дугаар сард багтаан дуусгаж Монголын талд хүлээлгэх өгөхөөр байсан боловч ОХУ болон Украин Улс хооронд үүссэн геополитикийн нөхцөл байдлаас шалтгаалан 8 дугаар сарын 29-ний өдөр “ДЦС-3” ТӨХК-д хүлээлгэн өгсөн. Төсөл хэрэгжих талбайн газрын асуудлаар БХБЯ болон НЗД-д албан хүсэлтийг хүргүүлж, ГЗБГЗЗГ болон НЗД-аас ирүүлсэн хариу албан бичгийн дагуу “ДЦС-3” ТӨХК-д чиглэл хүргүүлсэн. Нийслэлийн 2023 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний төсөлд газрын асуудлыг тусгуулах саналыг Нийслэлийн Засаг даргад 2022 оны 10 дугаар сарын 25-ны өдөр хүргүүлсэн. ОХУ-ын талаас ирүүлсэн төслийн ТЭЗҮ-ийг судлах хүрээнд Интер РАО-Экспорт, “ДЦС-3” ТӨХК хооронд 2022 оны 10 дугаар сарын 03-ны өдөр техникийн асуудлаар, 2022 оны 10 дугаар сарын 24-25-ны өдрүүдэд ЭХЯ-ны удирдлагууд, “ДЦС-3” ТӨХК-ийн төлөөлөл болон Интер РАО Экспорт компанийн төлөөлөлтэй уулзалт хийж, санал солилцсон. Монгол-Оросын Худалдаа, ЭЗ, ШУ, техникийн хамтын ажиллагааны ЗГХКХ-тай холбогдуулан төслийн талаар Засгийн газрын хуралдаанд танилцуулж, хуралдааны 54 дүгээр тэмдэглэлийн дагуу төслийн санхүүжилтийн асуудлаар ОХУ-ын Сангийн яаманд зээлийн хүсэлтийг уламжилж өгөх хүсэлтийг ЭЗХЯ-д 2022 оны 11 дүгээр сарын 10-ны хүргүүлсэн. Мөн ГХЯ-аар дамжуулан ОХУ-ын Эрчим	ЭХЯ	30.0

					хүчний сайдад Засгийн газар хоорондын хэлэлцээрийн төслийг ирүүлэх хүсэлтийг 2022 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр хүргүүлсэн. Төслийн явц гэрээ байгуулах түвшинд хүрээгүй байна.		
22	2.1.5. Багахангайн 300 МВт-ын цахилгаан станцыг барьж, нийслэл Улаанбаатар хотод хийх шинэ эко, ногоон бүтээн байгуулалтын төслүүдийн эрчим хүчний хэрэглээг хангах	Жилд 1,855.9 сая кВт.ц цахилгаан эрчим хүч үйлдвэрлэж, төвийн эрчим хүчний нэгдсэн сүлжээнд нийлүүлэн, нийслэл Улаанбаатар хотод хэрэгжүүлэх цахилгаанаар ажиллах эко, ногоон төслүүдийг бүрэн хангах техникийн боломжийг бүрдүүлсэн байна.	-	-	Төв аймгийн Баянжаргалан сумын нутаг (Багахангай дүүрэг)-т 300 МВт-ын цахилгаан станцын төслийг хувийн хөрөнгө оруулалтаар “Цэцэнс майнинг энд энерги” ХХК хэрэгжүүлж байна. Төслийн талбайд барилга угсралтын ажил эхэлсэн. 2024 онд ашиглалтад оруулахаар төлөвлөн ажиллаж байна. Энэхүү төслийн хөрөнгө оруулалтын гэрээ 2018 онд байгуулагдсан бөгөөд бэлтгэл бүрэн хангагдсанаар барилгын ажил эхлээд байна.	ЭХЯ	100.0
23	2.1.6. Эрдэнэбүрэн-Мянгад-Улиастайн 220 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц барьж Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станцын үйлдвэрлэх цахилгаан эрчим хүчийг бүс нутгийн сүлжээнд нийлүүлэх	Баруун бүсийн эрчим хүчний систем, Алтай-Улиастай эрчим хүчний системийн үйлчлэх хүрээний баруун 5 аймгийн эрчим хүчний хангамж, хүртээмжтэй байдал дээшилсэн байна.	-	-	Төслийн ТЭЗҮ, зураг төсөл боловсруулагдсан. ЦДАШ-ын 468.3 км трассыг баталгаажуулж орон нутгийн газрын албаны мэдээллийн санд бүртгүүлсэн. Санхүүжилтийн асуудлаар АХБ-тай хамтран ажиллаж, АХБ-аас санхүүжих төслийн шаардлагыг хангасан талаар мэдэгдэж, байгаль орчин, нийгмийн нөлөөллийн хөндлөнгийн үнэлгээг нарийвчлан хийж байна. АХБ-аас 2022-2023 онд авч ашиглах эх үүсвэрээс 140.0 сая ам.доллартой тэнцэх санхүүжилтийг Эрдэнэбүрэн-Мянгад-Улиастай чиглэлийн 220 кВ-ын 2 хэлхээт 468.3 км урттай ЦДАШ, дэд станц барих төсөлд хуваарилахаар төлөвлөж, санхүүжилтийн ерөнхий хөтөлбөрт тусган зээлийн хэлэлцээрт 2022 оны 8 дугаар сарын 26-ны өдөр АХБ болон Сангийн сайд гарын үсэг зурсан. АХБ-ны зүгээс төслийн зээлийн гэрээг 2023 оны 09 дүгээр сард батлуулах төлөвлөгөөтэйгөөр ажиллаж байна.	ЭХЯ	70.0
24	2.1.7. Төв аймгийн Хөшигийн хөндийд шинэ дагуул хотууд болон эдийн засгийн чөлөөт бүсийг байгуулж хөгжүүлэхэд шаардлагатай дулаан, цахилгаан хангамжийн эх үүсвэрийг шийдвэрлэх	Шинэ дагуул хотын төлөвлөлтийн үе шатуудтай уялдуулан цахилгаан дулааны эх үүсвэрийг ашиглалтад оруулсан байна.	-	-	Хөшигийн хөндийн дагуул хотын цахилгаан, дулаан хангамжийн эх үүсвэрийг шийдвэрлэх хүрээнд “Улаанбаатар хотын шинэ дагуул хотуудыг түшиглэн баригдах дулаан, цахилгааны 5 дахь эх үүсвэрийн ТЭЗҮ боловсруулах” зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг БХБЯ-аас сонгон шалгаруулж, 3-н талт гэрээ байгуулагдсан. Шинэ Зуунмод хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө шинэчлэгдсэнтэй холбогдуулан эх үүсвэрийн ТЭЗҮ боловсруулах ажил хүлээгдсэн бөгөөд тус ТЭЗҮ-ийн дунд шатны тайлан боловсруулах ажил хийгдэж байна. БХБЯ-аас Төв аймгийн Хөшигийн хөндий шинэ хотуудын цахилгаан хангамжийн техникийн нөхцөлийн хүсэлт ирүүлсний дагуу эрчим хүчний нэгдсэн сүлжээнээс цахилгаан эрчим хүчээр хангах горимын тооцоог хийж, тухайн байршилд баригдах Аеро сити, Тээвэр логикийн нэгдсэн төв, Их, бага Майдар хотуудын цахилгаан хангамжийн техникийн нөхцөлийг Эрчим хүчний яамнаас олгосон. Тус техникийн нөхцөлийн дагуу 220 кВ-ын 2 хэлхээт “Сонгино-Сэргэлэн” цахилгаан дамжуулах агаарын шугам, 220/110/35 кВ-ын 2х125 МВА хүчин чадалтай “Сэргэлэн” дэд станц, 110 кВ-ын 2 хэлхээт “Сэргэлэн-Аеросити” цахилгаан дамжуулах агаарын шугам, 110/35/10 кВ-ын 2х40 МВА хүчин чадалтай “Аеросити” дэд	ЭХЯ	70.0

					станцуудын ажлын зураг төсөв хийгдсэн буюу төлөвлөгдсөн ЦДАШ, дэд станцуудын зураг төсвүүд хийгдсэн. Эрчим хүчний нэгдсэн сүлжээнээс Хөшигийн хөндийн эдийн засгийн чөлөөт бүсийн эхний ээлжийн барилга байгууламжийг цахилгаан эрчим хүчээр хангах горимын тооцоог хийж, цахилгаан хангамжийн техникийн нөхцөл, ажлын зураг төсөл боловсруулах даалгаврыг Эрчим хүчний яамнаас олгосон. Олгосон техникийн нөхцөл, ажлын зураг төсөл боловсруулах даалгаврын дагуу БХБЯ-наас улсын төсвийн хөрөнгөөр баригдаж буй 110/35/10 кВ-ын "Шинэ Зуунмод" дэд станцаас 35 кВ-ын 2 хэлхээ цахилгаан дамжуулах агаарын шугам, 35/10 кВ-ын 2х10 МВА хүчин чадалтай дэд станцын дэд станцуудын ажлын зураг төсөв хийгдсэн. Үүний дагуу БХБЯ-аас гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, барилга угсралтын ажил эхэлсэн.		
Зорилт 2.2.Сэргээгдэх эрчим хүчийг зохистой харьцаагаар хөгжүүлэн усан болон хуримтлуурын станц барьж, эрчим хүчний нэгдсэн системийн найдвартай, тогтвортой байдлыг хангана.							
25	2.2.1.Эрдэнэбүрэнгийн 90 МВт-ын усан цахилгаан станц барьж баруун бүсийн эрчим хүчний хэрэглээг бүрэн хангах	Жилд 366 сая кВт.цаг цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх хүчин чадалтай цахилгаан станцыг барьж, баруун бүсийн эрчим хүчний хэрэглээг хангасан байна.	-	-	Эрдэнэбүрэнгийн УЦС-ын төслийн барилга угсралтын ажлын гүйцэтгэгчээр "Power Construction Corporation of China Ltd болон POWERCHINA Chengdu Engineering Corporation limited" компанийн түншлэл шалгарч, 2021 оны 09 дүгээр сарын 17-ны өдрийн ЭХА-14/2021 дугаар түлхүүр гардуулах нөхцөлтэй гэрээг байгуулсан. Төслийн БОННУ-ний тайланг БОАЖЯ-ны Мэргэжлийн зөвлөлөөр батлуулсан. БНХАУ-ын ЭКСИМ банкттай Тусгайлсан зээлийн хэлэлцээр байгуулах ажлын хүрээнд тус банканд барилга угсралтын ажлын гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ, БОННУ-ний тайлан, тусгайлсан зээлийн хэлэлцээрийн төслийг хүргүүлж, банкттай 2022 оны 03 дугаар сарын 10-ны өдрөөс цахим уулзалтыг сар бүр тогтмол хийж байна. Уулзалтад СЯ, Монгол Улсаас БНХАУ-д суугаа ЭСЯ, ГХЯ болон ЭХЯ-ны төлөөллүүд оролцож, харилцан мэдээлэл солилцож, тулгамдсан асуудлыг шийдвэрлэхээр ажиллаж байна. Төслийг БНХАУ-ын стандартаар хэрэгжүүлэх, төслийн газар чөлөөлөлт, айл өрх, түүхийн дурсгалыг нүүлгэн шилжүүлэх, БОННУ-ний дүгнэлт, үнэ тариф, Эрдэнэбүрэн-Мянгад-Улиастай чиглэлийн ЦДАШ-ын талаар холбогдох мэдээллийг бэлтгэж хүргүүлсэн. Нөлөөлөлд өртөж буй Увс аймгийн Өмнөговь сумын 125, Баян-Өлгий аймгийн Баяннуур сумын 145 өрхийн биет бус сэтгэл санааны хохирлын нөхөн олговор олгох асуудлыг Засгийн газрын 2022 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, тогтоол гаргуулсан. Иргэдтэй байгуулах нүүлгэн шилжүүлэх гэрээ, нөхөн олговрын гэрээний төслийг Ховд, Баян-Өлгий, Увс аймгийн Засаг дарга нарт тус тус хүргүүлж, гэрээ байгуулах ажлыг эхлүүлсэн. Усан сан үүсэх 9,871.1 га талбайд 206 ширхэг түүх соёлын дурсгалын зүйлс өртөхөөр байгааг авран хамгаалах, малтлагыг 2022-2024 онд хийхээр төлөвлөж, 2022 онд шаардагдах төсвийг батлуулсан. Барилга угсралтын ажлын бэлтгэл ажлын хүрээнд гүйцэтгэгч компаниас төслийн талбарт ажиллаж, ажлын зурагт шаардлагатай мэдээлэл цуглуулах, геологи, геофизикийн судалгааны ажил хийгдэж байна. БУА-ын кэмпиог ЦЭХ-ээр хангах ЦДАШ-ын трассын ажил хийгдэж байна. Төсөлтэй холбоотойгоор УИХ-ын гишүүн Ч.Хүрэлбаатар, Ш.Адьяа нар нэг удаагийн үйлчлэл бүхий "Нөхөн олговор олгох тухай" хуулийн төслийг санаачлан ЗГ-т танилцуулсан.	ЭХЯ	50.0
26	2.2.2. Төвийн эрчим хүчний нэгдсэн сүлжээнд 160 мВт.ц багтаамжтай	Төвийн бүсийн эрчим хүчний системд давтамж,	-	-	АХБ-тай байгуулсан санхүүжилтийн ерөнхий хөтөлбөрт 2020 оны 02 дугаар сард нэмэлт өөрчлөлт орж, УИХ-аас соёрхон баталснаар уг төслийн санхүүжилт шийдвэрлэгдсэн. АХБ-тай "Эрчим хүчний	ЭХЯ	70.0

	цэнэг хуримтлуурыг ашиглан нэгдсэн сүлжээний оргил ачааллыг тохируулах боломжийг бүрдүүлэх	хүчдэл тохируулах туслах үйлчилгээг үзүүлэх, эрчим хүчний чанарын үзүүлэлтийг сайжруулах, системийн тогтвортой байдлыг хангах хуримтлуур ашиглалтад орсон байна.			сүлжээнд ашиглах том чадлын хуримтлуурын төсөл"-ийн зээлийн тусгайлсан гэрээнд 2020 оны 05 дугаар сарын 14-ний өдөр гарын үсэг зурсан. 2020 онд зөвлөх үйлчилгээний тендерийг зохион байгуулж, ХБНГУ-ын "RWE Technology International GmbH" компани болон Монгол Улсын "Мон-Энержи-Консалт" ХХК-ийн баг шалгарч, 2021 оны 06 дугаар сарын 25-нд гэрээ байгуулсан. Байгаль орчны мониторинг хийх, жендэрийн чиглэлээрх ажлуудыг хэрэгжүүлэх компаниудыг сонгон шалгаруулж гэрээ байгуулсан. ЭХХЗХС-ийн нэгдсэн сүлжээнд үзүүлэх туслах үйлчилгээний үнэ тариф, зах зээлийн дүрмийг эхний байдлаар боловсруулсан.		
27	2.2.3. Эгийн голын усан цахилгаан станцын биологийн олон янз байдлын нөлөөллийн судалгааг дуусгаж, Дэлхийн өвийн хороонд хүргүүлэх	Юнескогийн Дэлхийн өвийн хороонд танилцуулж, зохих шийдвэрийг гаргуулсан байна.	-	-	Шинээр баригдах том чадлын цэнэг хураагуурын станцыг эрчим хүчний нэгдсэн сүлжээнд холбох Техникийн нөхцөлийг 2021 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн хурлаар хэлэлцэж, 14/2021/252 дугаартай олгосон. 2021-2022 онд барилга угсралтын ажлын гүйцэтгэчийг сонгон шалгаруулах тендерийг 2 удаа зохион байгуулсан. АХБ-аас үл татгалзах хариу ирүүлснээр 2022 оны 06 дугаар сарын 09-ний өдөр Үнэлгээний хороо төслийн гүйцэтгэгчтэй гэрээ байгуулах зөвлөмжийг өгсөн. Дэлхийн зах зээл дээрх цэнэг хураагуурын түүхий эдийн үнэ нэмэгдсэнтэй холбогдуулан тендер ирүүлсэн компаниуд үнээ нэмэх нөхцөл тавьж, АХБ-ны зөвлөмжөөр эхний тендер хүчингүй болж, дахин зарлагдсан. Төслийн ерөнхий гүйцэтгэгчээр БНХАУ-ын ZTT-ZEST консорциум шалгарч, 2022 оны 7 дугаар сард гэрээнд гарын үсэг зурсан ба АХБ-ны зөвлөмжийн дагуу гэрээнд холбогдох нэмэлт өөрчлөлтийг оруулсан. Барилга угсралтын ажлыг 2022 оны 08 дугаар сарын 04-ний өдөр эхлүүлсэн ба төслийн ажлын зураг хийгдэж байна. Ерөнхий зураг төсөл боловсруулах ажлыг түргэвчлэх үүднээс гүйцэтгэгч, ДҮТ ТӨХХК, ЦДҮС ТӨХК, Төслийн менежментийн зөвлөх компани (ТМЗК) зэрэг талуудын хамтарсан хурлыг 2022 оны 10 дугаар сарын 26-ны өдөр зохион байгуулж шийдлүүд дээр саналуудаа нэгтгэв. Төслийн хүрээнд "Эрчим хүчний салбарт ажиллаж буй 120 эмэгтэй инженерүүдийг чадавхжуулах сургалт"-ыг 2022 оны 10 дугаар сарын 24-28-нд 3 үе шаттайгаар зохион байгуулсан.	ЭХЯ	90.0
					ЮНЕСКО-гийн Дэлхийн өвийн хорооны (ДӨХ)-ны 2015 оны 39, 2016 оны 40 дүгээр чуулганаар Эгийн голын усан цахилгаан станцын төсөлтэй холбогдуулан Сэлэнгэ мөрөн, Байгаль нуурын Биологийн олон янз байдлын нөлөөллийн судалгааг хийх зөвлөмж гарсан. Уг судалгааны ажлын гүйцэтгэгчээр БРЛ Инженеринг компани шалгарч, 2019 оны 06 дугаар сард гэрээ байгуулсан. Төслийг санхүүжүүлэгч Хөгжлийн банкнаас төслийг үргэлжлүүлэн санхүүжүүлэх боломжгүй тухай 2019 оны 08 сард мэдэгдсэнээс хойш дээрх судалгааны ажил зогсонги байдалтай байсан. Засгийн газрын 2021 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн хуралдаанд асуудлыг танилцуулж, 14 дүгээр тэмдэглэлээр төслийн гидрологийн техник, эдийн засгийн үзүүлэлтийн тооцоо судалгаа гүйцэтгэсэн Франц Улсын Трактебел Инженеринг компани болон байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн судалгааг гүйцэтгэж буй БРЛ Инженеринг компанитай холбогдох төлбөрийг тус тус хийх арга хэмжээ авахыг даалгасны дагуу Сангийн сайдаас өгсөн чиглэлийн хүрээнд Эрчим хүчний сайдын урсгал зардлын жилийн төсвийн хуваарьт өөрчлөлт оруулж, шаардлагатай хөрөнгийг шийдвэрлэсэн.		
					Франц Улсын "БРЛ Инженер" компани, Монгол Улсын "Престиж Инженеринг" ХХК, "Санни Трейд" ХХК-ийн түншлэлтэй байгуулсан		

					Зөвлөх үйлчилгээний гэрээг 2022 оны 10 дугаар сарын 1-ний өдөр хүртэл сунгасан. Тус компанитай 2022 оны 05 дугаар сарын 27-ны өдөр төслийн явцын талаар уулзалт хийсэн. Судалгааны ажлын явцад байнгын хяналт тавьж ажилласнаар судалгааны тайланг зөвлөх компаниас гэрээний дагуу 2022 оны 10 дугаар сарын 31-нд ирүүлснийг БОАЖЯ-нд уламжлан, Мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлсэн. Тус зөвлөлөөс Усны зөвлөлөөр хэлэлцүүлэх шаардлагатай гэж үзсэн. Ерөнхий сайдад Эгийн голын УЦС төслийн үйл ажиллагааг 2022 оны 08 дугаар сарын 09-ний өдөр төслийн талбарт танилцуулах ажлыг зохион байгуулж, уг асуудлыг Засгийн газрын 2022 оны 08 дугаар сарын 17-ны хуралдаанд танилцуулж, хуралдааны 41 дүгээр тэмдэглэлээр өгсөн арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байна.		
Зорилт 2.3. Эрчим хүчний салбарыг санхүү, эдийн засгийн бие даасан тогтолцоонд үе шаттайгаар шилжүүлнэ.							
28	2.3.1. Эрчим хүчний үнэ тарифыг индексжүүлж улирал тутам шинэчилнэ.	Үнэ тарифыг улирал тутам индексжүүлсэн байна.	-	-	Дэлхийн банкны техникийн туслалцаатайгаар хэрэгжүүлж буй “Монгол Улсын Эрчим хүчний зах зээлийн загварыг сайжруулах”, “Монгол улсын Эрчим хүчний үнэ тарифын тогтолцоог сайжруулахад үзүүлэх дэмжлэг” төслүүдийн хүрээнд ажлын даалгаврын дагуу зөвлөхүүдтэй хамтран ажиллаж зохих судалгаа шинжилгээнүүдийг хийсний үндсэн дээр Эрчим хүчний зохицуулах хорооны даргын 2019 оны А/106 тоот тушаалаар “Бодит өртөг, ашгийн зохих түвшнийг хангасан үнэ тарифын тогтолцоог олон улсын жишигт нийцүүлэн боловсронгуй болгох, индексжүүлэлтийг хэрэгжүүлэх талаар санал боловсруулах” ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна. Тус ажлын хүрээнд урамшуулалт зохицуулалт, ДЦС-уудын хувьсах зардлын үндсэн хүчин зүйл жишмэл түлшний хувийн зарцуулалтын сар бүрийн мэдээллийг тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс авч, хэрэглэгчийн тарифт үзүүлэх хэлбэлзлийн нөлөөллийг шинэчлэн тооцсон. Дэлхий даяар “КОВИД-19” халдварт өвчин гарсан болон олон улсын цаг үеийн нөхцөл байдалтай холбоотойгоор хэрэглэгчдийн төлбөрийн чадвар буурсан тул хэрэглэгчдийн цахилгаан, дулааны тарифыг индексжүүлэх асуудал хойшлогдсон. Эрчим хүчний салбарын санхүү, эдийн засгийн нөхцөл байдлын талаар Монгол Улсын Ерөнхий сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт “Эрчим хүчний үнэ тариф, цаашид авах арга хэмжээний талаарх хувилбарт тооцоо, танилцуулга”-ыг Монгол Улсын Засгийн газрын хуралдаанд танилцуулахаар 3 удаа хандсан боловч үнэ индексжүүлэх асуудал хойшлогдсон хэвээр байна. Эрчим хүчний үнэ тарифыг индексжүүлэх талаарх мэдээллийг олон нийтийн мэдээллийн хэрэгслүүдээр дамжуулан нийтэд хүргэх ажлыг ЭХЗХ-ноос байнга зохион байгуулж байна. ЭХЗХ-ны 2022 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн хурлаар аж ахуйн нэгж байгууллагын цахилгаан эрчим хүчний үнэд өөрчлөлт оруулсан.	ЭХЯ	50.0
Зорилт 2.4. Зүүн хойд Азийн эрчим хүчний нэгдсэн сүлжээнд эрчим хүч нийлүүлэх сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр, сүлжээнд холбогдох хэт өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцын бэлтгэл ажлыг хангана.							
29	2.4.1. Өмнийн говийн нар салхины эх үүсгэврийг ашиглаж сэргээгдэх эрчим хүч үйлдвэрлэн Зүүн хойд Азийн супер сүлжээнд эрчим хүч нийлүүлэх судалгаа хийх	Өмнийн говьд барих сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийн хүчин чадал, Зүүн хойд Азийн эрчим хүчний нэгдсэн сүлжээнд	-	-	Монгол орны говийн бүсийн нар, салхины арвин нөөцөд тулгуурлан том чадлын сэргээгдэх эрчим хүчний цогцолбор барих, Зүүн хойд Азийн орнуудад цахилгаан экспортлох Гобитек-Азийн нэгдсэн сүлжээ санаачилгыг хэрэгжүүлэхэд бүс нутгийн орнуудтай хамтран ажиллаж байна. Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр төслийн хоёр дахь үе шатны судалгааны ажил эхлүүлэхээр тус банкны 4 жилийн стратегийн төлөвлөгөөнд тусган батлуулсан. Зүүн хойд Азийн бүс нутгийн орнуудын төлөөллүүдтэй санал солилцох, цахим	ЭХЯ	50.0

		холбогдох улс хоорондын хил дамнасан хэт өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцын техник, технологийн шийдэл, өмнийн говийн нар, салхины эх үүсгэврийг ашиглаж ногоон устөрөгч үйлдвэрлэх технологийн шийдлийг судалсан байна.			уулзалтыг тогтмол хийж, хамтран ажиллаж байна.		
Зорилт 2.5.Оросын Холбооны Улсаас Бүгд Найрамдах Хятад Ард Улс руу Монгол Улсын газар нутгаар дамжин өнгөрөх байгалийн хий дамжуулах хоолой барих бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлнэ.							
30	2.5.1. Оросын Холбооны Улсаас Бүгд Найрамдах Хятад Ард Улс руу Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжуулан барих байгалийн хий дамжуулах хоолойн техник, эдийн засгийн үндэслэлийг дуусгаж, барилга угсралтын ажлыг эхлүүлэх бэлтгэлийг хангах	Монгол Улсын хийн хэрэглээний хий хуваарилах байгууламжуудын хүчин чадал, байршил, дэд бүтэц, логистикийн терминалуудын судалгааг хийж, бэлтгэл ажлыг хангасан байна.	-	-	“Газпром” НХН-ийн 100 хувийн хөрөнгө оруулалттай тусгай зориулалтын компани болох “Газопровод Союз Восток” ХХК-ийг 2021 оны 1 дүгээр сард Монгол Улсад бүртгүүлэн үйл ажиллагааг эхлүүлээд байна. Монгол Улсын Засгийн газар, “Газпром” нээлттэй хувьцаат нийгэмлэгийн хамтарсан ажлын хэсгийн төлөвлөгөөний дагуу төслийн техник, эдийн засгийн үндэслэлийг “Газопровод Союз Восток” ХХК боловсруулж, баталгаажуулсан.	ЭХЯ	50.0
ГУРАВ.АЖ ҮЙЛДВЭРИЙН СЭРГЭЛТ							
Зорилт 3.1.Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олголтыг бүрэн цахимжуулж, өртөг зардлыг бууруулан хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, дэвшилтэт техник, технологид суурилсан, нэмүү өртөг шингэсэн уул уурхайн бүтээгдэхүүний хэмжээг дээшлүүлэн эрдэс баялгийн баталгаат нөөцийг арвижуулна.							
31	3.1.1. Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олголтыг цахимжуулж, тусгай зөвшөөрлийн тоог нэмэгдүүлэн хөрөнгө оруулалтыг татах боломжийг бүрдүүлэх	Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалт болон өргөдлөөр олгох үйл ажиллагааг цахимжуулж, хайгуулын ажилд зарцуулах хувийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, эрдэс баялгийн нөөцийг арвижуулсан байна.	-	-	АМТХ-ийн 10.1.2-д заасны дагуу ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтаар олгох журам батлах эрхийг Засгийн газрын 2021 оны 381 дүгээр тогтоолоор олгосны дагуу Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2022 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн А/35 дугаар тушаалаар батлуулсан. Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд 2022 оны 05 дугаар сарын 05-ны өдөр 5821 дугаартайгаар бүртгүүлсэн. Энэ хугацаанд тусгай зөвшөөрлийг цахимаар олгох бэлтгэл ажлыг ТӨБЗГ-ын худалдан авах ажиллагааны газартай хамтран гүйцэтгэж, программ хангамжийн ажилд шаардлагатай мэдээллүүдийг боловсруулсан. Шинэчлэн баталсан журмын хүрээнд цахим хэлбэрээр ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалт явуулах боломжтой болсон. Сонгон шалгаруулалт зарлах бэлтгэл ажлыг бүрэн хангаж зарлах шийдвэрийг хүлээж байна. Засгийн газрын 2022 оны 08 дугаар сарын 10-ны өдрийн хуралдаанаар тусгай зөвшөөрөл олголттой холбоотой асуудлыг танилцуулсан бөгөөд асуудлыг Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд танилцуулахаар шийдвэрлэсэн. ҮАБЗ-д танилцуулах материалыг боловсруулсан бөгөөд хуралдааны товыг хүлээж байна.	АМГТГ	90.0

					Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамнаас 2022 оны 09 дүгээр сард Улаанбаатар хотод зохион байгуулсан "Mongolian Mining Week-2022" олон улсын уул уурхайн 7 хоногийн арга хэмжээний хүрээнд ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олголтын цахимжуулалт, хайгуул судалгааны ажлын санхүүжилтийн асуудлаар хамтран ажиллагч, хөрөнгө оруулагч талуудтай уулзалт хийж, мэдээлэл санал солилцсон. Хайгуулын тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтаар олгох 25 талбайг 2022 оны 11 дүгээр сарын 23-ны өдрөөс tender.gov.mn платформ зарласан. Цаашид 7 хоног тутамд 25 талбайг дээрх платформоор дамжуулан зарлахаар бэлтгэл ажлыг бүрэн хангасан. Монгол Улсын хэмжээнд 2022 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн байдлаар 5.92 сая га талбайг хамарсан ашигт малтмалын 2,554 тусгай зөвшөөрөл хүчин төгөлдөр байгаа нь нийт нутаг дэвсгэрийн 3.8 хувийг эзэлж байна. Үүнээс ашиглалтын 1,709 /1.83 сая га/, хайгуулын 845 /4.09 сая га/ тусгай зөвшөөрөл байна. 2022 оны эхний 10 сард ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн болон улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн ордын нөхөн төлбөрөөр улсын төсөвт 30.8 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлээд байна.		
32	3.1.2. Улсын тусгай хамгаалалттай болон хилийн бүсэд орших хэтийн төлөв бүхий талбайд улсын төсвийн хөрөнгөөр геологи-хайгуулын ажил гүйцэтгэх	Эдийн засгийн хувьд өндөр ач холбогдолтой ашигт малтмалын /алт, зэс, өндөр технологийн түүхий эд гэх мэт/ эрэл, хайгуулын ажлыг төрийн өмчит компаниар гүйцэтгүүлж, эдийн засгийн эргэлтэд оруулсан байна.	Улсын төсөв	3.6	Улсын тусгай хамгаалалттай болон хилийн бүс, зурваст төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн зураглал, ерөнхий эрлийн болон бусад сэдэвчилсэн судалгаа, ашигт малтмалын хэтийн төлөвийг тогтоох эрэл-үнэлгээний ажлуудад зарцуулах төсвийн саналыг УУХҮС-ын 2023 оны төсвийн хязгаар батлагдсантай холбогдуулан дахин тооцож, нэгтгэлд тусгуулахаар яамны санхүүгийн нэгжид 7-р сарын 26-ны өдөр хүргүүлсэн. 2023 оноос хилийн бүс, зурваст ашигт малтмалын хэтийн бүхий талбайд 2 төслийг хэрэгжүүлэхээр 2023 оны улсын төсвийн төсөлд тусгуулахаар мөн хүргүүлсэн. "Mongolian Mining Week-2022" олон улсын уул уурхайн 7 хоногийн арга хэмжээний хүрээнд /2022.09.19-09.23/ ашигт малтмалын нөөцийн хэтийн төлөв бүхий талбайд гүйцэтгэх геологи, хайгуулын ажлын талаарх мэдээлэл, танилцуулгыг олон улсын байгууллага, оролцогч талуудад танилцуулж санал солилцсон. УУХҮС-ын 2023 оны төсвийн багцад батлагдсан геологи-хайгуулын ажил болон эрдэм шинжилгээ, судалгааны ажлын төсвийн эх үүсвэрээр дунд, том масштабын геологийн зураглал, эрэл, эрэл-үнэлгээний ажил, ашигт малтмалын хэтийн төлөвийн судалгааны ажлыг тусгай хамгаалалттай газар, хилийн бүсэд гүйцэтгэхээр төлөвлөн яамны 2023 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний төсөлд тусгуулсан.	УУХҮЯ	50.0
33	3.1.3. Тавантолгойн нүүрс баяжуулах үйлдвэрийг ашиглалтад оруулж, ордыг иж бүрэн ашиглах нөхцөлийг бүрдүүлэх	Эхний модуль 10 сая тонн нүүрс баяжуулах үйлдвэрийг 2023 онд ашиглалтад оруулж, 928 ажлын байр шинээр бий болгож, экспортын орлогыг нэмэгдүүлсэн байна.	"Эрдэнэс Тавантолгой" ХК	957.1	Нүүрс баяжуулах үйлдвэрийн барилгын зураг төсөв боловсруулах, барилга угсралтын ажил гүйцэтгэх түлхүүр гардуулах нөхцөлтэй тендер зарласан. Гүйцэтгэгчээр БНХАУ-ын "Норинко Интернэшнл Күүперэшн" компани болон "Дади инженеринг девелопмент групп" компаниудын түншлэл шалгарсан. Геодиз, инженер геологийн судалгаа бүрэн хийгдсэн. Архитектор төлөвлөлтийн даалгавар, эскиз зургийг Өмнөговь аймгийн ГХБХБГазар, Аймгийн МХГ, Аймгийн ОБГ-аар баталгаажуулсан. Зам болон үйлдвэрийн нарийвчилсан зургийн ажил үе шаттайгаар хийгдэж байна. Цогтцэций сумаас НБҮ-ийн төслийн 103 га газар эзэмших зөвшөөрлийг авсан. Бетон зуурмагийн үйлдвэр барьсан, төслийн хашаалах ажлыг гүйцэтгэж байна. Цахилгаан хангамжийн дэд станц барих тендер зохион байгуулж, гүйцэтгэгч шалгаруулан, ЦДАШ-ийн зураг төслийн ажил хийгдэж	УУХҮЯ	50.0

					байна. Технологи сонголт эцэслэсэн. Архитектор төлөвлөлтийн даалгавар, эскиз зургийг Өмнөговь аймгийн ГХБХБГазар, Аймгийн МХГ, Аймгийн ОБГ-аар баталгаажуулсан. Замын зураг төсөл боловсруулах компанийг гүйцэтгэгч сонгосон. Түүхий нүүрсний агуулах, бутлах хэсгийн нарийвчилсан зураг төслийн ажлыг эхлүүлсэн. Төслийн ерөнхий гүйцэтгэгчийн Монгол дахь Төлөөний газрыг 2022 оны 07 дугаар сарын 25-ны өдөр байгуулсан.		
34	3.1.4. "Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн ил уурхайн олборлолтын өртгийг бууруулах, хүчин чадлыг нэмэгдүүлэх зорилгоор технологийн харьцуулсан сонголт /1.олон утгуурт экскаватор-конвейер, 2.цахилгаан экскаватор-конвейер, 3.цахилгаан экскаватор-хүнд даацын автосамосвал/ хийж, өөрөө олборлогч компани болох	Олборлолтын хүчин чадлыг үе шаттайгаар нэмэгдүүлж, төслийн хүчин чадлыг 50 сая тоннд хүргэсэн байна. Олборлолтын өртөг, зардлыг 20-30 хувиар бууруулсан байна.	"Эрдэнэс Тавантолгой" ХК	1,352.3	"ЭТТ" ХК-н инженер техникийн ажилтнууд өөрсдийн дотоод нөөц бололцоог ашиглан, гадна болон дотоодын мэргэжлийн зөвлөх инженерүүдтэй хамтран ТЭЗҮ-г боловсруулж байна. 55% Техник худалдан авах сонгон шалгаруулалтад тэнцсэн компаниудтай гэрээг байгуулсан. Үлдсэн багц тендерийг зохион байгуулан ажиллаж байна. Конвейерийн ТЭЗҮ боловсруулан ажиллаж байна. Техникүүдийн нийлүүлэгчийг сонгон шалгаруулж гэрээг байгуулан ажиллаж байна. Конвейерийн ТЭЗҮ боловсруулан ажиллаж байна. Техникүүдийн нийлүүлэгчийг сонгон шалгаруулж гэрээг байгуулан үлдсэн техникүүдэд тендер шалгаруулалт зохион байгуулж байна.	УУХҮЯ	70.0
35	3.1.5. "Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн ил уурхайн аргаар ашиглах боломжгүй нөөцийг далд уурхайн аргаар ашиглаж, экспортыг нэмэгдүүлэх	Олборлолтын хэмжээг 10 сая тонноор нэмэгдүүлж, 1500-1800 хүний ажлын байр шинээр бий болгосон байна.	"Эрдэнэс Тавантолгой" ХК, хөрөнгө оруулагч	-	"Евроашиан майнинг контрактор" ХХК-тай хамтран урьдчилсан үнэлгээний ажил гүйцэтгэсэн. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын тушаалаар "Нүүрсний далд уурхайн аюулгүй ажиллагааны дүрэм"-ийн төсөл боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсэг" байгуулж ажиллуулах бэлтгэл ажлыг хангаад байна. "Эрдэнэс Тавантолгой" ХК-иас өмнөх жилүүдэд хийж гүйцэтгэсэн геологи, хайгуулын үр дүнг нэгтгэх, 3 хэмжээс загварчлалын дүнг компанийн удирдлага болон ТУЗ-д танилцуулах ажил хийгдэж байна. Мөн шаардлагатай материалыг бүрдүүлж ажлын даалгаврыг боловсруулаад байна.	УУХҮЯ	30.0
Зорилт 3.2.Нэмүү өртөг шингэсэн хүнд үйлдвэрлэлийг хөгжүүлж, дотоодын бүтээн байгуулалтын хэрэгцээг хангаж, экспортыг нэмэгдүүлнэ.							
36	3.2.1. "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын үр ашгийг нэмэгдүүлэх зорилгоор уул уурхай-металлурги химийн нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн цогцолбор /зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр, исэлдсэн хүдрээс катодын зэс үйлдвэрлэх/-ыг байгуулах	Паркийн хүрээнд баригдах үйлдвэрүүд ашиглалтад орж жилд 135 мянган тонн катодын цэвэр зэс үйлдвэрлэснээр экспортын орлого нэмэгдэж, 1050 ажлын байр шинээр бий болгосон байна. Зэсийн бүтээгдэхүүн	"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ	136.1	"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ыг түшиглэн Уул уурхай-металлурги-химийн үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн парк байгуулах төслийн ТЭЗҮ, БОННУ, Ерөнхий төлөвлөгөө батлагдсан. Үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг Засгийн газрын 2021 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн 129 дүгээр тогтоолоор олгосон. Дэд бүтэц /ус хангамж, ариутгах татуургын систем, авто зам, төмөр зам, цахилгаан хангамжийн зураг төсөл, ТЭЗҮ боловсруулж, БХБЯ-ны харьяа Барилгын хөгжлийн төвөөр батлуулсан. Зураг төсөл, ТЭЗҮ-ний дагуу УТП-ийн дэд бүтцийг барьж байгуулах тендер шалгаруулах үнэлгээний хороо байгуулагдан ажиллаж байна. Мөн УТП-ийн дэд бүтцийн зураг, төслийн дагуу төсөвт өртгийн өөрчлөлтийг "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын 2022 оны хөрөнгө оруулалтын тодотгол төлөвлөгөөнд оруулан батлуулсан. 2023 оны Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд батлуулахаар 2022 оноос шилжиж буй ажил, шинээр	УУХҮЯ	50.0

		үйлдвэрлэх дагалдах жижиг, дунд үйлдвэрүүдийн кластер байгуулсан байна.			төлөвлөх ажлын жагсаалтыг боловсруулан дараагийн шатны удирдлагад шилжүүлсэн. Автозам барьж байгуулах ажлын тендер нь 2022 оны 06 дугаар сарын 30, 2022 оны 09 дүгээр сарын 26-нд 2 удаа зарласан. Шаардлага хангасан оролцогч материал ирүүлээгүй тул тендерийг 2022 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр дахин тендер зарласан. Төмөр зам барьж байгуулах ажлын тендерийг 2022 оны 10 дугаар сарын 06-нд нээж, 3 компани материал ирүүлсэн боловч шаардсан материал дутуу ирүүлсэн тул тендер хүчингүй болсон. 2022 оны 11 дүгээр сарын 07-нд дахин тендер зарласан. 2022 оны 12 дугаар сарын 12-нд тендер нээнэ. Ус хангамж, ариутгах татуургын систем барьж байгуулах ажлын тендер 2022 оны 10 дугаар сарын 06-нд нээсэн бөгөөд нийт 7 оролцогчийн ирүүлсэн материалд үнэлгээ хийгдэж дууссан ба шаардлага хангах оролцогч байгаагүй тул мэдэгдэл хүргүүлэн, дахин зарлахаар ажиллаж байна. Паркийн цахилгаан хангамжийн ТЭЗҮ-ийг Эрчим хүчний яам хүлээн аван, хариуцан ажиллаж байна. Диспетчерийн үндэсний төвтэй горимын тооцоо хийлгэсэн. 3 ширхэг дэд станц тус бүр дээр техникийн нөхцөл гарсан. Цаашид ЭХЯ хариуцан цахилгаан хангамжийн нарийвчилсан зураг төсөл боловсруулах техникийн даалгавар ЭХЯ-аас 2022 оны 11 дүгээр сарын 01-нд ирсэн. Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын 2022 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд өөрчлөлт оруулан, үнэлгээний хороо байгуулж, тендерийн баримт бичгийг боловсруулж байна.		
37	3.2.2. Хар төмөрлөгийн үйлдвэрлэлийг дагалдах үйлдвэрүүдийн хамт хөгжүүлж ган бүтээгдэхүүний дотоодын хэрэгцээг хангах	Төмрийн хүдрийг дотооддоо боловсруулж, нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүн болох 350 мянган тонн ган бүтээгдэхүүн үйлдвэрлэх "Монгол ган цогцолбор I", 500 мянган тонн ширэм, 1 сая тонн кокс үйлдвэрлэх Алтанширээт аж үйлдвэрийн парк, 200 мянган тонн ган бүтээгдэхүүн үйлдвэрлэх Эрдэнэтийн төмөрлөгийн үйлдвэр төслүүд хэрэгжиж дууссанаар 2025 он гэхэд дотоодын гол нэрийн ган бүтээгдэхүүний	-	-	Засгийн газрын 2022 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн 148 дугаар тогтоолоор Эдийн засаг, хөгжлийн яам /хуучнаар/ болон "Кью Эс Си" ХХК-ийн хооронд 2014 онд байгуулсан "Уул уурхай, металлургийн цогцолбор байгуулах төсөл"-ийг хэрэгжүүлэх Концессын гэрээг цуцалсан. Уг тогтоолын дагуу ТӨБЗГ-аас Дарханы төмөрлөгийн үйлдвэрийг төрийн өмчит компанийн статустай болгож, бүтцийг баталж, удирдлагыг томилсон. "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ТӨҮГ нь Засгийн газрын "Шинэ сэргэлтийн бодлого"-ын Аж үйлдвэрийн сэргэлтийн хүрээнд "Шинэ сэргэлт- Монгол ган" хэлэлцүүлгийг 2022 оны 07 дугаар сарын 04-ний өдөр зохион байгуулсан. Тус компаниас "Монгол ган цогцолбор I" төслийг хэрэгжүүлэх, ТЭЗҮ-ийг шинэчлэн боловсруулах зорилгоор сонгон шалгаруулалт зарлахаар ажиллаж байна. Төслийн цахилгаан хангамжийн ТЭЗҮ, зураг төслийг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийлгэх, 2023 оны төсөвт суулгах хүсэлтийг УУХҮС-ын 2022 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн 01/2288 дугаар албан бичгээр Сангийн сайдад хүргүүлээд байна. Бэрэн групп ХХК-ийн 2014 оноос Орхон аймагт хэрэгжүүлж байгаа 200 мянга тонн/жил хүчин чадалтай ган бүтээгдэхүүний үйлдвэрийн төслийн хэрэгжилт 75 орчим хувьтай байна. Тус компани нь Монгол Улсын Хөгжлийн банкнаас 2014 онд 22.7 сая ам.доллар, 2018 онд 4.5 сая ам.доллар, нийт 27.2 сая ам.долларын зээлийн санхүүжилт авсан бөгөөд үйлдвэр ашиглалтад орж үйл ажиллагаа эхлүүлээгүйн улмаас уг зээл эргэн төлөгдөөгүй байна. Цаашид үйлдвэрийг ашиглалтад оруулахад шаардагдах 30.7 тэрбум төгрөгийн санхүүжилтийг нэмж олгох хүсэлтийг тус компаниас Хөгжлийн банк	УУХҮЯ	30.0

		/арматур гэх мэт/ хэрэгцээний 80 хувийг хангаж, экспортод гаргах бүтээгдэхүүний тоо хэмжээ нэмэгдсэн байна.			болон УУХҮЯ-нд гаргасан. УУХҮЯ болон Хөгжлийн банкны холбогдох удирдлагууд удаа дараагийн уулзалтуудыг зохион байгуулж, боломжит хувилбарыг судалсан. Хөгжлийн банкны Бизнес, хөгжил хариуцсан дэд захирал З.Батырбек тус компанийн өр, зээлийн асуудлын талаар УУХҮЯ-ны ХҮБГ-ын дарга Д.Даваадоржид 2022 оны 08 дугаар сарын 12-ны өдөр танилцуулсан. Мөн энэ асуудлаар дэлгэрэнгүй мэдээлэл ирүүлэх тухай ХҮБГ-ын даргын 2022 оны 08 дугаар сарын 16-ны өдрийн 07/2216 дугаар албан бичгийг Хөгжлийн банканд хүргүүлсэн. “Бэрэн групп” ХХК, түүний хамаарал бүхий компаниудын тус банкнаас авсан зээл, өрийн асуудлыг шүүхээр шийдвэрлүүлэх хүсэлтийг Хөгжлийн Банкнаас хүргүүлсэн талаар мэдэгдээд байна. Газрын асуудал (140 га)-ыг бүрэн шийдвэрлэж, 12 км төмөр зам, 6,3 МВТ-ын цахилгааны дэд станц, 110 кВ, 10 кВ-ын 9,4 км цахилгаан дамжуулах агаарын шугамууд барьж байгуулсан ба төмрийн хүдрийн нойтон баяжуулах үйлдвэрийг 2021 онд ашиглалтад оруулсан. Паркийн ус хангамжийг шийдэх зорилгоор “Бор хөөвөр”-ийн газрын доорх усны ордын талбайд ус цуглуулах байгууламж байгуулах ажил, ажилчдын 5 блок байр барих, нүүрс ачиж, буулгах талбайн газар, шорооны ажлыг 2022 оны 5 дугаар сард тус тус эхлүүлсэн. “Монголын эдийн засгийн чуулган 2022”-ын хүрээнд зохиогдсон “Аж үйлдвэрийн сэргэлт” хэлэлцүүлгийн үеэр “Алтан ширээт аж үйлдвэрийн парк”-ийн зарим үйлдвэрийг түүхий эд /кокских нүүрс/-ээр тогтвортой хангах боломж бүрдүүлэх зорилгоор “Эрдэнэс Тавантолгой” ХК болон “Болдтөмөр Ерөө гол” ХХК-ийн хооронд харилцан ойлголцлын санамж бичиг байгуулсан.		
38	3.2.3. Оюутолгойн ордыг түшиглэн зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр байгуулж катодын зэс, алт, мөнгө зэрэг нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх	Төслийн хүрээнд баригдах үйлдвэрүүд ашиглалтад орж жилд дунджаар 257 мянган тонн катодын цэвэр зэс, 5.7 тонн алт, 57 тонн мөнгө үйлдвэрлэснээр экспортын орлого нэмэгдсэн байна.	Гадаад, дотоодын хөрөнгө оруулалт	5,985.0	1. Төслийн урьдчилсан ТЭЗҮ, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийгдсэн. 2. Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 378 дугаар тогтоолоор 466 га газрыг Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутаг дэвсгэрт улсын тусгай хэрэгцээнд авсан. Газрын кадастрын зургийг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газраар баталгаажуулан, топо зураглал хийсэн. 3. ЗТХЯ-аас үйлдвэрийн байршлаас хамааран Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын 147-150 дугаар километр аль ойр байх өртөө, зөрлөгөөс зураг төслийн дагуу салаалахад техникийн нөхцөлийн хувьд боломжтой гэсэн санал, дүгнэлт гарсан. 4. Үйлдвэрийн усны асуудлыг Дорноговь аймгийн Мандах сумын нутагт орших Цагаан цавын газрын доорх усны ордоос үйлдвэрлэлийн С1 зэргээр үнэлсэн 800л/с нөөцөөс төслийн 220л/с усны хэрэглээг шийдвэрлэх боломжтой талаар Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас албан тоот ирүүлсэн. 5. Монгол Улсын Ерөнхий сайдын 2022 оны 1 дүгээр сарын 11-ний өдрийн 01 дүгээр “Албан даалгавар”-аар даалгасны дагуу “Эрдэнэт, Оюутолгой зэрэг ордыг иж бүрэн ашиглаж, зэсийн боловсруулалтыг нэмэгдүүлэх төслүүдийн талаар” Засгийн газрын хуралдаанд танилцуулахаар Уул уурхай хүнд үйлдвэрийн сайд 2022 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн 01/1590 дугаартай албан бичгээр	УУХҮЯ	30.0

					ЗГХЭГ-т хүргүүлээд байна. 6. Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрт хөрөнгө оруулж хамтран ажиллах талаар саналыг "Рио Тинто Монгол" ХХК болон "Оюу толгой" ХХК-д хүргүүлсэн. 7. Дорноговь аймагт орших Цагаан цавын газрын доорх усны ордоос үйлдвэрийн усыг хангахад 224 км шугам хоолойгоор дамжуулан татах шаардлагатай байгаа тул ЗББҮ-ийн ойролцоо орших газрын доорх усны ордоос усны асуудлыг шийдвэрлэх боломжит хувилбаруудын талаарх саналыг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны газраас 2022 оны 09 дүгээр сарын 27-ны өдрийн 01/1091 албан бичгээр ирүүлсэн. 8. Төслийн цахилгааны хэрэглээг "Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ" ТӨХК-ийн хариуцах "Тавантолгой-Оюутолгой" 220 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамаар дамжуулан төвийн бүсийн эрчим хүчний нэгдсэн сүлжээнээс бүрэн хангах боломжтой талаар ЭХЯ-ны 2022 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн А/3862 албан бичгээр ирүүлсэн. 9. Оюу толгойн Хөрөнгө оруулалтын гэрээний 3.21-д заасны дагуу олон улсын зах зээлийн үнэ, стандартад суурилсан арилжааны нөхцөлөөр Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрт Оюунтолгойн зэсийн баяжмалыг нийлүүлэх боломжтой талаар "Рио Тинто Монгол" ХХК-иас 2022 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн 189/22 албан бичгээр мэдэгдсэн.		
39	3.2.4. "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын ҮТП байгуулах ажлын хүрээнд Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр байгуулах	?	"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ	1,917.8	Үйлдвэрийн нарийвчилсан зураг төсөл боловсруулах ажлыг эрчимжүүлэх зорилгоор Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ийн Ерөнхий захирал Г.Ёндон 2022 оны 11 дүгээр сарын 01-ний өдөр Enfi компанийн дээд шатны удирдлагатай цахим хурал хийж, туршилтын ажлыг эрчимжүүлж 6 сарын хугацаанд дуусгах, нарийвчилсан зураг төслийн ажлыг эхлүүлэх тал дээр тохиролцсон. China Enfi engineering corporation-аас 2022 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр ирүүлсэн албан бичигт туршилтын үйлдвэрийг 2023 оны 05 дугаар сарын 30-нд барьж дуусган, туршилтын ажлын үр дүнг 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн дотор гаргасан байх тухай албан ёсоор мэдэгдсэн. ЭБМЗ-өөс өгсөн зөвлөмжийн дагуу "Аж үйлдвэрийн бүсэд мөрдөх агаарын чанарын стандартууд болон зэс хайлуулах үйлдвэрийн хаягдал утааны найрлага дахь агаар бохирдуулах бодисуудын ялгарлын олон улсын стандартуудыг судалж үндэсний болгон боловсруулж батлуулах зөвлөх үйлчилгээ"-ний тендерийг 2022 оны 11 дүгээр сарын 02-нд нээж, үнэлгээг хийж, Эс Ай Си Эй байгууллагад гэрээ байгуулах эрх олгоод байна. ЗБХБҮ-ийн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийх ажлын тендерийг 2022 оны 11 дүгээр сарын 16-ны өдөр нээсэн бөгөөд үнэлгээ хийгдэж байна. Хүхрийн хүчлийг ашиглан фосфорын бордоо үйлдвэрлэх туршилт судалгааг Эрдэнэт Үйлдвэр ТӨҮГ-ийн үйлдвэрийн судалгаа, шинжилгээний хүрээлэнгийн ажилтнууд гүйцэтгэж байна. Мөн "Фосфорын ордыг ашиглах урьдчилсан ТЭЗҮ боловсруулах ажил"-ын гэрээг ШУТИС-ын УУХ-ГУУС-тай 2022 оны 09 дүгээр сарын 13-нд байгуулан ажиллаж байгаа бөгөөд 2022 оны 11 дүгээр сарын 04-ний өдөр ирүүлсэн эхний тайланд Ажлын хэсгийн дүгнэлт гарсан. Ажлын явц 50 хувьтай байна.	УУХҮЯ	30.0

40	3.2.5. "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын УТП байгуулах ажлын хүрээнд исэлдсэн хүдрээс катодын зэс үйлдвэрлэх	?	"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ	167.4	SX/EW: 2021 оны 09 дүгээр сарын 17-ны өдөр "Майнинг Шорт Лонг Терм" ХХК-тай "SX/EW технологиор катодын зэс боловсруулах үйлдвэрийн нарийвчилсан зураг төсөл боловсруулах" зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулан ажиллаж байна. Тус үйлдвэрийн ТЭЗҮ-ийг УУХҮЯ-ны дэргэдэх ЭБМЗ-ийн Ашигт малтмалын орд ашиглах ТЭЗҮ хэлэлцэх салбар хурлаар 2022 оны 6-р сарын 24-нд хэлэлцүүлсэн бөгөөд Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын Ерөнхий захирлын зөвлөлийн 2022 оны 10 дүгээр сарын 13-ны өдрийн өргөтгөсөн хурлаас "Гүйцэтгэгч компанийн боловсруулсан ТЭЗҮ-ийг "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын техникийн зөвлөлөөр хэлэлцэх"-ээр шийдвэрлэсний дагуу Техникийн зөвлөлийн 2022 оны 11 дүгээр сарын 02, 04-ний өдрийн хурлаар хэлэлцэж "ТЭЗҮ-ийг засварласны дараа Техникийн зөвлөлөөр дахин хэлэлцүүлж дэмжсэн тохиолдолд УУХҮЯ-ны ЭБМЗ-өөр хэлэлцүүлэх"-ийг гүйцэтгэгч компанид хариуцуулж ажил гүйцэтгэх гэрээний хугацааг 2023 оны 03 дугаар сарын 31-ний өдөр хүртэл сунгасан байна. ТЭЗҮ, нарийвчилсан зураг төсөл боловсруулах ажлын явц 30 хувьтай байна.	УУХҮЯ	30.0
41	3.2.6. Дархан-Сэлэнгийн бүсэд "Монгол ган цогцолбор-1" байгуулах	?	Концессын гэрээ	1,445.8	Засгийн газрын 2022 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн 148 дугаар тогтоолоор Эдийн засгийн хөгжлийн яам /хуучнаар/ болон "Кью Эс Си" ХХК-ийн хооронд 2014 онд байгуулсан "Уул уурхай, металлургийн цогцолбор байгуулах төсөл"-ийг хэрэгжүүлэх Концессын гэрээг цуцалсан. Уг тогтоолын дагуу ТӨБЗГ-аас Дарханы төмөрлөгийн үйлдвэрийг төрийн өмчит компанийн статустай болгож, бүтцийг баталж, удирдлагыг томилсон. "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ТӨҮГ нь Засгийн газрын "Шинэ сэргэлтийн бодлого"-ын Аж үйлдвэрийн сэргэлтийн хүрээнд "Шинэ сэргэлт-Монгол ган" хэлэлцүүлгийг 2022 оны 07 дугаар сарын 04-ний өдөр зохион байгуулсан. Тус компаниас "Монгол ган цогцолбор 1" төслийг хэрэгжүүлэх, ТЭЗҮ-ийг шинэчлэн боловсруулах байгууллага /ААН/-ыг сонгон. Төслийн цахилгаан хангамжийн ТЭЗҮ, зураг төслийг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийлгэх, 2023 оны төсөвт суулгах хүсэлтийг УУХҮС-ын 2022 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн 01/2288 дугаар албан бичгээр Сангийн сайдад хүргүүлсэн.	УУХҮЯ	30.0
42	3.2.7. Эрдэнэтийн төмөрлөгийн үйлдвэрийн цогцолбор байгуулах	?	"Бэрэн групп" ХХК, Хөгжлийн банкны зээл	174.2	Бэрэн групп ХХК-ийн 2014 оноос Орхон аймагт хэрэгжүүлж байгаа 200 мян.тн/жил хүчин чадалтай ган бүтээгдэхүүний үйлдвэрийн төслийн хэрэгжилт 75.0 орчим хувьтай байна. Тус компани нь Монгол Улсын Хөгжлийн банкнаас 2014 онд 22.7 сая ам.доллар, 2018 онд 4.5 сая ам.доллар, нийт 27.2 сая ам.долларын зээлийн санхүүжилт авсан ба үйлдвэр ашиглалтад орж үйл ажиллагаа эхлүүлээгүйн улмаас уг зээл эргэн төлөгдөөгүй байна. Цаашид үйлдвэрийг ашиглалтад оруулахад шаардагдах 30.7 тэрбум төгрөгийн санхүүжилтийг нэмж олгох хүсэлтийг тус компаниас Хөгжлийн банк болон УУХҮЯ-нд гаргасан ба УУХҮЯ болон Хөгжлийн банкны холбогдох удирдлагууд удаа дараагийн уулзалтуудыг зохион байгуулж, боломжит хувилбарыг судалж, ХҮБГ-ын даргын 2022 оны 08 дугаар сарын 16-ны өдрийн 07/2216 дугаар албан бичгийг Хөгжлийн банканд хүргүүлсэн. "Бэрэн групп" ХХК, түүний хамаарал бүхий компаниудын тус банкнаас авсан зээл, өрийн асуудлыг хууль, хяналтын байгууллагаар шийдвэрлүүлэх хүсэлтийг Хөгжлийн банкнаас хүргүүлсэн талаар мэдэгдээд байна. Иймээс төслийн ажил зогсонги байдалд ороод байна.	УУХҮЯ	0.0
43	3.2.8. Дорноговь аймагт байгуулах "Алтан ширээт аж үйлдвэрийн парк"-ийн төсөл	?	"БТЕГ" ХХК	1,197.0	Газрын асуудал (140 га)-ыг бүрэн шийдвэрлэж, 12 км төмөр зам, 6.3 МВт-ын цахилгааны дэд станц, 110 кВ, 10 кВ-ын 9.4 км цахилгаан дамжуулах агаарын шугамууд барьж байгуулсан ба төмрийн хүдрийн нойтон баяжуулах үйлдвэрийг 2021 онд ашиглалтад оруулсан.	УУХҮЯ	50.0

					Нүүрс баяжуулах үйлдвэрийн ТЭЗҮ боловсруулж, ЭБМЗ-ийн хуралдаанаар хэлэлцүүлэн дүгнэлт гаргуулсан. НБҮ-ийн барилгын ажил, тоног төхөөрөмж суурилуулах ажил хийгдэж байна. Паркийн ус хангамжийг шийдэх зорилгоор “Бор хөөвөр”-ийн газрын доорх усны ордын талбайд ус цуглуулах байгууламж байгуулах ажил, ажилчдын 5 блок байр барих, нүүрс ачиж, буулгах талбайн газар, шорооны ажлыг 2022 оны 5 дугаар сард тус тус эхлүүлээд байна. “Монголын эдийн засгийн чуулган 2022”-ын хүрээнд зохиогдсон “Аж үйлдвэрийн сэргэлт” хэлэлцүүлгийн үеэр “Алтан ширээт аж үйлдвэрийн парк”-ийн зарим үйлдвэрийг түүхий эд /коксжих нүүрс/-ээр тогтвортой хангах боломж бүрдүүлэх зорилгоор “Эрдэнэс Тавантолгой” ХК болон “Болдтөмөр Ерөө гол” ХХК-ийн хооронд харилцан ойлголцлын санамж бичиг байгуулсан.		
Зорилт 3.3.Газрын тосны баталгаат нөөцийг өсгөж, олборлолтыг нэмэгдүүлэх замаар дотоодын газрын тос боловсруулах үйлдвэрийг түүхий эдээр хангана.							
44	3.3.1. Газрын тосны бүтээгдэхүүний импортын хараат байдлыг бууруулж, дотоодын түүхий эдэд тулгуурласан газрын тос боловсруулах үйлдвэрийг барьж байгуулан нефть-химийн аж үйлдвэрийн суурийг тавих	Үйлдвэр ашиглалтад орж бүрэн хүчин чадлаар ажилласнаар түлш, шатахууны импортын хамаарлыг бууруулж, нефть-химийн аж үйлдвэрийн шинэ салбар бий болж, улсын төсөвт хувь нэмэр оруулахын зэрэгцээ түлш, шатахууны дотоодын хэрэгцээний 50-60 хувийг хангаснаар гадаад худалдааны алдагдал 1 тэрбум орчим ам.доллараар буурсан байна.	БНЭУ-ын Экспорт-Импорт банкны хөнгөлөлттэй зээл	3,831.6	Технологийн бус барилга байгууламжийн ажил /ЕРС-1/-ын барилга угсралтын ажлын гүйцэтгэл 2022 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн байдлаар 75.0 хувьтай байна. Эдгээрт Түүхий ус хадгалах сав-98.7%, Оффис, сургалтын төв-80.7%, Хоолны газар-89.8%, Лаборатори-89.2%, Эмнэлгийн барилга-83.8%, Агуулах-58.5%, Нэвтрэх хаалга-1-82.8%, Нэвтрэх хаалга-2-56.3%, Гал унтраах ангийн барилга-68.3%, Засварын цех-51.0%, Үерийн ус цуглуулах талбай-82.5%, Ус зайлуулах хоолой-53.0%, Ус дамжуулах хоолой-95%, 17км авто зам-60.6%, Ус дамжуулах хоолой-/Бор хөөвөр/-72.6%, Худгийн барилга-79.7%, Цахилгаан дамжуулах агаарын шугам-96.0%-ийн тус тус гүйцэтгэлтэй. Лицензгүй технологийн байгууламжийн ажил /ЕРС-2/-ын ерөнхий гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах түргэвчилсэн тендерийг 2022 оны 6 дугаар сарын 06-ны өдөр зарласан ба 2022 оны 09 дүгээр сарын 19-ны өдөр тендер хүлээж авсан. Үйлдвэрийн цахилгаан станцын ажил /ЕРС-3/-ын ерөнхий гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах түргэвчилсэн тендерийг 2022 оны 05 дугаар сарын 04-ний өдөр зарласан ба 2022 оны 07 дугаар сарын 04-ний өдөр тендер хүлээн авсан. ЕРС-3 багц ажлын тендерт хамгийн бага үнийн санал ирүүлсэн БНЭУ-ын “Megha Engineering & Infrastructure Limited” (Mera инженеринг инфрастракчер лимитед) компанитай Инженерчлэл, худалдан авалт, барилгын угсралтын гэрээ байгуулах асуудлыг Засгийн газрын 2022 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэсний дагуу “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК, “Megha Engineering & Infrastructure Limited” компани хооронд 2022 оны 10 дугаар сарын 28-ны өдөр гэрээ байгуулсан. Лицензтэй технологийн байгууламжуудыг барих ажил /ЕРС-4/-ын лиценз эзэмшигчдийг шалгаруулсан, Устөрөгчийн байгууламжийн лиценз эзэмшигч Итали Улсын Кинетикс техноложи компанитай, Хүхэр ялгах байгууламжийн лиценз эзэмшигч Франц Улсын Аксенс компани, Бензин боловсруулах, Гидрокрекинг, Дизелийн гидроцэвэрлэгээ, Дизелийн гидроцэвэрлэгээ, Шингэрүүлсэн шатдаг хий ялгах байгууламжуудын лиценз эзэмшигч АНУ-ын ЮӨҮПи Хонивэлл компанитай тус тус гэрээг байгуулсан. Лицензтэй технологийн байгууламжийн Инженерчлэл, худалдан авалт, барилга угсралтын ажлын ерөнхий гүйцэтгэгчийг сонгох	УУХҮЯ	70.0

					тендерийн баримт бичиг боловсруулж байна.		
45	3.3.2. Газрын тосны ашиглалтын баталгаат нөөцийг өсгөж, газрын тос боловсруулах үйлдвэрийг дотоодын түүхий эдээр хангах дамжуулах хоолойг барьж байгуулах	Давст-31 талбайд гадаадын хөрөнгө оруулагчдыг татан оруулж хайгуул, ашиглалтын ажлыг эрчимжүүлсэн байна. Газрын тос дамжуулах 530 км урт хоолойг барьж ашиглалтад оруулснаар тээвэрлэлтийн шинэ технологийг нэвтрүүлсэн байна.	370.0 сая ам.доллар, нүүрс урьдчилан борлуулах гэрээ	1,230.7	Дорноговь аймагт 1,334.66 га, Дорнод аймагт 1,386.2 га газрыг дамжуулах хоолойн хэрэгцээнд зориулан “Улсын тусгай хэрэгцээ”-нд авахыг тус аймгийн ИТХ-аар дэмжсэн шийдвэр гарсан. Сүхбаатар аймгийн ИТХ-ын 12-р сарын хурлаар тус аймагт хамаарах дамжуулах хоолойн газрын асуудлыг хэлэлцүүлэхээр хүлээгдэж байна. Сүхбаатар аймгийн Сүхбаатар сум, Халзан сум, Дорноговь аймгийн Дэлгэрэх сум, Дорнод аймгийн Матад сумын ИТХ-ын шийдвэрээр халаах-өргөх станцуудын хэрэгцээнд газар олгохыг дэмжсэн шийдвэр гарсан. Газрыг гэрчилгээжүүлэхээр газар эзэмших хүсэлт, дагалдах баримт бичгийн бүрдлийг хангаж тус сумдын Засаг дарга болон газрын албанд хүргүүлээд байна. Барилга угсралтын үеийн түр кемпүүдийн барилгын ажлыг эхлүүлээд барилга угсралтын ажил-35%, түр замын ажил-15%, Геодезийн цэг тэмдэгт суулгах ажил-100%, байр зүйн зураглалын судалгааны ажил-100%, мэдээлэл боловсруулах, тайлан бэлтгэх ажил-60%, геотехникийн судалгааны ажил-80%, дээжлэлт шинжилгээ-80%. Тосон-Уул 19, Тамсаг XXI талбайн нэгдсэн байгууламжаас 17.5 л ба 16.7 л дээж авч тосны дээж авсан. Тус дээжийг БНХАУ-ын Шанхай хот дахь Intertek компанийн лабораторид илгээсэн, хариу хүлээгдэж байна. Канад Улсын Ворлэй Инженеринг компани дамжуулах хоолойн Суурь Инженерчлэлийн Загвар (FEED) боловсруулах ажлыг 2022 оны 10 дугаар сарын 15-ны өдрөөс эхлүүлээд ажил-25% байна. БОАЖЯ-аас байгаль орчны ерөнхий үнэлгээний дүгнэлт хийгдсэн. БОННУ хийх ажил 90 хувьтай хийгдэж байна.	УУХҮЯ	90.0
46	3.3.3. Газрын тосны бүтээгдэхүүний чанарын стандарт, хяналтын тогтолцоог сайжруулж, хангамжийг тогтворжуулах	Шинжилгээний лабораториудын хүчин чадлыг сайжруулж, тоног төхөөрөмжийг шинэчлэн олон улсын лабораторийн итгэмжлэлийг авсан байна. Импортлогч аж ахуйн нэгжүүдийн компанийн нөөцийг нэмэгдүүлэх зорилгоор Монголбанктай хамтран ажилласан байна.	-	-	Шатахууны чанарын хэмжилт, судалгааны талаар болон газрын тосны бүтээгдэхүүний чанар, стандартыг сайжруулах эрх зүйн орчны талаар УУХҮЯ-ны Газрын тосны бодлогын газрын мэргэжилтнүүд болон Жайка төслийн шатахууны чанарын хэмжилт хийж буй мэргэжилтэнтэй 2022 оны 08 дугаар сарын 24-ний өдөр уулзаж харилцан санал солилцсон. 2022 оны 04 дүгээр сарын 22-ны өдөр батлагдсан Агаарын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.6 дах хэсэгт “Монгол Улсын стандартаар тогтоосон экологийн хамгийн өндөр ангиллаас доош ангиллын, эсхүл уг ангиллын стандартын шаардлага хангаагүй автобензин, дизель түлшийг жижиглэнгээр худалдан борлуулах” гэж хориглох тухай нэмэлт орсон. Ийнхүү автотээврийн хэрэгслээс ялгаруулах агаарын бохирдлыг үр дүнтэй бууруулахын тулд Агаарын чанарыг сайжруулах бүсэд экологийн Евро-5 ангиллын стандартын шаардлага хангаагүй шатахуун жижиглэнгээр худалдан, борлуулахыг хориглох эрх зүйн орчин бүрдсэн. Экологийн өндөр ангилал бүхий Евро-5 стандартын шатахууны хэрэглээ байнга нэмэгдэж, 2022 оны эхний хагас жилийн байдлаар 165.6 мянган тонн байгаа нь нийт импортолсон шатахууны 21.3 хувийг эзэлж байна. Мөн газрын тосны бүтээгдэхүүний чанар, стандарт, хяналтын тогтолцоог сайжруулах, бэхжүүлэх, эрх зүйн орчныг сайжруулах хүрээнд туршлага судлах, шатахууны чанар, стандартыг сайжруулахад хамтарсан судалгаа хийх, техникийн зөвлөгөө өгөх, гүйцэтгэлийн үнэлгээ хийх, техник, технологийн чиглэлээр санамж бичгийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам болон Бүгд Найрамдах Солонгос Улсын Газрын тосны чанар, хангамжийн газар (К-Петро)-тай 2022 оны 8 дугаар сарын 10-ны өдөр Улаанбаатар хотноо байгуулсан. 2022 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн байдлаар нийт 1.54 сая тонн газрын тосны бүтээгдэхүүн импортолсон. Үүнд: Автобензин А-80 29.2 мянган тонн, АИ-92 500.9 мянган тонн, АИ-95, 98 20.6 мянган тонн, дизель түлш 788.2 мянган тонн, онгоцны түлш ТС-1 30.5 мянган тонн байна. Хангамж,	АМГТГ	90.0

					нийлүүлэлт тогтвортой байна. Улсын хэмжээнд А-80 автобензин 33, Аи-92 автобензин 27, АИ-95 автобензин 32, дизель түлш 20, ТС-1 онгоцны түлш 34 хоногийн ердийн хэрэглээтэй тэнцэх үлдэгдэл нөөцтэй байна.		
Зорилт 3.4.Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэвшилтэт техник, технологи, инновацад тулгуурлан хөгжүүлж, шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ, үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлнэ.							
47	3.4.1. Мал аж ахуйн гаралтай түүхий эдийн анхан шатны боловсруулалтын түвшнийг сайжруулж, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх	Арьс ширний боловсруулалтын түвшнийг 60 хувьд хүргэх замаар малын гаралтай бүтээгдэхүүний үнийг тогтворжуулж, малчдын бодит орлого нэмэгдсэн байна. Экспортыг 232.7 сая ам.доллараар нэмэгдүүлж, 32.7 тэрбум төгрөгийг улсын төсөвт татан төвлөрүүлнэ. Жилдээ 4.5 сая ширхэг арьс, шир боловсруулах 5 үйлдвэр, дагалдах 3 үйлдвэр байгуулагдаж, нийтдээ 2.4 мянган ажлын байрыг бий болгосон байна.	Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ	0.3	Засгийн газрын 2022 оны 09 дүгээр тогтоолоор Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-аас 50.0 тэрбум төгрөгийн санхүүжилтийг нийгмийн хариуцлагын хүлээн тус цогцолборын бүтээн байгуулалтад зориулан гаргахаар шийдвэрлэсэн. Цогцолборын бүтээн байгуулалтыг эхлүүлэх бэлтгэл ажлын хүрээнд ТЭЗҮ, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, байгаль орчин, нийгмийн нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ, түр цахилгаан хангамж, түр худаг, түр оффисын барилгын ажлыг хийж гүйцэтгээд байна. Мөн Дархан-Уул аймгийн Хонгор сумын Засаг даргын 2022 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн А/130 дугаар захирамжаар олгосон 25 га газар олгосон. Үйлдвэрийн барилгын зураг төсөл боловсруулах ажил 80.0 хувь, дэд бүтцийн ажлын зураг төсөл боловсруулах ажил 40.0 хувь, цэвэрлэх байгууламжийн ажлын зураг төсөл 30.0 хувийн гүйцэтгэлтэй тус тус хийгдэж байгаа бөгөөд үйлдвэрийн барилгын ажлын зургийг Италийн талд хүргүүлж хянуулахаар хамтран ажиллаж байна. Улсын Их Хурлын Үйлдвэржилтийн бодлогын Байнгын хорооны 2022 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн хурлаар цогцолборын ажлын явцын мэдээллийг танилцуулсан. Тус хурлаас Засгийн газарт чиглэл хүргүүлэх тухай Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны 08 дугаар тогтоол батлагдсан. Улсын Их хурлаас төрийн байгууллага хоорондын уялдаа холбоог хангах замаар Монгол Улсын Хөгжлийн банкны санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрийн үр ашгийг нэмэгдүүлэх, зээлийн чанарыг сайжруулах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг үүрэг болгосны дагуу Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам болон Монгол Улсын Хөгжлийн банк хооронд салбарын хамтын ажиллагааг дэмжих чиглэлээр ажиллах үүрэг бүхий хамтарсан ажлын хэсгийг байгуулан ажиллаж байна.	ХХААХҮЯ	30.0
48	3.4.2. Баруун бүсэд мал аж ахуйн гаралтай түүхий эдийн анхан шатны боловсруулалтын түвшнийг сайжруулж, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний үнэ цэнийг нэмэгдүүлэх	Баруун бүсийн эдийн засаг, нийгмийн хөгжил, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлж, дэвшилтэт техник, технологи бүхий 19 үйлдвэр баригдсан байна. Нийт 51.8 сая ам.долларын экспорт бий болсон байна. Улсын төсөвт 30 орчим тэрбум төгрөгийн татвар, хураамж төвлөрүүлсэн байна. Өдөрт 200 бод, 500 бог төхөөрөх, өдөрт 5000 литр сүү боловсруулах, жилд 3000 тн ноос, 300 тн ноолуур, жилд 600000	-	-	Монгол Улсын 2022, 2023 оны төсөвт нийт 19.2 тэрбум төгрөгийн санхүүжилтийг дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажилд зориулан тусгаад байна. Тус санхүүжилтээр авто зам, цахилгаан хангамж, дулаан хангамж, холбоо хангамж, инженерийн шугам сүлжээ, арьс ширний цэвэрлэх байгууламж зэрэг 6 багц ажлын нээлттэй тендер шалгаруулалтыг 2022 онд зарлан гүйцэтгэгчдийг сонгон шалгаруулан гэрээ байгуулан ажиллаж байна. Гэрээний дагуу холбоо хангамж, цахилгаан хангамж, авто зам, инженерийн шугам сүлжээний ажлын зураг төсөл 90.0 хувийн гүйцэтгэлтэй хийгдэж байгаа бөгөөд мэргэжлийн байгууллагаар магадлал хийлгэхээр ажиллаж байна. Цэвэрлэх байгууламж, дулаан хангамжийн ажлын зураг төсөл 50.0 хувийн гүйцэтгэлтэй хийгдэж байна. УИХ-ын Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны 2022 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн хурлаар үйлдвэрлэл, технологийн паркийн ажлын явцын талаарх мэдээллийг танилцуулсан. Тус хурлаас үйлдвэрлэл, технологийн паркийн талаар хэрэгжүүлэх арга хэмжээний тухай Засгийн газарт чиглэл хүргүүлэх тухай 8 дугаар тогтоол баталсан. Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн А/463 дугаар тушаалаар Захиалагчийн хяналт тавих гэрээг Ховд аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газартай байгуулахаар шийдвэрлэсний дагуу тус газарт гэрээний төслийг хүргүүлээд байна.	ХХААХҮЯ	30.0

		ширхэг арьс, шир боловсруулах хүчин чадалтай үйлдвэрүүд баригдсан байна.					
49	3.4.3. Махны үйлдвэр, хорио цээрийн бүс бүхий 4 цогцолбор байгууламж барих, технологийн шинэчлэл хийх, малын гаралтай бүтээгдэхүүнийг олон улсын стандартад нийцүүлэн бэлтгэх	Жилд 640 мянган толгой бог, 101 мянган толгой бод малыг эдийн засгийн эргэлтэд оруулж, малчдын эдийн засгийн байдал сайжирч орлого нэмэгдсэн байна. Мах, махан бүтээгдэхүүний экспортын хэмжээ 21 мянган тонноор нэмэгдсэн байна. Дотоодын арьс, шир боловсруулах үйлдвэрүүдийг олон улсын стандартад нийцсэн түүхий эдээр хангах нөхцөл бүрдсэн байна.	-	-	Бүгд Найрамдах Хятад Ард Улсын 1.0 тэрбум ам.долларын хөнгөлөлттэй зээлийн хүрээнд санхүүжих Хорио цээрийн бүс бүхий махны үйлдвэр технологийн шинэчлэл хийх" нийт 78.0 сая ам.долларын өртөг бүхий төсөл хэрэгжих 4 байршилд байгаль орчны төлөв байдлын ерөнхий үнэлгээг хийж гүйцэтгэсэн. Төсөл хэрэгжих 4 байршлын газрын гэрчилгээг холбогдох орон нутгийн газрын албанаас ирүүлж байршил тус бүр дээр байгаль орчны төлөв байдлын ерөнхий үнэлгээг хийж гүйцэтгэсэн. 2022 оны 07 дугаар сарын 22-ны өдрийн 01/2355 болон 2022 оны 08 дугаар сарын 05-ны өдрийн 01/2447 дугаар албан бичгүүдээр Сангийн сайдад тус төслийг цаашид хэрхэн хэрэгжүүлэх талаар Засгийн газрын холбогдох шийдвэрийг гаргуулан хамтран ажиллах тухай албан бичгийг хүргүүлээд байна.	ХХААХҮЯ	30.0
50	3.4.4. Сэлэнгэ, Хөвсгөл, Дархан-Уул аймаг, нийслэлд төрөл бүрийн шахмал хавтан, модон бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэх	Жилдээ 50000 куб метр модыг эдийн засгийн эргэлтэд оруулж, шахмал модлог хавтангийн дотоодын зах зээлийн 70 хувийг хангаж, экспортод үйлдвэрлэлийн 37 хүртэлх хувийг нийлүүлсэн байна. 2500 ажлын байр бий болсон байна.	-	-	1. Ойн тухай хуульд төрөл бүрийн шахмал модлог хавтан, модон бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд шаардлагатай заалтыг нэмэлтээр тусгаж хуулийн төслийг боловсруулсан. Тус хуулийн төслийг БОАЖЯ-аас ЗГХЭГ-т хүргүүлээд байна. 2. Төрөл бүрийн шахмал модлог хавтан, модон бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, холбогдох төсвийг боловсруулан "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгуулсан. Стратеги төлөвлөгөөний төслийг БОАЖЯ-аас төрийн болон төрийн бус байгууллага, судалгаа шинжилгээний байгууллагын төлөөллийг оролцуулсан хэлэлцүүлэг, уулзалтыг зохион байгуулан ажиллаж байна. 3. Жижиг дунд үйлдвэрийг дэмжих сангаас 2022 онд зээл олгох салбарын жагсаалтад Модлог хавтан, фанерын үйлдвэрийн төслүүдийг оруулан батлуулав. Төсөлд хамрагдах хавтан үйлдвэрлэлийн чиглэлийн жишиг төсөл, шаардлагатай мэдээллийг бэлтгэн Нийслэл, Сэлэнгэ, Дархан-Уул, Хөвсгөл аймгийн ХХААГ, мэргэжлийн холбоод, сонирхогч ААНБ-дад хүргүүлэн мэдээллээр ханган ажилласан. Жижиг дунд үйлдвэрийг дэмжих сангийн зээлд хамрагдахаар модлог хавтан, фанерын үйлдвэрийн нийт 21 ААНБ төслөө боловсруулан, 3.5 тэрбум төгрөгийн санхүүжилтийн хүсэлтийг хүргүүлсэн. Төслийн шалгаруулалтын үр дүнд 2 аж ахуйн нэгжийн модлог хавтан үйлдвэрлэлийн төсөл дэмжигдсэн. 4. Сэлэнгэ, Хөвсгөл, Дархан-Уул, Нийслэлд төрөл бүрийн шахмал, хавтан, модон бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэх үйл ажиллагааны танилцуулга мэдээллийг бэлтгэн, хөрөнгө оруулалтын саналын хамтаар төсөл хэрэгжүүлэх боломжтой сонирхогч талуудад танилцуулан ажиллаж байна. -Хөвсгөл ой модны цогцолбор	ХХААХҮЯ	50.0

					үйлдвэрийн төслийг хамтран хэрэгжүүлэх сонирхогч тал болох "Премиум групп", "Шинэ санаа" ХХК-ийн удирдлагатай холбогдох уулзалтуудыг хийж, Хөвсгөл мод боловсруулах цогцолбор үйлдвэрийн төслийг танилцуулан, хамтран хэрэгжүүлэх боломжийг хэлэлцэв. - ОХУ-ын Красноярск муж, Тувагийн БНУ-аас модон бүтээгдэхүүн нийлүүлэх дамжуулан тээвэрлэх асуудлаар хамтран ажиллах талаар мэдээлэл солилцон ажиллав. - Импортоор оруулах бөөрөнхий мод, гуалин, зүсмэл материалыг "Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай" хуулийг шинэчлэн батлуулахаар БОАЖЯ-тай хамтран ажиллаж байна. Хуулийн үзэл баримтлалыг боловсруулж эхэлсэн бөгөөд ажлын даалгаварт модон бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн салбарын саналыг тусгуулан батлуулсан. Мөн 2021 оны 05 дугаар сарын 10-ны өдөр батлагдсан импортоор оруулж байгаа хөдөө аж ахуйн зориулалттай шинэ трактор, комбайн, машин механизм, усалгаа, хүлэмжийн тоног төхөөрөмж, ойн болон шувууны аж ахуйн техник, тоног төхөөрөмж, бордоо, ургамал хамгааллын бодисыг гаалийн албан татвараас хөнгөлөх тухай хуулийн үйлчлэх хугацаа дууссантай холбогдуулан хөнгөлөлтийг сунгуулах асуудлаар БОАЖЯ-хамтран холбогдох судалгааг эхлүүлээд байна. - Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийг дагалдан Хүнс, хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд боловсруулах үйлдвэрийн зориулалттай, шинэ тоног төхөөрөмжийг импортын барааны гаалийн албан татвараас хөнгөлөх тухай хууль батлагдсаны дагуу тавилга, мод боловсруулах үйлдвэрлэлийн салбарын гаалийн албан татвараас чөлөөлөгдөх тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийн жагсаалтыг боловсруулан мэргэжлийн холбоод, үйлдвэр аж ахуйн нэгжүүдээс санал авч байна. 5. Германы хамтын ажиллагааны байгууллагын санхүүжилтээр Монголын ой модны үйлдвэрлэл эрхлэгчдийн холбооны хэрэгжүүлж буй Сэлэнгэ, Хэнтий аймгийн модны үйлдвэрлэл эрхлэгч аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн нэмүү өртгийн судалгааны ажилд модлог хавтан, фанер үйлдвэрлэлийн төслийг хамруулаад байна. - БОАЖЯ, Азийн хөгжлийн банк хамтран хэрэгжүүлж буй "Ойн салбарын хөгжлийн хөтөлбөрийн техникийн туслалцаа"-ны төслийн "Монгол оронд ойн тогтвортой менежментийг хэрэгжүүлэх замын зураглал"-д мод боловсруулах, тавилга үйлдвэрлэлийн салбарын үйлдвэр аж ахуйн нэгжүүдийг чанарын шаардлага хангасан түүхий эдээр тогтвортой хангах, "Шинэ сэргэлтийн бодлого"-д туссан шахмал хавтан, түлш үйлдвэрлэлийг дэмжих асуудлуудыг тусгуулсан.		
Зорилт 3.5. Хөдөө аж ахуйн түүхий эд, бүтээгдэхүүний нөөцтэй уялдуулан боловсруулах үйлдвэрийн хүчин чадлыг нэмэгдүүлэх замаар хагас боловсруулсан бүтээгдэхүүний экспортын хувь хэмжээг бууруулан нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлнэ.							
51	3.5.1. Боловсруулах үйлдвэрийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, экспортын худалдааны эргэлтийн болон хөрөнгө оруулалтад зориулсан нэн хөнгөлөлттэй санхүүгийн дэмжлэг үзүүлэх	Дотоодын үйлдвэрүүдийн түүхий эд бэлтгэл болон бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хэмжээг 2 дахин нэмэгдүүлж, суурилагдсан хүчин чадлын ашиглалтыг 80-аас багагүй хувьд хүргэсэн байна.	-	-	1. Засгийн газрын 2022 оны 117, 144 дүгээр тогтоолоор 2021 оны 42 дугаар тогтоолоор баталсан "Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10.0 их наядын цогц төлөвлөгөө"-ний хүрээнд Арилжааны банкуудаар дамжуулан 2022 оны 12 дугаар сарын байдлаар ноолуур бэлтгэл, үйлдвэрлэлийн зориулалтаар 31 ААН-д 106.96 тэрбум, ноос бэлтгэл, үйлдвэрлэлийн зориулалтаар 8 ААН-д 8.01 тэрбум, арьс шир бэлтгэл, үйлдвэрлэлийн зориулалтаар 6 ААН-д 4.95 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг тус тус олгосон. 2. Хөнгөн үйлдвэрийн салбарын экспортын хэмжээ 2022 оны 10 дугаар сарын байдлаар өмнөх оны мөн үетэй харьцуулахад 282.3 сая ам.доллараас 457.4 сая ам.доллар болж, 62.0 хувиар өссөн байна.	ХХААХҮЯ	30.0

52	3.5.2. Халал аргаар боловсруулсан махны зах зээлд нэвтрэх, экспортын зах зээлийг тэлэх	Хоёрдогч зах зээлд бүтээгдэхүүн экспортлон, нийлүүлэлтийг тогтворжуулж, нэгж бүтээгдэхүүний борлуулалтын үнийг өсгөнө. Махны экспортыг эхний жилд 10 мянган тоннд хүргэж, жил бүр экспортыг 5 мянган тонноор нэмэгдүүлсэн байна.	-	-	1. ОУСК-ийн “Монгол мах” төсөл, “Монголын махны экспортын төв” ТББ-тай хамтран Гуравдагч зах зээлд мах, дайвар бүтээгдэхүүн, түүхий эд гаргах боломжийн талаар Иран, Турк, Азербайжан, Арабын Нэгдсэн Эмират улсын аж ахуйн нэгжийн төлөөлөлтэй экспортод учирч байгаа саад, бэрхшээлийг даван туулахад төр, хувийн хэвшлийн цаашдын хамтын ажиллагааны талаар санал солилцох уулзалтыг 2022 оны 06 дугаар сард зохион байгуулсан. 2. “Монголын махны экспортын төв” ТББ-тай халал аргаар мал төхөөрөх үйлдвэрлэгч нарыг оролцуулсан уулзалтыг 3 удаа зохион байгуулж, нийт 50 гаруй үйлдвэрлэгчийг хамруулав. Тус байгууллагаас Ойрд Дорнод болон Зүүн өмнөд Азийн улс орнуудад хурга экспортлоход тавих шаардлага, нийлүүлэлтийг тогтвортой бий болгох боломж, Монгол Улсын эдийн засагт үзүүлэх эерэг нөлөөллийг сурталчлах зорилгоор богино хэмжээний шторк, нэвтрүүлэг бэлтгэн олон нийтийн телевизээр нэвтрүүлсэн. 3. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга энэ оны 8 дугаар сард Иран Улсын Аж үйлдвэрийн дэд сайд болон төрийн бус байгууллага, Лалын холбоо, бизнесийн төлөөлөлтэй уулзалт зохион байгуулж, Монгол Улсаас халал аргаар бэлтгэсэн мах экспортлох боломж, өнөөгийн нөхцөл байдал, хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал солилцсон. 4. Экспортыг дэмжих төслийн хүрээнд Монгол Улсын итгэмжлэл, тохирлын үнэлгээний чадамжийг дээшлүүлэх, Үндэсний итгэмжлэлийн төвийн үйл ажиллагааг халал бүтээгдэхүүний итгэмжлэл, баталгаажуулалтын чадавхыг нэмэгдүүлэх, ОУ-д хүлээн зөвшөөрүүлэх чиглэлээр ажиллаж байна. НҮБ-ын АҮХБ-ын техникийн туслалцаатайгаар Арабын Нэгдсэн Эмират Улсын олон улсын итгэмжлэлийн төвтэй “Халал итгэмжлэлийн чиглэлд хамтран ажиллах гэрээ” байгуулахаар тохиролцож, 2022 оны 9 дүгээр сард хоёр талын хамтарсан уулзалтыг цахимаар зохион байгуулсан. Уг гэрээг байгуулснаар Монгол Улсын Үндэсний итгэмжлэлийн төвийн шинжээчдийг АНЭУ-ын Олон улсын итгэмжлэлийн төвд сургалт сургалтад хамруулж, дадлагажуулах, хамтарсан итгэмжлэлийн үйл ажиллагааг зохион байгуулах боломжтой юм. Өнөөдрийн байдлаар Монгол Улсад Үндэсний итгэмжлэлийн төвөөр ISO 17065 стандартын дагуу итгэмжлэгдсэн хөндлөнгийн Халал баталгаажуулалтын байгууллага байхгүй тул энэ чиглэлийн баталгаажуулалтын байгууллагыг албан ёсны үйл ажиллагаа явуулдаг болоход дэмжлэг үзүүлэн ажиллаж байна.	ХХААХҮЯ	50.0
53	3.5.3. Төмөр замын боомтоор мах, махан бүтээгдэхүүнийг тээвэрлэх нөхцөлийг бүрдүүлэх /зориулалтын вагон/, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын боомтын зөвлөлтэй гэрээ, хэлэлцээр байгуулах замаар мах, махан бүтээгдэхүүнийг экспортлох боломжийг хэлэлцэх	Бүгд Найрамдах Хятад Ард Улс руу жил бүр 50 мянган тонн махыг стандартын дагуу экспортлох боломжийг бүрдүүлж, найдвартай тээвэрлэлтийн сүлжээг бий болгож, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын гүн рүү тээвэрлэлт хийн, тээврийн зардал буурах нөхцөлийг	-	-	Монгол Улсаас БНХАУ-д төмөр замын боомтоор мах, махан бүтээгдэхүүн экспортлох нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр арга хэмжээ авч, хамтран ажиллах тухай албан тоотыг Зам тээврийн хөгжлийн яам, Гадаад харилцааны яаманд тус тус хүргүүлсэн.	ХХААХҮЯ, ЗТХЯ	0.0

54	3.5.4. Адууны дайвар түүхий эдийг экспортлох, импортлох үеийн хорио цээр, мал эмнэлэг, ариун цэврийн шаардлагын тухай протоколыг Бүгд Найрамдах Хятад Ард Улстай байгуулах	бүрдүүлсэн байна. Малын гаралтай экспортын бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээ нэмэгдсэн байна.	-	-	ХХААХҮЯ: 1. БНХАУ-д адууны дайвар түүхий эдийг экспортлох, импортлох үеийн хорио цээр, мал эмнэлэг, ариун цэврийн шаардлагын тухай протоколын төслийг урьдчилсан байдлаар боловсруулж, БНХАУ-ын Гаалийн ерөнхий газарт хүргүүлсэн. 2. Монгол-Хятадын Хүнсний бүтээгдэхүүний экспорт, импортын аюулгүй байдлын хамтын ажиллагааны Дэд сайд нарын түвшний 6 дугаар хуралдааныг 2022 оны 12 дугаар сард багтаан зохион байгуулахаар төлөвлөж, энэхүү уулзалтын ярианы сэдэвт хүлээгдэж буй протоколуудын асуудлыг хэлэлцэхээр санал боловсруулж байна. ЭМЯ: Монгол Улсын Шадар сайдын 2022 оны 30 дугаар тушаалаар “MNS 6648:2016, Хүнсний бүтээгдэхүүний сав боодлын шошгололтод тавих шаардлага стандартад нэмэлт өөрчлөлт оруулах” ажлын хэсгийг баталсан. Тушаалын дагуу Эрүүл мэндийн сайдын 2017 оны “Хүнсний сав, боодлын нүүрэн хэсэгт шим тэжээлийн мэдээлэл байршуулах” зааврыг шинэчлэн боловсруулж, төсөлд санал авахаар ХХААХҮЯ, МХЕГ, ШУТИС, СХЗГ, ШӨХТГ, МХХ зэрэг 6 газарт 2/2018 дугаар албан бичиг хүргүүлж ирүүлсэн саналыг нэгтгэж танилцуулсан ч уулзалтын шийдвэрээр манай орны хувьд хүнсний бүтээгдэхүүний нүүрэн хэсэгт шим тэжээлийн мэдээллийг заавал байршуулан мөрдүүлэх нөхцөл бүрдээгүй, хууль эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох нь зүйтэй гэж үзсэн тул хойшлуулахаар шийдвэрлэсэн. Мөн “Хүнсний сав боодлын шошгололтод тавих шаардлага” MNS 6648:2016 стандартад нэмэлт өөрчлөлт оруулах ажлын хүрээнд Стандарт хэмжил зүйн газартай хамтран ажиллаж, Хүнсний стандартын техникийн хорооны хурлаар тус стандартад тусгагдсан хүнсний бүтээгдэхүүний шим тэжээлийн мэдээллийг шошгонд байршуулж болно гэснийг заавал байршуулах болгож өөрчлөх асуудлыг хэлэлцэж олонхийн саналаар дэмжигдээгүй тул хойшлогдсон.	ХХААХҮЯ, ЭМЯ	50.0
55	3.5.5. Төрөөс ноос ноолуур, арьс шир, мах болон экспортын ач холбогдол бүхий бусад түүхий эдийн нэгдсэн агуулах болон тээвэр, логистикийн дэд бүтцийг сайжруулах арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлэх	Экспортын ач холбогдол бүхий түүхий эд, бүтээгдэхүүний нэгдсэн агуулах болон тээвэр, логистикийн дэд бүтцийг сайжруулсан байна.	-	-	Агуулахын нэгдсэн стандарттай болох, 21 аймгийн 309 суманд биржийн арилжаанд оролцох агуулахад биржийн итгэмжлэл олгох гэсэн үндсэн зорилт тавин ажиллаж байна. Үүнд: 1. Малын гаралтай арьс шир, ширхэгт түүхий эдийн агуулахын үйл ажиллагаанд тавих ерөнхий шаардлага бүхий Монгол улсын стандартыг боловсруулах, батлуулах: -Стандартын төсөлд холбогдох байгууллага болон олон нийтээс санал авахаар Төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоод, их дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагаас санал авахаар СХЗГ-ын 2022 оны 09 дүгээр сарын 06-ны өдрийн 01/697 тоот албан бичгийг хүргүүлж, санал авахаар www.estandart.gov.mn цахим хуудаст байршуулсан. 2022 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн Стандартчиллын техникийн хорооны хуралдаанаар стандартын төслийг хэлэлцүүлж, батлуулсан. 2. 21 аймгийн 309 суманд биржийн арилжаанд оролцох агуулахад биржийн итгэмжлэл олгох: - Сумдын удирдлага болон хоршоод, хувь хүмүүст мэдээлэл хүргүүлж, сургалт зохион байгуулж ажилласны үр дүнд нийт 17 аймгийн 83 сумын 12 иргэн, 17 аж ахуйн нэгж, 77 хоршооны агуулахтай итгэмжлэлийн гэрээ байгуулан хамтран ажиллаж байгаа бөгөөд нийт итгэмжлэлийн гэрээ байгуулах ажил 34.0 хувьтай явж байна. Тус ажлын хүрээнд мэдээлэл хүргэх, уулзалт хийх, сургалт зохион байгуулах чиглэлээр 2022 онд “ХААБ”	ХХААХҮЯ	70.0

					ХХК нь аймгуудын Хүнс Хөдөө Аж Ахуйн Газартай хамтран биржийн үйл ажиллагааг сурталчлан таниулах, сургалт уулзалтыг 17 аймагт /томилолтоор орон нутагт ажиллаж/ зохион байгуулж, 115 хоршоонд зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж 69 хоршоог биржийн байнгын бус гишүүнээр бүртгэж, гэрээ байгуулсан. Сургалт уулзалтад аймгуудын ХХААГ-ын мэргэжилтэн, ААН, хоршоод, малчдын төлөөлөл нийт 1,018 иргэн хамрагдсан.		
Зорилт 3.6.Шинжлэх ухаанд суурилсан өндөр технологи, блокчейн, хиймэл оюун ухааны ололтыг нэвтрүүлж, дижитал эдийн засгийн чиг хандлагад нийцсэн аж үйлдвэржилтийг хөгжүүлнэ.							
56	3.6.1. Инновац, Аж үйлдвэрийн IV хувьсгал, хиймэл оюун, блокчейн зэрэг технологийн хөгжилд түшиглэсэн шинжлэх ухааны салбарыг хөгжүүлэх хүний нөөцийг бүрдүүлэх	Мэдээллийн технологийн салбарын бүтээгдэхүүний экспорт нэмэгдсэн байна.	-	-	БШУЯ: 2022-2023 оны хичээлийн жилд дотоодын их, дээд сургуульд компьютерын сүлжээ мэргэжлээр 81, компьютер-хэл шинжлэл мэргэжлээр 1, компьютерын ухаан мэргэжлээр 54, мэдээллийн систем мэргэжлээр 81, мэдээллийн технологи мэргэжлээр 166, мэдээлэл зүй мэргэжлээр 19, өгөгдлийн ухаан мэргэжлээр 27, программ хангамж мэргэжлээр 633, системийн аюулгүй байдал мэргэжлээр 82, сүлжээний технологи мэргэжлээр 25, утасгүй холбоо мэргэжлээр 26 буюу нийт 1,195 оюутан оюутны хөгжлийн зээлээр суралцаж байна. Боловсролын зээлийн сангийн санхүүжилтээр 2022 онд шинээр 33 оюутан харилцаа холбоо, мэдээллийн технологийн чиглэлээр гадаадын 8 улсад суралцаж байна. Засгийн газрын 2020 оны “Боловсролын зээлийн сангийн талаар авах арга хэмжээний тухай” 70 дугаар тогтоолоор “Монгол Улсад шаардлагатай тэргүүлэх чиглэлийн мэргэжлийн жагсаалт”-ыг баталсан бөгөөд түүнд Мэдээлэл, харилцаа холбооны технологийн чиглэлээр “Утасгүй холбоо”, “Өгөгдлийн ухаан”, “Системийн аюулгүй байдал” “Хиймэл оюун ухаан” гэсэн 4 мэргэжлээр бакалаврын болон магистрын зэргийн сургалт багтсан. БШУ-ны сайдын 2021 оны "Шинэ мэргэжлээр сургалт эрхлэх тусгай зөвшөөрөл олгох тухай" А/174 дүгээр тушаалаар ШУТИС-д Мультимедиа технологи, өгөгдлийн сан, хиймэл оюун ухаан, IoT технологи, робот ба хиймэл оюун ухаан, Ухаалаг сүлжээ гэсэн мэргэжил шинээр нээж 2021-2022 хичээлийн жилд элсэлт авч, мэргэжилтэн бэлтгэж эхэлсэн. Дээд боловсролын салбарын 2022-2023 хичээлийн жилийн статистик мэдээллээр их, дээд сургуулиудад мэдээлэл харилцаа, холбооны технологийн салбарын чиглэлийн 10,660 оюутан 22 мэргэжлээр суралцаж байна. Үүнээс: системийн аюулгүй байдал-578, кибер аюулгүй байдал-139, өгөгдлийн ухаан-111, виртуал сургалтын систем-5, IT технологи/зүйлсийн интернэт-79, хиймэл оюун ухаан-104 оюутан суралцаж байна. Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны А/160 дугаар тушаалаар дээд боловсролын сургалтын байгууллагын мэргэжлийн чиглэл, индекс шинэчлэн батлагдсан. Үүнд: Мэдээлэл, харилцаа холбооны технологийн хиймэл оюун ухаан, өгөгдлийн ухаан, мэдээллийн аюулгүй байдал зэрэг, IoT зэрэг 13 мэргэжлийн индекс батлагдсан. БНЭУ-ын санхүүжилтээр хэрэгжиж буй Мэдээллийн технологи, аутсорсингийн төслийн 2 дугаар багц нь Мэдээлэл, харилцаа холбооны технологийн инженер, оюутан залуус, багш нарын чадавхыг бэхжүүлэх дээрх хөтөлбөрүүд багтсан нийт 16 хөтөлбөрөөр онлайн сургалт зохион байгуулагдахаас 2022 оны 6-11 дүгээр сард Linux Training, DATA Visualization, AI & ML, DATA Analytics, VMware, iOS, Java, Soft Skills, Soft Test, BPO гэсэн 10 онлайн сургалтыг ШУТИС-ийн МХТС дээр зохион байгуулж, 386 суралцагч хамрагдсан. 2022 оны 11-12 дугаар сард БНЭУ-д зохион байгуулсан Data Analytics, Cyber Security сэдвээр 45 хоногийн танхимын сургалт зохион байгуулагдаж 28 хүн хамрагдсан.	БШУЯ, ЭМЯ	100.0

					ЭМЯ: Дэлхийн банкны санхүүжилттэй “Цахим эрүүл мэнд” төслийн хүрээнд мэдээлэл солилцооны платформд өгөгдөл солилцох стандартыг боловсруулсан. Ингэснээр өгөгдөл солилцооны платформ ННЕР-д эрүүл мэндийн бүх байгууллага дээрх стандартыг мөрдөж хоорондоо холбогдон ажиллаж мэдээлэл солилцох боломж бүрдсэн.		
ДӨРӨВ.ХОТ, ХӨДӨӨГИЙН СЭРГЭЛТ							
Зорилт 4.1.Нийслэл Улаанбаатар хотын нийтийн тээврийн чанар, стандартыг сайжруулан багтаамж ихтэй шинэ төрлийн нийтийн тээврийн хэрэгслийг үйлчилгээнд нэвтрүүлж, гол ба үндсэн авто зам, замын байгууламжийн сүлжээг өргөтгөн шинэчилж, олон түвшний уулзварыг байгуулан хүртээмжийг нэмэгдүүлж, авто замын түгжрэлийг бууруулна.							
57	4.1.1. Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулахад нөлөө үзүүлэх үндсэн ба гол авто замын сүлжээг хөгжүүлэх, өргөтгөх, шинэчлэх	Авто замын түгжрэлийн индекс 15-20 хувиар буурч, авто замын нэвтрүүлэх чадвар 35 хувиар сайжирсан байна.	-	-	Улаанбаатар хотын гол болон туслах гудамж замыг шинээр барих, өргөтгөн шинэчлэх хүрээнд Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулахад нөлөө үзүүлэх үндсэн ба гол авто замын сүлжээг хөгжүүлэх чиглэлээр 2022 онд Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 13 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлж, авто замыг шинээр барихаар төлөвлөсөн. Үүнээс Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн “Нийслэлийн 2022 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай” тогтоолоор 2 төсөл арга хэмжээ татагдсан. 11 төсөл арга хэмжээнээс 4 төсөл арга хэмжээ хэрэгжсэн, 6 төсөл арга хэмжээний барилга угсралтын ажил үргэлжилж, 1 төсөл арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг зарласан. Ажил эхэлсэн зам барилгын ажлын явц: 1. Эрчим хүчний гудамжнаас “Монос Фарм Трейд” ХХК хүртэлх Таван толгой түлш ХХК-ийн зүүн талаар шинээр хийгдэх 1.7 км авто замын ажил-100 хувь хэрэгжсэн. 2. Номин Юнайтед их дэлгүүрийн баруун талын авто замаас Б.Шаравын гудамж хүртэлх 0.86 км авто замын ажил 100 хувь хэрэгжсэн. 3. Чингисийн өргөн чөлөөнөөс баруун Үйлдвэрийн гудамж хүртэлх 1.23 км авто зам, 33 у/м гүүрийн барилгын ажил-42 хувьтай байна. 4. Гачууртын авто замаас Шар хадны автобусны эцсийн зогсоол хүртэлх 4.27 км авто зам, Улиастай голын 97.3 у/м төмөрбетон гүүрийн ажил-40 хувийн хэрэгжилттэй байна. 5. “Наадамчдын авто замаас Энхтайваны өргөн чөлөө хүртэлх 3.5 км авто замын гүүрийн барилга 483.1 у/м”-35 хувьтай байна. 6. Хайгуулчдын гудамж болон Хүнсчдийн гудамжны дагуу шинээр барих болон шинэчлэх авто замын ажил-100 хувийн хэрэгжсэн. 7. Ээрмэлийн гудамжийг Туул гол гудамжтай холбох авто замын ажил-87 хувийн хэрэгжилттэй байна. 8. Улаанхуарангийн гудамжнаас 68-р сургуулийн баруун талаар Цагдаагийн академийн өргөн чөлөөтэй холбох зам-98 хувийн хэрэгжилттэй байна. 9. Дунд голын арын Алтай хотхоны урд талын авто замын ажлууд-3 хувийн хэрэгжилттэй байна. 10. Зайсангийн 225 у/м төмөрбетон гүүрийн өргөтгөл, шинэчлэлтийн ажил-10 хувийн хэрэгжилттэй байна. 11. Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/523 дугаартай захирамжаар 11 байршилд нийт 35.2 км гол болон туслах гудамж замын зураг төслийг боловсруулж байгаа ба зураг төслийн ажлаас 8 ажил 100 хувь, 3 ажил нь 30-70 хувийн гүйцэтгэлтэй байна. Нийт 9.6 км урт, 12 гол гудамж замын шинэчлэлтийн ажлыг 100 хувь хэрэгжүүлсэн. Үүнд: 1. Гэсэр сүмийн уулзвараас Тасганы овооны уулзвар хүртэлх авто	НЗДТГ	70.0

				зам (БГД, ЧД), 2. Ж.Самбуугийн гудамжны авто зам (ЧД), 3. С.Амарсанаагийн гудамжны авто зам (БГД), 4. Ж.Батмөнхийн гудамжны авто зам (СБД), 5. Хилчний гудамжны авто зам (БЗД), 6. Ногоон нуур гудамжны авто зам /СБД/, 7. Их сургуулийн гудамжны авто зам /СБД/, 8. Баруун Сэлбийн гудамжны авто зам /ЧД/, 9. Н.Содномын гудамжны авто зам /СБД/, 10. 31 дүгээр хорооны авто зам /СХД/, 11. Усны гудамжны авто зам /СБД/, 12. С.Чоймболын гудамжны авто зам /ЧД/. Улаанбаатар хот доторх хорооллын чанартай авто замыг шинээр барих, засвар шинэчлэлт хийх ажлын хүрээнд Баянзүрх болон Хан-Уул дүүрэгт нийт 22 байршлаас 10 байршлын 4.38 км авто замын барилга угсралтын ажлыг ашиглалтад оруулсан. 2023 онд 12 байршил дахь ажлыг ашиглалтад оруулахаар бэлтгэл судалгаа хийгдэж байна. Мөн Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/523 дугаартай захирамжаар 79 байршилд нийт 70.3 км хорооллын чанартай авто замын зураг төсөл хийгдэж байгаагаас зураг төслийн 60 ажил 100 хувь, 17 ажил нь 30-80 хувийн гүйцэтгэлтэй, 2 ажлын гэрээг цуцалсан. Гэрээ цуцлагдсан 2 ажлын үйл ажиллагааг үргэлжлүүлэх тул боловсруулалтын ажлыг хийж байна. Улаанбаатар хотын гудамж замын уулзварыг сайжруулах ажлын хүрээнд 18 уулзварт шинэчлэлт хийхээр төлөвлөсөн. “Уулзваруудын дахин инженерчлэл” төсөл арга хэмжээний суурь судалгааны ажлыг гүйцэтгэсэн. “Уулзвар, замын гарц, буцаж эргэлт, нэвтрүүлэх чадварыг сайжруулах зам барилгын ажил”-ын хүрээнд 5 шарын уулзвараас МТ шатахуун түгээх станц хүртэлх авто замд шинэчлэлтийн ажил, Саруул тэнгэр хотхоны уулзвараас Грийн апартамент хотхоны уулзвар хүртэлх авто замын хучилтын ажил тус тус хийгдсэн. “Уулзваруудын дахин инженерчлэл” төсөл, арга хэмжээнд шаардагдах 4.5 тэрбум төгрөгийг 2023 оны төсөвт тусгасан. Авто машины болон явган хүний гүүрэн эсвэл нүхэн гарц барих ажил: 1. Замын цагдаагийн газрын ойролцоо 330 у/м явган хүний гүүрийг ажлын зураг төслийн дагуу гарцыг барьж дуусгасан. 100 хувь 2. Гачууртын уулзвараас Налайх-Чойрын уулзвар хүртэлх 20.9 км авто замын өргөтгөл, шинэчлэлт” төслийн үлдэгдэл ажлыг 2022 оны 12 дугаар сарын 31-ний дотор дуусгавар болгохоор гүйцэтгэгчийн гэрээг сунгасан. Уг төслийн хүрээнд нийт 5 байршилд явган хүний гүүрэн гарц барихаар төлөвлөснөөс 3 байршилд явган хүний гүүрэн гарцын зураг төсөл боловсруулагдаж, Зам тээвэр хөгжлийн төвд магадлалаар хянагдан баталгаажсан. Эхний ээлжид гүүрэн гарц барихаар төлөвлөсөн байршилд нэг түвшинд явган хүний гарцын тэмдэг, тэмдэглэгээний ажлыг гүйцэтгэсэн. Авто машин болон явган хүний нүхэн гарц: -Баянзүрх дүүрэгт Ахмадын хороолол орчмын Нарны зам,	
--	--	--	--	---	--

				Дүнжингаравын авто замын холбосон төмөр зам доогуурх явган зорчигч, автомашинд зориулсан нүхэн гарцын ажлын явц 60 хувьтай хэрэгжиж, газар чөлөөлөлтөөс шалтгаалан ажил түр зогссон. -Хан-Уул дүүргийн Яармагийн авто замд явган хүний нүхэн гарц барих ажлын хүрээнд Наадамчдын авто зам доорх 37.5 у/м туннелийн угсралтын ажил бүрэн дууссан. Нийт ажлын явц – 92 хувьтай. Төмөрбетон гүүрэн байгууламжийг шинээр барих, өргөтгөн шинэчлэх хүрээнд 2022 онд нийт 5 байршилд Улаанбаатар хотод төмөрбетон гүүрэн байгууламжийг шинээр барих, өргөтгөн шинэчлэх ажлын зураг төсөл хийгдсэнээс 4 төсөл арга хэмжээг эхлүүлж, 1 зураг төслийн ажил боловсруулах шатанд байна. Авто зогсоолыг нэмэгдүүлэх хүрээнд 2022 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн байдлаар нийт 583 автомашины зогсоолыг шинээр барьсан байна. Явган хүний зам болон дугуйн замын сүлжээг хөгжүүлэх хүрээнд нийт 14.35 км дугуйн зам, 80850 м2 явган зам барихаар төлөвлөсөн. Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/259 дүгээр захирамжид тусгагдсан Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх “Нүхэн гарц, гүүрэн байгууламж, авто зам дагуу тусгаарлагдсан зурвас бүхий дугуйн болон явган хүний замын ажил” нийслэлийн замын сангийн хөрөнгөөр он дамжин хэрэгжүүлэх унадаг дугуйн багц 1 ажлын хүрээнд 2 байршилд 33.9 км, багц 2 ажлын хүрээнд 6 байршилд 16.3 км дугуйн зам барих ажлыг үргэлжлүүлж байна. 2022 онд Улаанбаатар хотын ХУД, БЗД, НД, ЧД, БГД, БЗД-ийн 26 байршилд нийт 42,901 м2 явган зам шинээр барьсан байна.Үүнд: - “Явган хүний зам” ажлын хүрээнд СБД-ийн 16 хороонд 520 м2 явган зам- Ажлын хувь 100 хувь, - “Явган хүний зам” ажлын хүрээнд ХУД-т 1045 м2 явган зам- Ажлын хувь 100 хувь, - “Номин Юнайтед их дэлгүүрийн баруун талын авто замаас Б.Шаравын гудамжтай холбох зам” ажлын хүрээнд ХУД-ын 20-р хороонд 520м2 явган зам- Ажлын хувь 100 хувь, - “Номин Юнайтед их дэлгүүрийн баруун талын авто замаас Б.Шаравын гудамжтай холбох зам” ажлын хүрээнд ХУД-ын 20-р хороонд 2550 м2 явган зам- Ажлын хувь 100 хувь, - “Эрчим хүчний гудамжнаас Монос фарм трейд ХХК хүртэлх Таван толгой түлш ХХК-ийн зүүн талаар шинээр хийгдэх авто зам,” ажлын хүрээнд БГД-ын 20-р хороонд 5100м2 явган зам- Ажлын хувь 100 хувь, - “Номин Юнайтед их дэлгүүрийн баруун талын авто замаас Б.Шаравын гудамжтай холбох зам” ажлын хүрээнд ХУД-ын 20-р хороонд 520м2 явган зам- Ажлын хувь 100 хувь, - “Хайгуулчдын гудамж болон Хүнсчдийн гудамжны дагуу шинээр барих болон шинэчлэх авто зам” ажлын хүрээнд СХД-ийн 4,20,38-р хороонд 4470 м2 явган зам- Ажлын хувь 100 хувь, - “Улаанхуарангийн гудамжнаас 68 дугаар сургуулийн баруун талаар Цагдаагийн академийн өргөн чөлөөтэй холбох гудамж зам” ажлын хүрээнд 8-р хороонд 1131 м2 явган зам- Ажлын хувь 100 хувь, - “Ээрмэлийн гудамжийг Туул гол гудамжтай холбох авто зам” ажлын хүрээнд ХУД-ийн 19-р хороонд 1500 м2 явган зам- Ажлын хувь 100 хувь, - “1 дүгээр хорооны авто замыг Мянганы замын хэвтээ тэнхлэгтэй		
--	--	--	--	--	--	--

					холбох авто зам” ажлын хүрээнд ХУД-ийн 19-р хороонд 1500 м2 явган зам- Ажлын хувь 100 хувь, -Замын цагдаагийн гүүрэн гарц төслийн хүрээнд СБД-ийн 1-р хороонд 5788 м2 явган зам-Ажлын хувь 100, -“Авто замын байгууламжийн нүхэн гарц, гүүрэн байгууламж, авто замын тусгаарлагдсан зурвас бүхий дугуйн болон явган зам” ажлын хүрээнд Нийслэлийн 12 байршилд явган замыг тус тус барьсан байна.- Ажил хувь 40 хувьтай байна.		
58	4.1.2. Зам тээврийн хөдөлгөөний удирдлага, хяналтын нэгдсэн, ухаалаг систем бий болгох	Замын хөдөлгөөний бодлого, төлөвлөлтөд ашиглах, нэгдсэн байдлаар хянаж зохицуулах, тээврийн хэрэгслийн зорчилтын бодит цагийн мэдээллийн систем бий болсон байна.	-	-	Улаанбаатар хотын авто зам, тээврийн нэгдсэн ухаалаг системийг бий болгох төсөл”-ийг хэрэгжүүлснээр Замын хөдөлгөөний удирдлага зохион байгуулалтын ухаалаг системийн төсөл, арга хэмжээний хүрээнд Улаанбаатар хотын гэрлэн дохиотой уулзвар бүхий 161 байршилд RFID уншигч төхөөрөмжөөр бүрэн тоноглох ба 455 уншигч, 1,036 антенг суурилуулах ажил, 343 байршилд Г хэлбэрийн шон, 11 байршилд П хэлбэрийн шон суулгах ажил, Энхтайваны өргөн чөлөөний 44 цэгт 45 камер, Модны 2, Төмөр замын дээд сургууль орчимд 38 камер, Их тойрууд 14 цэгт 32 камерын ажил хийгдсэн. Г болон П хэлбэрийн шон суулгах ажил, нийслэлийн шалган нэвтрүүлэх товчоодын төлбөр, хураамжийн системийг сайжруулах, цахим төлбөрийн систем нэвтрүүлэх, нэхэмжлэх үүсгэх, төлбөрийн нэгдсэн системд холбох, тоног төхөөрөмж угсарч суурилуулах ажил тус тус хийгдэж байна.	НЗДТГ	90.0
59	4.1.3. Нийтийн тээврийн чанар, стандартыг сайжруулж, хүртээмжийг нэмэгдүүлэх багтаамж ихтэй нийтийн тээврийн шинэ технологи нэвтрүүлэх	Нийтийн тээврээр зорчигчдын тоо 2020 онтой харьцуулахад 30 хувиар нэмэгдэж, 50-60 мянган автомашины хөдөлгөөнийг саармагжуулсан байна.	-	-	1. Улаанбаатар хотод багтаамж ихтэй шинэ төрлийн тээврийн хэрэгсэл буюу хөнгөн галт тэрэг нэвтрүүлэх хүрээнд 2022 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр Улсын Их Хурал дахь Улаанбаатар хотын хөгжлийн бодлого эрхэлсэн түр хорооны хуралдаанд “Тулгуурт гүүрэн байгууламж бүхий хөнгөн галт тэрэг (LRT)-ний шугам тавих” төслийн талаар хэлэлцэж эхний ээлжид нэгдүгээр шугамын чиглэлийн трассын бүтээн байгуулалтын ажлын бэлтгэл ажлыг хийсэн. “Улаанбаатар хотод хэрэгжүүлэх хөгжлийн төсөл, арга хэмжээг эрчимжүүлэх тухай” Засгийн газрын 2022 оны 226 дугаар тогтоолыг боловсруулж, батлуулсан. Тулгуурт гүүрэн байгууламж бүхий Улаанбаатар хөнгөн галт тэрэгний нэгдүгээр шугамын “Суурь бүтцийн техникийн зураг төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээ”-ний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер шалгаруулалтыг 2022 оны 09 дүгээр сарын 19, 2022 оны 10 дугаар сарын 11-ний өдрүүдэд зарласан ба ирүүлсэн саналыг үнэлгээний хороогоор хянан үзэхэд шаардлага хангасан оролцогчийн тоо 3-аас доош байгаа буюу Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу хураангуй жагсаалт үүсээгүй. Хуулийн 36.7-д заасны дагуу зарлалыг 2022 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр дахин нийтэлж, 8 санал ирсэн байна. Тулгуурт гүүрэн байгууламж бүхий Улаанбаатар хөнгөн галт тэрэгний нэгдүгээр чиглэлийн трассын кадастрын зургийн цэг тэмдэг тавих, трассын дагуух “Инженерийн шугам сүлжээ бүхий байр зүйн зураг боловсруулах зөвлөх үйлчилгээ”-ний тендер шалгаруулалтыг 2022 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр нээсэн. Хураангуй жагсаалтад орсон тендерт оролцогчдод урилгыг хүргүүлж, тендер шалгаруулалтыг 2022.11.23-ны өдөр нээхэд Геодата ХХК нь захиалагчийн шалгуур үзүүлэлтийг хангасан тендер ирүүлж шалгарсан. Тус компанид гэрээ байгуулах тухай мэдэгдлийг хүргүүлээд байна. Батлагдсан трассын дагуу нөлөөлөлд өртсөн нэгж талбаруудын судалгааг хийж гүйцэтгэсэн.	НЗДТГ	70.0

					2. Улаанбаатар хотын нийтийн тээврийн үйлчилгээнд байгаль орчинд ээлтэй автобусаар парк шинэчлэлт хийх хүрээнд: - Нийслэлийн Засаг даргын Тамгын газар Сүлдэрхан минералс ХХК болон Xia men golden dragon bus CO.,Ltd түншлэлтэй 2021 онд байгуулсан НХААГ-21/015 дугаар гэрээний хүрээнд 2022 оны 05 дугаар сарын 30-ны өдөр Нийтийн тээврийн газрын даргын 2022 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн А/51 дүгээр тушаалаар байгуулагдсан Ажлын хэсэг Шэй мэн голден драгон үйлдвэрийн XML6125J15C загварын Евро-5 ангиллын дизель хөдөлгүүртэй хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг тээвэрлэх тоноглолтой их багтаамжийн 60 ширхэг автобусыг “Зорчигч тээврийн нэгтгэл” ОНӨААТҮГ-т хүлээлгэн өгсөн. - Мөн БНХАУ-аас Хөгжлийн банкны зээлийн хөрөнгөөр 2022 онд үйлдвэрлэсэн цахилгаан хөдөлгүүртэй 10 ширхэг давхар, их багтаамжийн 1 ширхэг, нийт 11 ширхэг автобусыг “Зорчигч тээвэр гурав” ОНӨААТҮГ-т хүлээлгэн өгч нийт 71 автобусаар парк шинэчлэлт хийж 2022 оны 06 дугаар сараас эхлэн нийтийн тээврийн үйлчилгээнд нэвтрүүлсэн. -2022 онд их багтаамжийн 410 дизель автобус, 150 цахилгаан автобус, дунд багтаамжийн 30 автобус, нийт 590 автобусаар парк шинэчлэхээр төлөвлөсөн ба үүнээс 224 автобус худалдан авахаар гэрээ байгуулсан. Хэрэгжилт 90 хувьтай. 3. Нийтийн тээврийн чанар, стандартыг сайжруулах, шинэ технологи, багтаамж ихтэй нийтийн тээврийн хэрэгсэл нэвтрүүлэх, хүртээмжийг нэмэгдүүлэхэд хотын стандартыг мөрдүүлэх хүрээнд зорчигч тээврийн үйлчилгээний 5 бүлэг стандартын төслийг боловсруулан 2022 оны 03 дугаар сарын 24-ний өдөр Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн батлуулсан. Стандартыг олон нийтэд таниулан сурталчлахаар “Хотын үйлчилгээ” сэдэвт зөвлөгөөнийг нийтийн тээврийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуй нэгж, байгууллагуудыг хамруулан зохион байгуулсан. Үүнд: 1.Такси зогсоолд тавигдах ерөнхий шаардлага; 2.Нийтийн тээврийн үйлчилгээ, тээврийн үйлчилгээ, тээврийн хэрэгсэлд тавигдах ерөнхий шаардлага; 3.Хүүхдийн автобусанд тавигдах ерөнхий шаардлага; 4.Такси үйлчилгээнд тавигдах ерөнхий шаардлага зохион байгуулсан.		
60	4.1.4. Түгжрэлийг бууруулах чиглэлээр арга хэмжээ авсан аж ахуйн нэгжүүдэд татварын хөнгөлөлт үзүүлэх хууль, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох	Түгжрэлийг бууруулах чиглэлээр арга хэмжээ авсан аж ахуйн нэгжүүдэд татварын хөнгөлөлт үзүүлэх хууль, эрх зүйн зохицуулалт бий болсон байна.	-	-	Тайлан ирүүлээгүй.	НЗДТГ	0.0
61	4.1.5. Нийслэл Улаанбаатар хотын дэд төвүүдийг холбосон, олон түвшний огтлолцол бүхий “Шинэ тойрог зам”-ыг барьж байгуулах	Нийт 71.5 км урттай, 11 олон түвшний уулзвартай “Шинэ тойрог зам”-ын сүлжээг бий болгож, авто замын түгжрэлийн	-	-	Улаанбаатар хотын шинэ тойрог замын сүлжээг шинээр бий болгох хүрээнд 2022 оны 05 дугаар сарын 31-ний Засгийн газрын хуралдаанаар “Улаанбаатар хотын шинэ тойрог зам” төслийн ажлыг 2022 онд багтаан эхлүүлэхийг даалгасны дагуу Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн 2022 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн хуралдаанд танилцуулсан. Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн 2022 оны 07 дугаар сарын 01-	НЗДТГ	50.0

		индексийг 15-20 хувиар бууруулсан байна.			ний өдрийн хуралд танилцуулж дэмжигдсэн. Техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах бэлтгэл ажлыг ханган, ажлын даалгаврыг боловсруулж байна.		
Зорилт 4.2.Шинэ суурьшлын бүс, дагуул хот, эдийн засгийн чөлөөт бүсийн бүтээн байгуулалтыг эрчимжүүлж, Улаанбаатар хотоос орон нутагт шилжин суурьшсан иргэд, аж ахуйн нэгжүүдийг цогц бодлогоор дэмжих замаар төвлөрлийг сааруулна.							
62	4.2.1. Нийслэл Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулах зорилгоор дэд төвүүдийн бүтээн байгуулалтыг эрчимжүүлэх, суурь дэд бүтцийг барьж байгуулах	Гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа дэд төвүүдийн бүтээн байгуулалтыг дуусгаж, нэмэлтээр бусад дэд төв, олон нийтийн төвүүдийг байгуулсан байна.	-	-	1. Хот төлөвлөх, хот байгуулах үйл ажиллагаанд мөрдөх, хотын стандартыг боловсруулах, мөрдүүлэх: Хот төлөвлөх, хот байгуулах үйл ажиллагаанд мөрдөх, хотын стандартыг боловсруулах, мөрдүүлэх ажлын хүрээнд дараах ажлыг үе шаттайгаар хийж гүйцэтгэв. Үүнд: - “Хотын стандартыг боловсруулах, мөрдүүлэх” Ажлын хэсэг нэгдүгээр ээлжийн 9 бүлгийн 38 хотын стандартыг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн барьж, хэлэлцүүлэн 2022 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн 18-26 дугаар тогтоолоор батлуулж, 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс дагаж мөрдүүлэхээр ажиллаж байна. - Хотын стандартыг дагаж мөрдүүлэх ажлын хүрээнд “Хотын стандартыг мөрдүүлэх бэлтгэл арга хэмжээний төлөвлөгөөг баталж, төлөвлөгөөний дагуу 11 зорилтын 25 арга хэмжээг тусгаж, холбогдох Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудад хүргүүлж, хотын стандартыг иргэд олон нийтэд сурталчлан таниулах, мөрдүүлэх үйл ажиллагааг зохион байгуулж ажилласан. - “Хотын стандартын нэгдсэн зөвлөгөөн”-ийг зохион байгуулах ажлын хүрээнд “Хотын стандартын тогтолцоо”, “Хотын соёл”, “Хотын үйлчилгээ”, “Иргэдийн ая тухтай орчин”, “Барилгын аюулгүй орчин” сэдэвт нийт 5 удаагийн зөвлөгөөнийг 2022 оны 11 дүгээр сарын 11-23-ны өдрүүдэд холбогдох төрийн болон төрийн бус байгууллага, иргэд, аж ахуйн нэгжүүдийн 2,600 оролцогчийг хамруулан зохион байгуулав. Хоёр дугаар ээлжийн хотын стандартыг боловсруулж батлуулах ажлын хэсэг байгуулагдсан. Санал авах хэлэлцүүлгийг 2022 оны 12 дугаар сарын 09-ний өдөр зохион байгуулахаар бэлтгэл ажлыг хангуулан ажиллаж байна. Хэрэгжилт 90 хувьтай. 2. Баянхошуу дэд төвийн үе шат 2-н хүрээнд баригдах нийгмийн барилга байгууламжийг төвийн шугам сүлжээнд холбоно: Төслийн эхний үе шатны хүрээнд: -Баянхошуу (6.5 км автозам, 6.3 км цахилгааны, 16.8 км дулаан хангамжийн, 10.9 км ус хангамжийн, 16.6 км ариутгах татуургын, 2.9 км харилцаа холбооны шугам сүлжээний ажлууд, 4.7 км үерийн хамгаалалтын далан суваг, 1000м3 усан сан, 4.65 га талбайн тохижилтын ажил, мэдээлэл холбооны төв, бизнес инкубатор төв, 240 хүүхдийн цэцэрлэг, 20 айлын орлогод нийцсэн орон сууц зэрэг ажлууд), -Сэлбэ (7.6 км автозам, 2.4 км цахилгааны, 8.7 км дулаан хангамжийн, 7 км ус хангамжийн, 11.5 км ариутгах татуургын, 2.8 км харилцаа холбооны шугам сүлжээний ажлууд, 2.2 км үерийн хамгаалалтын далан суваг, 1000м3 усан сан, 3.01 га талбайн тохижилтын ажил, мэдээлэл холбооны төв, бизнес инкубатор төв, 240 хүүхдийн цэцэрлэг, 3 төмөр бетон гүүр, 28МВт-ын дулааны станц зэрэг ажлууд), дэд төвүүдийн нийгмийн болон инженерийн барилга байгууламжийн барилгын ажлууд бүрэн дуусан ашиглалтад оруулаад байна. Баянхошуу дэд төвийн үе шат 2-ын хүрээнд: Баянхошуу дэд төвийн нийгмийн барилга байгууламжуудыг төвийн шугам сүлжээнд холбох салбар шугамын барилга угсралтын ажил 60.25 хувьтай үргэлжилж	НЗДТГ	70.0

					байна. Дараах ажлууд хийгдээд байна. Үүнд •Дулааны шугам 1.7 км угсрагдахаас 1км угсрагдсан •Цэвэр усны шугам 1.7 км угсрагдахаас 1км угсрагдсан •Бохир усны шугам 280 м угсрагдаж дууссан. •УДДТ 15х9 барилгын суурийн ажил хийгдсэн. 3. Дамбадаржаа дэд төвийн нийгмийн болон инженерийн барилга байгууламжуудын зураг төсөл боловсруулагдаж дууссан. Харин газар чөлөөлөлт нүүлгэн шилжүүлэлтийн ажлын явц 92.6 хувьтай байна. Худалдан авах ажиллагааны явц 26.6 хувьтай үргэлжилж байна. Дамбадаржаа дэд төвд үерийн хамгаалалтын сувгийн барилга угсралтын ажил эхэлсэн бөгөөд барилга угсралтын гүйцэтгэл 68.4 хувьтай байна. 4. Толгойт дэд төвийн дэд бүтцийг барьж байгуулна: Толгойт дэд төвийн нийгмийн болон инженерийн барилга байгууламжуудын зураг төсөл боловсруулах ажлын явц 90 хувьтай байна. Газар чөлөөлөлт нүүлгэн шилжүүлэлтийн ажлын явц 33.11 хувьтай байна. Худалдан авах ажиллагааны явц 17.95 хувь. Харин Толгойт дэд төвийн барилга угсралтын 2 ажил эхэлсэн байна. Үүнд: •Толгойт дэд төвийн үерийн хамгаалалтын сувгийн барилга угсралтын ажлын явц 69.5%, •Сургалтын төвийн барилга угсралтын ажлын явц 21%. 5. Шархад дэд төвийн инженерийн барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах ажлын явц 38.0 хувьтай байна. Судалгааны ажил бүрэн дуусаж, бичиг баримтын боловсруулалтын бэлтгэл ажил хийгдэж байна.		
63	4.2.2. Шинэ суурьшлын бүс, эдийн засгийн чөлөөт бүс, дагуул хотын бүтээн байгуулалтыг эрчимжүүлэх	Шинэ суурьшлын бүс, эдийн засгийн чөлөөт бүс, дагуул хотын бүтээн байгуулалтыг эрчимжүүлэх бэлтгэл ажлыг хангаж, төлөвлөлтийг хийсэн байна.	-	-	1. “Хөшигийн хөндий орчмын шинэ дагуул хотын дэд бүтэц” төслийн хүрээнд “Шинэ Зуунмод” хотын эхний ээлжийн инженерийн бэлтгэл арга хэмжээ болон инженерийн шугам сүлжээний 2,173.3 сая төгрөгийн 6 төрлийн ажлын зураг төслийг захиалж боловсруулан, инженерийн бэлтгэл арга хэмжээ, цахилгаан хангамж, ус хангамж, мэдээлэл холбооны зураг төслүүдийн магадлалын нэгтгэсэн дүгнэлтийг гаргуулсан. 2. 2022 онд улсын төсвийн санхүүжилтээр эхний ээлжийн инженерийн шугам сүлжээний дараах ажлуудын барилга угсралтыг эхлүүлээд байна. Үүнд: -Ус хангамжийн эх үүсвэр, шугам сүлжээ /гүний худаг, 16 км салбар шугам/-ний гүйцэтгэгчээр “Эс Энд Трейд” ХХК шалгарч нь БХБЯамтай 2022/412 тоот гэрээ байгуулан барилга угсралтын ажлыг 2022 оны 10 дугаар сарын 07-ны өдөр эхлүүлсэн бөгөөд 2022 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн байдлаар 1400м газар шорооны ажил хийгдсэн бөгөөд ф280мм-ын хуванцар хоолойн наалт, гар пракц, хийн шахалт, буцаан булалтын ажил тус тус хийгдэж 8 хувийн гүйцэтгэлтэй үргэлжилж байна. -Цахилгаан хангамжийн шугам сүлжээний ажлын гүйцэтгэгчээр “Билгүүн Од констракшн” ХХК тус тус шалгарч захиалагчтай гэрээ байгуулан 2022 оны 09 дүгээр сарын 12-ны өдөр барилга угсралтын ажлыг эхлүүсэн бөгөөд 7.5 хувьтай үргэлжилж байна. 3. Шинэ Зуунмод хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулан, магадлалын нэгтгэсэн дүгнэлтийг гаргуулж Засгийн газрын 2022 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, Хот байгуулалтын тухай хуулийн 6.1.4 дэх заалтын дагуу “Шинэ Зуунмод хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө батлах тухай” ЗГ-ын 143-р тогтоолыг батлуулсан.	НЗДТГ, БХБЯ	70.0

					4. Төв аймгийн Сэргэлэн сумын нутаг дэвсгэр дэх “Чингис хаан” ОУШНБ-ыг түшиглэн 1000 га газарт “Хөшигийн хөндийн ЭЗЧБ” байгуулах тухай УИХ-ын тогтоолын төсөл, холбогдох судалгаа тооцоог боловсруулж, УИХ-ын 2022 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн “Хөшигийн хөндийн эдийн засгийн чөлөөт бүс байгуулах тухай” 10 дугаар тогтоолыг батлуулсан. 5. Нийслэл Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулах, хот хөдөөгийн тэнцвэрт хөгжлийг хангах зорилтын хүрээнд төрийн захиргааны зарим байгууллагын ажиллах нэгдсэн байрыг Төв аймгийн Хөшигийн хөндий рүү нүүлгэн шилжүүлэх арга хэмжээний талаарх судалгаа тооцоо, Засгийн газрын тогтоолын төслийн хамт боловсруулж Засгийн газрын 2022 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, “Төрийн захиргааны зарим байгууллагыг Хөшигийн хөндий рүү нүүлгэн шилжүүлэх арга хэмжээний тухай” Засгийн газрын 98 дугаар тогтоолыг батлуулсан. 6. Засгийн газрын 2022 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн 143-р тогтоолоор баталсан Шинэ Зуунмод хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Орон сууц, олон нийт, худалдаа, үйлчилгээний бүсийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө” боловсруулах ажлыг “Некст степ инженеринг” ХХК /200.0 сая төгрөг/, “Эдийн засгийн чөлөөт бүсийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө” /234.0 сая төг/, “Тээвэр, логистикийн төвийн ТЭЗҮ, эхний ээлжийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө” /339.6 сая төг/-г боловсруулах ажлыг “Хот төлөвлөлт, судалгааны институт” ОНӨААТҮГ, “Сургалт-Эрдэм шинжилгээ-Үйлдвэрлэлийн цогцолбор”-ын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө” /700.0сая төгрөг/ боловсруулах ажлыг “Нарт дизайн” ХХК тус тус гүйцэтгэсэн. Мөн ИНЕГ-ын 600 айлын орон сууцны барилгын ажлын зураг төслийн ажлыг /300.0 сая төгрөг/ “Кон-Консалтинг” ХХК боловсруулж дууссан. Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ УИХ-ын болон Засгийн газрын холбогдох гишүүдийн хамт 2022 оны 08 дүгээр сарын 12-ны өдөр Төв аймгийн Сэргэлэн сумын нутаг дэвсгэрт Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулах, Шинэ Зуунмод хот, шинэ суурьшлын бүс болон эдийн засгийн төрөлжсөн бүс байгуулах бүтээн байгуулалтын хүрээнд “Хөшигийн хөндийн шинэ суурьшлын бүс”-ийн инженерийн дэд бүтцийн эхний ээлжийн ажлыг эхлүүлж, нээлтийг хийсэн. 7. Засгийн газрын 2022 оны 09 дүгээр сарын 22-ны өдрийн 350 дугаар тогтоолын 28 дугаар хавсралтаар Хөшигийн хөндийн бүтээн байгуулалтын Үндэсний хороог Монгол Улсын Шадар сайд Д.Амарсайханаар ахлуулан байгуулсан. Үндэсний хорооны нарийн бичгийн даргаар БХБЯ-ны сайд Б.Мөнхбаатар ажиллаж байгаа бөгөөд Үндэсний хорооны хурлыг 2022 оны 09 дүгээр сарын 29-ний өдөр Төрийн ордонд зохион байгуулсан. Уг хурлаар Хөшигийн хөндийн шинэ хот, эдийн засгийн чөлөөт бүсийн бүтээн байгуулалтын ажлын явц, “Төв аймгийн Хөшигийн хөндий дэх Шинэ Зуунмод хот, эдийн засгийн чөлөөт бүсийг байгуулах төлөвлөлт, бүтээн байгуулалтын ажлын төлөвлөгөө”-ний төслийг хэлэлцсэн. Төв аймгийн Хөшигийн хөндийд шинэ дагуул хот болон эдийн засгийн чөлөөт бүс байгуулан хөгжүүлэх төлөвлөгөөний төсөлд БХБЯ-ны 2022 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн 1/4487, 3/4488 тоот албан бичгээр холбогдох яамд, төрийн байгууллагууд, Төв аймгийн ЗДТГ-аас санал авч нэгтгэн боловсруулж, 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдөр Шадар сайд Д.Амарсайханд танилцуулсан. Хөшигийн хөндийн бүтээн байгуулалтын Үндэсний хорооны дарга, Шадар сайд Д.Амарсайхан 2022 оны 10 дүгээр сарын 28-ны өдөр		
--	--	--	--	--	---	--	--

				БХБЯ-нд дээр холбогдох байгууллагуудын төлөөлөлтэй хамтарсан уулзалтыг хийж, эхний ээлжийн бүтээн байгуулалтын ажлууд болох төрийн захиргааны зарим байгууллагуудын нэгдсэн цогцолборын төлөвлөлт, ИНЕГ-ын 600 айлын орон сууцны барилгын зураг төсөл, Богдхан төмөр замын ажил, Эдийн засгийн чөлөөт бүсэд гадаадын болон дотоодын хөрөнгө оруулагчдыг татах зэрэг ажлын явцтай танилцаж, үүрэг, чиглэл өгөв. 2022 оны 10 дугаар сарын 25-ны өдөр БХБ-ын сайд Б.Мөнхбаатар болон ЦХХХ-ны сайд Н.Учрал, холбогдох яамны төлөөллүүд хамтарсан уулзалт хийж, Хөшигийн хөндийд шинэ хот, эдийн засгийн чөлөөт бүсийг байгуулахад харилцаа холбоо, мэдээллийн технологийн чиглэлээр хамтран ажиллахаар тохиролцсон. 8. Монгол Улсын Шадар сайд, Хөшигийн хөндийн бүтээн байгуулалтын Үндэсний хорооны дарга Д.Амарсайхан болон БХБ-ын сайд Б.Мөнхбаатар нар 2022 оны 10 дугаар сарын 31-ний өдөр Төв аймгийн Хөшигийн хөндийд шинэ хот болон эдийн засгийн чөлөөт бүс байгуулах ажлын явц, цаашид авах арга хэмжээний саналыг Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ, Монгол Улсын сайд, ЗГХЭГ-ын дарга Д.Амарбаясгалан нарт танилцуулсан. 9. БХБЯ-наас БНСУ-ын Газар, дэд бүтэц, тээврийн яамтай хамтран "K-city network"-ийн хүрээнд 800.0 мянган ам долларын буцалтгүй тусламжийн санхүүжилтээр "Шинэ Зуунмод - Ухаалаг хот" төслийн концепц баримт бичгийг боловсруулах зөвлөх үйлчилгээг 2022 оны 09 дүгээр сарын 13-ны өдрөөс эхлүүлсэн. Төслийн гүйцэтгэгчээр БНСУ-ын Soosung Engineering консорциум ажиллаж байгаа бөгөөд төслийн баримт бичгийг 8 сарын хугацаанд боловсруулж дуусгана. 10. АХБ-ны 2021-2024 онуудад Монгол Улстай хамтран хэрэгжүүлэх түншлэлийн стратегид багтсан зээл, буцалтгүй тусламж, техникийн туслалцааны хүрээнд "Хөшигийн хөндий орчмын шинэ дагуул хотын дэд бүтцийн хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх төслийн санамж бичгийг БХБЯ-наас боловсруулж, ЭЗХЯ, СЯ-аар батлуулан тус банканд 2022 оны 11 дүгээр сарын 04-ний өдөр хүргүүлсэн. 11. Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/779 дүгээр "Хөрөнгө оруулалтын ажлыг зохион байгуулах тухай" захирамжаар Эмээлт эко аж үйлдвэрийн паркийн техник эдийн засгийн үндэслэл, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний тодотгол боловсруулах ажлын гэрээг байгуулж, ажлыг 2022 оны 12 дугаар сарын 20-ны өдөр хүлээн авахаар ажиллаж байна. Нийслэлийн Засаг даргын 2022 оны 07-р сарын 22-ны өдрийн А/989 дүгээр "Эрх шилжүүлэх тухай" захирамжийн дагуу "Бизнес инкубатор, үйлдвэр сургалтын төвийн барилга", "Паркийн хамгаалалтын бүс"-ийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, паркийн хамгаалалтын бүсийн ажил 25%-ийн гүйцэтгэлтэй, "Бизнес инкубатор, үйлдвэр сургалтын төвийн барилга"-ын ажил гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж гэрээ байгуулах шатанд ажиллаж байна. "Арьс ширний үйлдвэрүүдийг нүүлгэн шилжүүлэх суурь судалгаа", "Эмээлт эко аж үйлдвэрийн паркийн макет" хийх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахаар гэрээ байгуулан ажиллаж байна. Багахангай үйлдвэрлэл, технологийн парк байгуулна: Багахангайн Үйлдвэрлэл технологийн парк" ОНӨТҮГ-т Техник, эдийн засгийн үндэслэл, Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, барилгажилтын зураг		
--	--	--	--	---	--	--

					төсөл, "Багахангайн Үйлдвэрлэл, технологийн парк"-ийн 35/10 квт дэд станцын зураг төсөл, Техник технологийн түвшний үнэлгээ тус тус хийгдсэн. Дүүргийн Засаг даргын захирамжаар Төмөр замын бүтээн байгуулалттай холбоотойгоор 5 га газар, нөөц 40 га газрыг паркийн эзэмшилд тус тус шилжүүлсэн.		
64	4.2.3. Хөшигийн хөндийд шинэ хотууд болон эдийн засгийн чөлөөт бүсийг байгуулах бүтээн байгуулалтыг эрчимжүүлэх	Шинэ дагуул хотууд болон эдийн засгийн чөлөөт бүсийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, техник, эдийн засгийн үндэслэл, ажлын зураг төслийг боловсруулж, эхний үе шатны инженерийн шугам сүлжээг барьж байгуулсан байна.	-	-	Монгол Улсын Засгийн газраас 2022 оны 01 дүгээр сарын 17-нд УИХ-д өргөн барьсан "Хөшигийн хөндийн эдийн засгийн чөлөөт бүс байгуулах тухай" УИХ-ын тогтоолын төслийг хэлэлцэх эсэх асуудлыг Эдийн засгийн Байнгын хорооны 3 дугаар сарын 16-ны өдрийн хуралдаанаар, УИХ-ын чуулганы 3 дугаар сарын 17-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар тус тус хэлэлцүүлсэн. Хөшигийн хөндийд шинэ хотууд болон эдийн засгийн чөлөөт бүсийг байгуулах бүтээн байгуулалтыг эрчимжүүлэх зорилгоор дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. 1. Судалгааны чиглэлээр: Чөлөөт бүс түүний эрх зүйн орчин, аялал жуулчлал, худалдаа үйлчилгээ, банк санхүүгийн төвийн дараах судалгаануудыг хийж, судалгааны эмхэтгэл хэвлэн гаргасан. Үүнд: •Эдийн засгийн чөлөөт бүсийн үзэл баримтлал болон чөлөөт бүсэд хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэлээр олон улсын туршлагауд, хууль эрх зүйн орчны нарийвчилсан судалгаа; •Дэлхий дахинаа хамгийн ашигтай бизнес гэж үзэж өргөжүүлэн хөгжүүлж байгаа Казиногийн хөгжил, хууль эрх зүйн орчин, харьцуулалт, тандан судалгаа; •Олон улсад амжилттай хөгжүүлж байгаа Олон улсын санхүүгийн төвүүд, хууль эрх зүйн орчны судалгаа; •Гадаадын улс орнууд олон улсын нисэх онгоцны буудал тойрсон төлөвлөлтийг хэрхэн хийж байгаа туршлагауд; •Чөлөөт бүсэд хэрэгжүүлэх Ногоон технологи, ногоон барилгын судалгаа. 2. Хуулийн төсөл боловсруулах, хамтран ажиллах чиглэлээр: •Хөшигийн хөндийн эдийн засгийн чөлөөт бүс байгуулах тухай тогтоолын төслийн үзэл баримтлал, тандан судалгаа, тогтоолын төсөл зэрэг холбогдох судалгаануудыг хийж, Шадар сайдын ажлын албатай хамтран ажилласан. •Казиногийн тухай хуулийн төслийг боловсруулахад ХЗДХЯ-ны ажлын хэсэгтэй хамтарч ажилласан. •Олон улсын Санхүүгийн төвийн тухай хуулийн төслийг боловсруулж байна. •Богд хан төмөр замын ТЭЗҮ боловсруулах ажлын хэсэгтэй хамтран ажиллаж Рашаант өртөөнөөс Богдхан уулын урдуур тойрч, Мааньт өртөөтэй холбогдох Богд хаан төмөр зам дагуу Хөшигийн хөндийд өртөө байгуулах, өртөө орчмыг цаашид хоёр дахь замтай болгож Шинэ онгоцны буудал руу зорчигчийн төмөр замын шугам, Тээвэр логистикийн төв, Үйлдвэржилтийн бүс рүү салбар төмөр зам барих санал оруулсан. •Хөшигийн хөндийн бүтээн байгуулалтын үндэсний хороонд Эдийн засгийн чөлөөт бүсийн менежментийг "Төр-хувийн хэвшлийн түншлэл" дээр тулгуурласан ТӨОК хэлбэрээр зохион байгуулах хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх болон Хөшигийн хөндийн ЭЗЧБ-	ШСАА ЭЗХЯ	50.0

					ийн бүтээн байгуулалтыг 2023 оны 04 дүгээр сард эхлүүлэхийн тулд шийдвэрлэх шаардлагатай асуудлуудыг танилцуулж хамтран ажиллаж байна.		
					3. Хөрөнгө оруулагчдад Хөшигийн хөндийн бүтээн байгуулалтын төслийг танилцуулах чиглэлээр: •Хөшигийн хөндийн бүтээн байгуулалтад хөрөнгө оруулалт татах, хамтран ажиллах зорилгоор төслийн танилцуулга хийх, санал солилцох гадаад дотоодын 60 гаруй уулзалтыг зохион байгуулсан. •БНТУ-ын Анкара хотод зохион байгуулагдсан "Турк-Монголын бизнес форум"д оролцож Хөшигийн хөндийн эдийн засгийн чөлөөт бүсийн үзэл баримтлал, төлөвлөлтийг танилцуулсан. 4.Дэд бүтэц, зураг төслийн ажлын чиглэлээр: •Барилга хот байгуулалтын яам ба Хот төлөвлөлт судалгааны институт ОНӨУҮГ нарын хооронд 2022 оны 01 сарын 28-ны өдөр байгуулсан №2022/23 тоот гэрээний дагуу Хөшигийн хөндийн ЭЗЧБ-ийн ерөнхий төлөвлөгөөний зураг төслийн ажил эцсийн тайлангаа яам болон бусад чөлөөт бүсийн захиргаа, хувийн хэвшлийн компани, хил гаалийн байгууллагуудтай хэлэлцүүлэх шатанд явж байна. •Хөшигийн хөндийн Эдийн засгийн чөлөөт бүсийн ерөнхий төлөвлөгөөний зураг төслийн ажлын явцад хэлэлцэх, санал өгөх байдлаар Хот төлөвлөлт судалгааны институт ОНӨУҮГ-тай хамтран ажиллаж байсан. •Төрийн нэг цэгийн үйлчилгээ бүхий чөлөөт бүсийн захиргааны барилгын концепц, зураг төсөл, ажлын зургийн даалгаврыг боловсруулсан.		
65	4.2.4. Улаанбаатар хотоос орон нутагт шилжин суурьшсан иргэн, аж ахуйн нэгжүүдэд төсөв, санхүүгийн бодлогоор дэмжлэг үзүүлэх	Улаанбаатар хот руу чиглэх шилжилт хөдөлгөөн саарсан байна.	-	-	Хот, хөдөөгийн сэргэлтийн зорилтыг хангах тухай ажлын хэсэгт ажиллан хэрэгжүүлж буй арга хэмжээний мэдээлэл болон цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас ирүүлсэн маягтын дагуу ажлын хэсэгт хүргүүлсэн. Мөн орон нутагт үйл ажиллагаа явуулах аж ахуйн нэгжийг дэмжих цогц арга хэмжээний санал боловсруулах ажлын хэсгийг ХХААХҮ-ийн сайдын тушаалаар байгуулан ажиллаж байна. Мөн орон нутагт шилжсэн иргэн, иргэнийг ажилд авсан жижиг, дунд үйлдвэрт хөнгөлөлттэй зээл олгох зорилгоор ХХААХҮ-ийн сайдын 2022 оны "Нэмэлт өөрчлөлт оруулах тухай" А-243 дугаар тушаалаар Хоршоог хөгжүүлэх сангийн журамд өөрчлөлт оруулан хоршоонд төдийгүй "жижиг, дунд үйлдвэр", "иргэн"-нд хөнгөлөлттэй зээл олгох зохицуулалтыг оруулсан.	НЗДТГ, ХХААХҮЯ	30.0
66	4.2.5. Орон нутагт шилжсэн иргэнийг ажилд авсан жижиг, дунд үйлдвэрт хөнгөлөлттэй зээл олгох хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх	Орон нутагт шилжсэн иргэнийг ажилд авсан жижиг, дунд үйлдвэрт хөнгөлөлттэй зээл олгох хууль, эрх зүйн орчин бүрдсэн байна.	-	-	Орон нутаг дахь Хоршоог хөгжүүлэх сангийн журам шинэчлэгдсэнтэй холбогдуулан 2022 оны 4-р улирын байдлаар Улсын хэмжээнд хоршоог хөгжүүлэх сангаас иргэн, аж ахуйн нэгжийн 286 төсөлд 9.6 тэрбум төгрөгийн санхүүжилт олгож, шинээр байнгын 475, түр 52 ажлын байр нэмэгдсэн байна.	ХХААХҮЯ	50.0
67	4.2.6. Орон нутагт үйлдвэрлэл, үйлчилгээ, хүн амын төвлөрлийг бий болгохын тулд инженерийн дэд бүтцийг барьж байгуулах	Орон нутагт үйлдвэрлэл, үйлчилгээ бий болж, ажлын байр нэмэгдэж, шилжилт хөдөлгөөн буурсан	-	-	Засгийн газрын 2021 оны 161 дүгээр тогтоолоор "Сумын хөгжил: Инженерийн дэд бүтцийн хангамж" төсөл, арга хэмжээг батлуулсан. Энэ төсөл арга хэмжээний хүрээнд 2021-2024 онд нийт 19 аймгийн 59 суманд инженерийн дэд бүтцийн хангамжийн шугам сүлжээг барьж байгуулахаар төлөвлөсөн.	БХБЯ	70.0

		байна.			Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2020 онд "Сумын төвийн шинэчлэл" төслийг 5 аймгийн 5 сумын төвд хэрэгжүүлэх ажил эхэлсэн. Үүнээс Архангай аймгийн Эрдэнэмандал, Баянхонгор аймгийн Өлзийт, Өвөрхангай аймгийн Хайрхандулаан сумдын ажил дуусаж, 2021 онд ашиглалтад орсон. Харин Завхан аймгийн Отгон болон Хэнтий аймгийн Батноров сумын төслийн ажил 2022 оны байдлаар 95%-тай байна. "Сумын хөгжил: Инженерийн дэд бүтцийн хангамж" төсөл, арга хэмжээний хүрээнд 2022 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 9 аймгийн 18 сумын төвийн инженерийн шугам сүлжээ, барилга байгууламжийн барилга угсралтын ажил, 5 аймгийн 15 суманд сумын инженерийн дэд бүтцийн хангамжийн шугам сүлжээний зураг төслийг гүйцэтгэж байна. Үүнд: Барилга угсралтын ажил Архангай, Ихтамир сум, Баянхонгор, Баацагаан, Галуут, Эрдэнэцогт сумд, Говь-Алтай, Алтай сум, Дорнод, Дашбалбар сум, Дундговь, Луус сум, Төв, Борнуур, Дэлгэрхаан, Сэргэлэн, Эрдэнэ, Баянчандмань сумд, Өвөрхангай, Бат-Өлзий, Уянга, Хужирт сум, Сэлэнгэ, Алтанбулаг сум, Хэнтий, Дэлгэрхаан, Галшар суманд төсөл хэрэгжүүлэх гүйцэтгэчийг сонгон шалгаруулж барилга угсралтын ажлыг эхлүүлсэн. Дээрх сумдад 2022 онд гүйцэтгэхээр төлөвлөсөн ажил: Архангай, Ихтамир суманд 100%, Баянхонгор, Баацагаан суманд 15%, Галуут суманд 85%, Эрдэнэцогт суманд 85%, Говь-Алтай, Алтай суманд 100%, Дорнод, Дашбалбар суманд 100%, Дундговь, Луус суманд 100%, Өвөрхангай, Бат-Өлзий суманд 100%, Хужирт суманд 100%, Уянга суманд 10%, Сэлэнгэ, Алтанбулаг суманд 15%, Төв, Борнуур суманд 100%, Дэлгэрхаан суманд 100%, Эрдэнэ суманд 100%, Сэргэлэн суманд 100%, Баянчандмань суманд 100%, Хэнтий, Галшар суманд 100%, Дэлгэрхаан суманд 100%-ийн гүйцэтгэлтэй. Нийт ажил 84%-ийн гүйцэтгэлтэй. Зураг төслийн ажил 5 аймгийн 15 суманд сумын инженерийн дэд бүтцийн хангамжийн шугам сүлжээний зураг төслийг гүйцэтгэж байна. Төрийн өмчийн Концессын зүйлийн жагсаалтад "Сумын хөгжил: Инженерийн дэд бүтцийн төсөл, арга хэмжээ"-г хэрэгжүүлэхээр ЭЗХЯ-нд санал хүргүүлсэн.		
68	4.2.7. Орон нутагт шилжсэн болон суурьшиж байгаа иргэн, ерх, хөдөлмөр эрхлэгчдийг хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу инженерийн дэд бүтцээр хангагдсан орон сууцаар хангахад дэмжлэг үзүүлэх	Бүсчилсэн хөгжлийн бодлого болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу хөдөө, орон нутагт хот суурин газрыг хөгжүүлэн Улаанбаатар хотын төвлөрөл, ачааллыг бууруулсан байна.	-	-	Орон сууцны ипотекийн 6 хувийн хүүтэй 3.6 их наяд төгрөгийн зээлийг 89.0 мянган зээлдэгчид олгосон. Монгол Улсын Хөгжлийн банкны зээлийн санхүүжилтээр "Төрийн орон сууцны корпораци" ТӨХХК-ийн захиалгаар орон нутагт 789 айлын түрээсийн орон сууцны санг бүрдүүлсэн.	БХБЯ	50.0
69	4.2.8. Орон нутагт бизнесийн орчныг дэмжих, хотоос хөдөө рүү шилжин суурьшиж байгаа	Хотоос хөдөө рүү шилжин суурьшиж байгаа иргэдийг	-	-	Орон нутаг дахь Хоршоог хөгжүүлэх сангийн журам шинэчлэгдсэнтэй холбогдуулан 2022 оны 4 дүгээр улирлын байдлаар Улсын хэмжээнд хоршоог хөгжүүлэх сангаас иргэн, аж	ХХААХҮЯ	50.0

	иргэдийг малжуулах болон бусад хөдөө аж ахуйн чиглэлийн жижиг бизнесийг төрөөс бодлогоор дэмжих	малжуулах болон бусад хөдөө аж ахуйн чиглэлийн жижиг бизнесийг төрөөс бодлогоор дэмжсэн байна.			ахуйн нэгжийн 286 төсөлд 9.6 тэрбум төгрөгийн санхүүжилт олгож шинээр байнгын 475, түр 52 ажлын байр нэмэгдсэн байна. “Хотоос орон нутагт шилжин суурьшиж байгаа иргэдийг малжуулах” бодлогын хүрээнд ХХААХҮЯ-аас аймгуудын Хүнс, хөдөө аж ахуйн газраар дамжуулан 21 аймгаас гэрээт малчин ажиллуулах сонирхолтой 7,585 малчин өрхөөс судалгаа авч нэгтгэхэд 4,752 малчин өрх гэрээт малчин ажиллуулах боломжтой гэсэн дүн гарсан. Түүнчлэн нийслэл хотоос хөдөө орон нутагт шилжиж гэрээт малчнаар ажиллах иргэдийн судалгааг авахад 496 өрх шилжин суурьшиж мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэх хүсэлтэй байсан. Иймд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны дэргэдэх Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2022 оны 01 дүгээр тогтоолоор батлагдан хэрэгжиж байгаа “Аж ахуй эрхлэгчдийг дэмжих хөтөлбөр”-ийн хүрээнд Хөдөө орон нутагт, ялангуяа мал аж ахуй, газар тариалангийн салбарт ажиллах хүчний дутагдал үүсээд байгаа үед Улаанбаатар хот, аймгийн төвөөс сум, багт шилжин суурьшиж мал маллах хүсэлтэй өрхийг гэрээт малчны ажилд зуучлах, тогтвортой ажиллуулах боломж нөхцөлийг судлах ажлыг хамтран зохион байгуулах, иргэдийг малжуулах арга хэмжээг нэгтгэн зохион байгуулахаар ТНБД-ын 2022 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 01/1381 албан тоот саналыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлсэн. 2022 оны 11 дүгээр сарын 23-ны байдлаар нийт 9 өрхийн 27 иргэнийг хот суурин газраас хөдөөд шилжин суурьшуулж гэрээт малчны ажилд жуучилсан байна. Эдгээр 9 өрхөд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны дэргэдэх Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас гэрээт малчин өрхийг малжуулах санхүүгийн дэмжлэг үзүүлсэн. Мөн Европын холбооны санхүүжилтээр ХЭҮК, МЭХ-тэй хамтран хэрэгжүүлсэн “Дэмжих бүлэг болон хүний эрхийн сургалтаар туслах малчдыг чадавхжуулах нь” төслийг 6 аймгийн 18 суманд хэрэгжүүлж “Туслах малчдын нийгэм, эдийн засгийн байдал, хүний эрхийн хэрэгжилт” судалгааг 6 аймгийн 18 сумын нийт 1,244 малчдыг хамруулан дараах 3 дэд бүлэгт хуваан судалгааг авсан. Үүнд: 1. Иргэний болон улс төрийн эрх, эрх чөлөө 2. Эдийн засаг, нийгэм, соёлын эрх 3. Хөдөлмөрлөх эрх, энэхүү судалгаагаар туслах малчдын хүний эрхийн нөхцөл байдал, ажил олгогч болон туслах малчин хоорондын хөдөлмөрийн харилцаанд үүсэж буй хүндрэл бэрхшээл, зөрчлийг тодорхойлж, туслах малчдын хөдөлмөрийн хуваарь, ажлын цаг, цалин хөлс, урамшууллын нөхцөл, өөрийн болон гэр бүлийн гишүүдийн нийгмийн хамгаалал, халамж боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдах, хөдөлмөрлөх, сурч боловсрох, мэдээлэл авах зэрэг эрхийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийхэд ажил олгогч малчин болон туслах малчид хөдөлмөрийн харилцааны талаар ойлголт бага байсан. 6 аймгийн 18 сумын нийт 139 туслах малчин 2 шатны сургалтад хамрагдсан, үүнээс эрэгтэй 50, эмэгтэй 89 байна. Төслийн хүрээнд олон нийтийн сүлжээгээр ажил олгогч малчин болон туслах малчдад хөдөлмөр эрхлэлт, хүний эрх зэрэг сэдвээр мэдээлэл хүргэж ажилласан. Үндсэн малчидтай хөдөлмөрийн харилцаа сэдвээр хийсэн хэлэлцүүлэгт нийт 100 гаруй ажил олгогч малчин оролцсон. Ажил олгогч малчин болон туслах малчдыг хөдөлмөрийн харилцаанд сургаснаар цаашид хот суурин газраас хөдөөд шилжин суурьшиж гэрээт малчнаар ажиллахад ажил олгогч болон туслах малчдын хөдөлмөрийн харилцаанд үүсэх асуудлыг бууруулах ач холбогдолтой.		
--	---	--	--	--	---	--	--

70	4.2.9. Хүнсний бүтээгдэхүүн, түүхий эд, газар тариалан, хөдөө аж ахуй, барилгын материалын үйлдвэрлэл түшиглэсэн орон нутгийн логикийн төвүүдийг байгуулах	Хүнсний бүтээгдэхүүн, түүхий эд, газар тариалан, хөдөө аж ахуй, барилгын материалын үйлдвэрлэлд түшиглэсэн орон нутгийн логикийн төвүүдийг байгуулж, тээвэрлэлтийн хүйтэн хэлхээний тогтолцоог бүрдүүлсэн байна.	-	-	Хөдөө аж ахуйн биржийн шинэчлэл болон хүнсний ногооны агуулахын сүлжээг хөгжүүлэн "Төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ, махны хадгалалт, борлуулалтын цогцолбор төв"-ийг байгуулахаар ТЭЗҮ-ийг боловсруулсан.	ХХААХҮЯ	50.0
71	4.2.10. Зарим их, дээд сургуулийг мэргэжлийн чиглэл, салбараар нь төрөлжүүлж, дагуул хотууд болон орон нутагт хотхон байгуулан шилжүүлэх замаар хотын төвлөрлийг сааруулах	Зарим их, дээд сургуулийг дагуул хотууд болон орон нутагт шилжүүлсэн байна.	-	-	1. Өмнөговь аймагт "Сургалт-эрдэм шинжилгээ-үйлдвэрлэлийн цогцолбор"-ын ерөнхий төлөвлөгөөний урьдчилсан загвар, ерөнхий ажлын төлөвлөгөө, урьдчилсан тооцоо, томсгосон төсвийг хийж гүйцэтгэсэн бөгөөд 20 га газрын гэрчилгээг гаргуулахаар Өмнөговь аймгийн Засаг даргын Тамгын газартай тохиролцсон. Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 321 дүгээр тогтоолын 1.2 дэх хэсэгт "Өмнөговь аймагт эрчим хүч, геологи, уул уурхай, барилга, мэдээллийн технологийн чиглэлээр Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн харьяа сургуулийг шинээр байгуулах" гэж заасны дагуу Засгийн газрын 2022 оны 293 дугаар тогтоолоор Технологийн дээд сургуулийг байгуулж, 2022-2023 оны хичээлийн жилд 4 хөтөлбөрөөр 120 оюутан элсүүлэн сургалтын үйл ажиллагаагаа эхлүүллээ. Тухайн сургуулийг ирээдүйд 3,000 оюутан сургах боломжтой "Сургалт-эрдэм шинжилгээ үйлдвэрлэлийн цогцолбор"-оор хөгжүүлэхээр төр, хувийн түншлэлийн хүрээнд Оюу Толгой ХХК-тай хамтарсан ажлын хэсгийг БШУ-ны сайдын тушаалаар байгуулан ажиллаж байна. Тус ажлын хүрээнд БШУЯ, Оюу Толгой ХХК-тай харилцан ойлголцлын санамж бичиг байгуулсан. Оюу толгой ХХК нь "Сургалт-эрдэм шинжилгээ үйлдвэрлэлийн цогцолбор"-ын Техник эдийн засгийн үндэслэл, барилгажилтын зургийг хийж гүйцэтгүүлэхээр худалдан авах ажиллагааг зарлан, сонгон шалгаруулалт хийж гүйцэтгэгч аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулсан. Техник эдийн засгийн үндэслэл, барилгажилтын зураг хийх ажил 2023 оны 9 дүгээр сард бэлэн болно. Мөн 5 дугаар сард Монгол Улсын Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүдийн хамтаар Өмнөговь аймагт ажиллах үеэр "Сургалт-эрдэм шинжилгээ үйлдвэрлэлийн цогцолбор"-ын бүтээн байгуулалтын шавийг тавих ёслолд оролцон тухайн төслийг амжилттайгаар эхлүүлсэн. 2. Хөшигийн хөндий дэх Их, дээд сургуулиудын нэгдсэн "Сургалт эрдэм шинжилгээ үйлдвэрлэлийн цогцолбор"-ын хүрээнд: Хөшигийн хөндий дэх "Сургалт эрдэм шинжилгээ үйлдвэрлэлийн цогцолбор" нь 20,000 оюутан 4,000 багш ажилчидтай орчин үеийн Дижитал шийдлүүдээр сургалтын орчин бүрдүүлсэн их, дээд сургуулиудын нэгдсэн цогцолбор болох юм. Хөшигийн хөндийд 500 га газарт "Сургалт, эрдэм шинжилгээ, үйлдвэрлэлийн цогцолбор"-ыг байгуулахаар шийдвэрлэсний дагуу эхний ээлжид ерөнхий төлөвлөгөөний урьдчилсан загвар, ерөнхий	БШУЯ	70.0

				ажлын төлөвлөгөө, урьдчилсан тооцоо, томсгосон төсвийг хийж гүйцэтгэсэн. Барилга хот байгуулалтын сайдын багцын санхүүжилтээр “Сургалт эрдэм шинжилгээ үйлдвэрлэлийн цогцолбор”-ын ерөнхий төлөвлөгөө боловсруулах худалдан авах ажиллагаа зарлагдан сонгон шалгаруулалт хийгдсэн. Шалгарсан аж ахуйн нэгж ерөнхий төлөвлөгөөний ажлын даалгавар гүйцэтгэх хугацааны дагуу 2023 оны 1 дүгээр сард хүлээлгэн өгнө. БШУЯ болон БХБЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга нарын хамтарсан баг гүйцэтгэгч аж ахуйн нэгжтэй 3 удаагийн зөвлөх уулзалтыг хийсэн. Мөн DELL ХХК-ийн төлөөлөлтэй уулзалт зохион байгуулж, олон улсын туршлага судлан зөвлөгөө авч хамтран ажиллаж байна. 3. Орхон аймаг дахь технологийн сургуулийг инженер, технологийн чиглэлээр, “Сургалт-эрдэм шинжилгээ-үйлдвэрлэлийн цогцолбор” болгон хөгжүүлэх ажлын хүрээнд: “Сургалт-эрдэм шинжилгээ-үйлдвэрлэлийн цогцолбор”-ыг байгуулах 50 га газарт ерөнхий төлөвлөгөөний урьдчилсан загвар, ерөнхий ажлын төлөвлөгөө, урьдчилсан тооцоо, томсгосон төсвийг гүйцэтгэсэн. “Сургалт-эрдэм шинжилгээ-үйлдвэрлэлийн цогцолбор”-оор төрөлжүүлэн хөгжүүлэхтэй уялдуулан богино, дунд, урт хугацааны төлөвлөлт хийх, хүний нөөцийг чадавхжуулах, мэргэжилтэн бэлтгэх олон улсын болон дотоодын дэвшилтэт технологийг нутагшуулах, “Сургалт-эрдэм шинжилгээ-үйлдвэрлэл”-ийн уялдаа холбоог хангах, шаардлагатай хөрөнгө оруулалт, санхүүгийн дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн хамтын ажиллагааны ойлголцлын санамж бичгийг Боловсрол, шинжлэх ухааны яам “Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газартай байгуулан ажиллаж байна. 4. Дархан-Уул аймаг нь үйлдвэрийн хотын уламжлалтай, улсын авто зам ба төмөр замын гол босоо тэнхлэг дайран өнгөрдөг, эрчим хүч, усан хангамжийн найдвартай эх үүсвэртэй, инженерийн болон нийгмийн дэд бүтцийн хөгжил сайтай, их, дээд сургуулийн салбаруудтай, ажиллах хүчин хүрэлцээтэй, иргэдийн амьдрал, ахуйн соёлын төвшин харьцангуй сайн зэргийг үндэслэн Хөдөө аж ахуй, газар тариалангийн чиглэлийн 5,000 оюутан суралцах “Сургалт эрдэм шинжилгээ үйлдвэрлэлийн цогцолбор” болгон хөгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. 2022-2023 оны хичээлийн жилд орон нутаг дахь элсэгчдийн тоог нэмэгдүүлэх чиглэлээр Дархан-Уул аймаг дахь их, дээд сургууль, политехникийн коллежуудын үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөгөөг гаргаж, хэрэгжилтэд тогтмол хяналт тавин ажиллаж байна. Дархан-Уул аймаг дахь “Сургалт эрдэм шинжилгээ үйлдвэрлэлийн цогцолбор”-ын үйл ажиллагааг хоёр үе шаттайгаар хэрэгжүүлэх бөгөөд эхний үе шатанд өнөөгийн их, дээд сургуулиуд, политехник коллежуудыг цогцолбор хэлбэрээр дахин төлөвлөж, /барилга, үл хөдлөх хөрөнгийг дахин засварлах, өргөтгөх, шинээр барих, барилгын их засвар, өргөтгөлийн ажлуудыг эхлүүлэхээр 2022, 2023 оны улсын төсөвт 5.0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг суулган, 2022 оны төсвийн хөрөнгө оруулалт болох 1.4 тэрбум төгрөгийн санхүүжилтээр эхний ээлжийн бүтээн байгуулалтын ажлуудыг эхлүүлээ. Хоёр дахь үе шатанд Хөдөө аж ахуй, газар тариалангийн чиглэлийн 5,000 оюутан суралцах “Сургалт эрдэм шинжилгээ үйлдвэрлэлийн цогцолбор”-ыг байгуулахаар шинээр олгогдсон 30 га газрын гэрчилгээг гаргуулж, ерөнхий төлөвлөгөөний урьдчилсан загвар, ерөнхий ажлын төлөвлөгөө, урьдчилсан тооцоо, томсгосон		
--	--	--	--	---	--	--

					төсвийг хийж гүйцэтгэсэн.		
Зорилт 4.3.Аймгийн төвүүдийг бие даасан хот болгон хөгжүүлж, орон нутаг төсвийн орлогоо бие даан бүрдүүлэх санхүү, эдийн засгийн боломжийг бүрдүүлнэ.							
72	4.3.1. Хот, хөдөөгийн хөгжлийн тэнцвэрийг хангах хүрээнд Хангайн бүсийн тулгуур төв болон томоохон уул уурхайг түшиглэсэн говийн бүсийн хот, сууринг хөгжүүлэх	Хангайн бүсийн тулгуур төв, Орхон аймгийн төв Эрдэнэт хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, Өмнөговь аймгийн Ханбогд, Цогтцэций, Гурвантэс сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлсэн байна.	-	-	1. Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуульд Хангайн бүсийн тулгуур төв, Орхон аймгийн төв Эрдэнэт хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах саналыг БХБЯ-аас 2021 оны 08 дугаар сарын 13-ны өдрийн 1/3248 тоот албан бичгийг СЯ-нд хүргүүлж 2022 оны улсын төсөвт 2.0 тэрбум төгрөгийг тусгуулсан. Үүний дагуу БХБЯ-ны ТНБД-ын 2022 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн А/10 дугаар тушаалаар байгуулагдсан үнэлгээний хороо Хангайн бүсийн тулгуур төв Эрдэнэт хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг зарлаж гүйцэтгэгч байгууллагаар "Нью Урбанизм" ХХК-ийг сонгон шалгаруулсан, гэвч 2022 оны төсвийн тодотголоор уг ажлын санхүүжилтийн эх үүсвэр улсын төсвөөс хасагдсан тул тендер хүчингүй болж цуцлагдсан. Хот байгуулалтын тухай хуулийн 15.1.1-т бүсийн хөгжлийн тулгуур төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, тэдгээрийн суурь судалгааг улсын төсвөөс санхүүжүүлэхээр заасны дагуу Хангайн бүсийн тулгуур төв Эрдэнэт хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулахад шаардлагатай 1.3 тэрбум төгрөгийн санхүүжилтийг 2023 оны улсын төсөвт тусгуулах саналыг СЯ-нд хүргүүлсэн. 2. Өмнөговь аймгийн Ханбогд сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний тодотгол, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлыг "Оюу Толгой" ХХК-ийн санхүүжилтээр "Эн Эй Пи" ХХК гүйцэтгэж, Өмнөговь аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021.12.02-ны өдрийн хурлаар хэлэлцүүлж, Өмнөговь аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлын 2021 оны 192-р тогтоолоор баталсан. Өмнөговь аймгийн Ханбогд сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний тодотгол, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг Барилга, хот байгуулалтын сайдын зөвлөлийн 2022 оны 3 дугаар сарын 24-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлсэн. Өмнөговь аймгийн Ханбогд сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний тодотгол, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг Засгийн газрын хуралдаанд танилцуулахаар ЗГХЭГ-т 2022 оны 4 дүгээр сарын 7-ны өдрийн 1/1480 тоот албан бичгээр хүргүүлж, Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар Засгийн газрын 2022 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн хуралдаанд танилцуулж, Засгийн газрын 2022 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 19 дүгээр тэмдэглэл гарсан. Өмнөговь аймгийн Ханбогд сумыг хот болгон хөгжүүлэх ажлын хүрээнд Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ 2022 оны 05 дугаар сарын 26-ны өдөр тус суманд УИХ, Засгийн газрын зарим гишүүний хамт биечлэн ажиллаж, "Ханбогд хөгжлийн ерөнхий төлөвлөгөө-2040" төлөвлөлтийн баримт бичгийг танилцуулж, Өмнөговь аймаг, Ханбогд сумын удирдлагуудад хүлээлгэн өгсөн. Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, "Оюутолгой" ХХК-ийн гүйцэтгэх захирал Дэйдрэ Лингенфэлдер, Өмнөговь аймгийн Засаг дарга Р.Сэддорж, Ханбогд сумын Засаг дарга Х.Нэхийт нар уг ерөнхий төлөвлөгөөг 5 жилийн хугацаатай хэрэгжүүлэхэд "Оюутолгой" ХХК-иас 50 сая долларын хөрөнгө оруулалт хийх санамж бичигт 2022 оны 05 дугаар сарын 26-ны өдөр гарын үсэг зурсан. 3.Өмнөговь аймгийн Цогтцэций сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах зургийн даалгаврыг 2021 оны 06 дугаар сарын 14-ний өдөр Өмнөговь аймгийн Засаг дарга баталсан. Зөвлөх үйлчилгээний тендерийг "Эрдэнэс Тавантолгой"	БХБЯ	100.0

					ХК-иас зохион байгуулж, гүйцэтгэгчээр “Эрхэт констракшн” ХХК-ийг шалгаруулж 2021 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн ЭТТ-2021/748 дугаар гэрээг байгуулсан.Барилга, хот байгуулалтын сайдын 2022 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 24 дугаар тушаалаар ЭХЯ, ЗТХЯ, УУХҮЯ, АМГТГ, ГЗБГЗЗГ, “Эрдэнэс таван толгой” ХК, “Тавантолгой төмөр зам” ТӨХК, “Таван толгой” ХК-ийн төлөөллийг оролцуулсан Өмнөговь аймгийн Цогтцэций сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах ажлыг удирдлага, зохицуулалтаар хангах үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулж ажилласан. Уг хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг Цогтцэций сумын ИТХ-ын 2022 оны 09 дүгээр сарын 06-09 өдрийн 8 дугаар хуралдаан, Өмнөговь аймгийн ИТХ-ын 2022 оны 09 дүгээр сарын 12-15-ны хуралдаанаар тус тус хэлэлцүүлж дэмжигдсэн. Мөн МАЭ-ийн хот төлөвлөлт, архитектурын орон тооны бус мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцэгдэж зөвлөмж гарсан.Одоо Өмнөговь аймгийн Цогтцэций сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг БХБЯ-ны ШУТТЗХ-аар 2022 оны 12 дугаар сарын 12-ны өдөр хэлэлцүүлж, экспертиз /магадлал/-ийн дүгнэлт гарсан. 4. Өмнөговь аймгийн Гурвантэс сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах зургийн даалгаврыг Барилга хот байгуулалтын сайд болон Өмнөговь аймгийн Засаг дарга нар хамтран 2021/69 дугаартай баталсан. Тус яамнаас ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулан гүйцэтгэгчээр нийслэлийн "Хот төлөвлөлт судалгааны институт" ОНӨААТҮГ-ыг шалгаруулж, 2021/493 тоот зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээг байгуулсан. Гүйцэтгэгч байгууллагаас Гурвантэс сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг ерөнхий төлөвлөгөө боловсруулж дуусган Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатарт 2022 оны 10 дугаар сарын 13-ны өдөр танилцуулсан. Уг хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг 2022 оны 05 дугаар сарын 24-нээс 2022 оны 06 дугаар сарын 21-ний өдрүүдэд Өмнөговь аймгийн ЗДТГ, Гурвантэс сумын ЗДТГ-аар хэлэлцүүлж дэмжигдсэн. Мөн 2022 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн МАЭ-ийн хот төлөвлөлт, архитектурын орон тооны бус мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцэгдэж зөвлөмж гарсан. Одоо Өмнөговь аймгийн Гурвантэс сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг БХБЯ-ны ШУТТЗХ-аар 2022 оны 12 дугаар сарын 12-ны өдөр хэлэлцүүлж, экспертиз /магадлал/-ийн дүгнэлт гарсан.		
73	4.3.2. Сумдын инженерийн дэд бүтцийн хангамжийн ашиглалт, үйлчилгээг нэгдсэн байдлаар зохион байгуулж, хэрэглэгчдэд иж бүрэн, чирэгдэлгүй үйлчилгээг үзүүлэх	Хэрэглэгчдийг нийтийн аж ахуйн иж бүрэн үйлчилгээгээр хангасан байна.	-	-	БХБЯ: Засгийн газрын 2021 оны 161-р тогтоолоор баталсан “Сумын хөгжил: Инженерийн дэд бүтцийн хангамж” төсөл, арга хэмжээнд сумын инженерийн дэд бүтцийн хангамж, ашиглалт, үйлчилгээг 3 хэлбэрээр зохион байгуулахаар тусгасан. Үүнд: 1.Тухайн аймгийн төвд үйл ажиллагаа эрхэлдэг тусгай зөвшөөрөл бүхий нийтийн аж ахуйн үйлчилгээний байгууллагын салбар нэгж хариуцах; 2.Сумын төвд үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий бие даасан орон нутгийн өмчит аж ахуйн нэгж байгуулж хариуцуулах; 3.Сумын төвийн дулаан хангамжийн үйл ажиллагааг хариуцан ажиллаж байгаа тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгжтэй менежментийн гэрээ байгуулан гүйцэтгүүлэх. Эрчим хүчний яам, Эрчим хүчний зохицуулах хороо, Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн төлөөллийг оролцуулан сумдад инженерийн дэд бүтцийн хангамжийн ашиглалт, үйлчилгээг хариуцсан 1 байгууллага байх,	БХБЯ, ЭМЯ	50.0

					аймгуудын Эрчим хүчний салбар зөвлөлийг түшиглэн ус хангамж, ариутгах татуургын чиглэлээр тусгай зөвшөөрөл олгох, ус хангамж, ариутгах татуургын үйлчилгээний үнэ тарифыг баталдаг салбар зөвлөл байгуулах, энэ шинээр өргөтгөн байгуулах аймгийн салбар зөвлөлийн үйл ажиллагаанд Эрчим хүчний зохицуулах хороо, Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөл нь мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллах зохицуулалтыг хийх зэрэг зохион байгуулалтыг хийх зорилго бүхий ажлын хэсэг байгуулан ажиллаж байна. ЭМЯ: Улсын хэмжээнд 330 сумын эрүүл мэндийн төвүүдийн ариун цэврийн байгууламжийн судалгааг бүрэн гаргаж дууссан. Сумын эрүүл мэндийн төвийн ариун цэврийн байгууламжийн зураг төслийн даалгаврыг боловсруулан, нэг маягийн зураг төсөл хийхээр боловсруулж дууссан. Төслийг хэрэгжүүлэх худалдан авах ажиллагааг зохион байгуулахаар тендерийн баримт бичиг боловсруулалтын шатанд явж байна.		
74	4.3.3.Инженерийн шугам сүлжээний найдвартай, хэвийн ажиллагааг хангах	Инженерийн дэд бүтцийн хангамжийн шугам сүлжээний ашиглалт сайжирч, ашиглалтын зардал буурсан байна.	-	-	Инженерийн шугам сүлжээний найдвартай, хэвийн ажиллагааг хангах зорилгоор улсын төсвийн болон гадаадын зээлийн хөрөнгөөр дараах арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд: 1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар инженерийн бэлтгэл арга хэмжээний 12, шугам сүлжээний 80, сумын хөгжил, инженерийн дэд бүтцийн хангамж төсөл 15 суманд, сумын төвийн шинэчлэл төсөл 7 суманд, халуун усны барилгын 11, цэвэрлэх байгууламжийн 4, эко жорлон шинээр барих төсөл 8 байршилд зэрэг нийт 137 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байгаа бөгөөд 2022 онд 56 төсөл, арга хэмжээг ашиглалтад оруулна. 2022 онд төлөвлөсөн ажлын хэрэгжилт 80 хувьтай байна. 2. Бүгд Найрамдах Австри Улсын зээлээр хэрэгжиж буй “Дархан хотын цэвэр усны шугам сүлжээг өргөтгөх, шинэчлэх, ухаалаг тоолуур нэвтрүүлэх төсөл”-ийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, 2022 оны 09 дүгээр сарын 09-нд “Ти Ар Эм” ХХК-тай түлхүүр гардуулах нөхцөлтэйгөөр 2022/455 дугаар ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан. Төслийн санхүүжилт-7.5 сая евро, төсөл 2022-2024 он хүртэл 24 сар үргэлжилнэ. Төслийн хүрээнд 13,300 м цэвэр усны шугам, 15,000 ширхэг цэвэр усны ухаалаг тоолуур суурилуулахаар төлөвлөсөн. Ажлын явц-10 хувьтай байна. 3. БНХАУ, АХБ, БНПУ-ын зээлээр УБ хот болон аймгийн төвүүд, сумдад бохир ус цэвэрлэх байгууламжийг шинээр барих төслийг 18 байршилд хэрэгжүүлснээс 9 байршлын цэвэрлэх байгууламжийг 2018-2022 онд байнгын ашиглалтад оруулсан. Үлдсэн 9 байршилд төсөл үргэлжлэн хэрэгжиж байна. 2022 онд төлөвлөсөн ажлын хэрэгжилт 90 хувьтай байна. 4.Орон сууц, нийтийн аж ахуйн чиглэлээр Улаанбаатар хотод 4 байгууллага, орон нутагт 29 байгууллага, нийт 33 байгууллага үйл ажиллагаа эрхэлж байна. Эдгээр байгууллагууд өвөлжилтийн бэлтгэл ажилд 34.9 тэрбум төгрөгийн санхүүжилт зарцуулан 1628 нэр төрлийн ажил гүйцэтгэхээр төлөвлөсөн бөгөөд 2022 оны байдлаар 1628 нэр төрлийн ажилд 27.13 тэрбум төгрөг зарцуулаад байна. Биелэлт улсын хэмжээнд 98 хувьтай байна. Үүнээс: Нийслэлд 99 хувь, орон нутагт 97 хувийн биелэлттэй байна.	БХБЯ	90.0
Зорилт 4.4.Эдийн засгийн бүсчилсэн хөгжлийн бодлогод тулгуурлан мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэлийн тогтвортой өсөлтийг дэмжиж, хүнсний дотоодын хэрэгцээг							

ханган, экспортын хувь хэмжээг нэмэгдүүлнэ.							
75	4.4.1. Тэжээлийн ургамал, эмийн ургамал тариалах, хүлэмжийн аж ахуй эрхлэх, загас үржүүлэх үйл ажиллагаа эрхлэгчдийг бодлогоор дэмжих	3500 га-аар жимсний талбайг нэмэгдүүлж, 450 байршилд агро ойн аж ахуйг хөгжүүлж, 120 га талбайд тариалангийн талбайн хамгаалалтын зурвас байгуулсан байна. Тэжээлийн ургамал, эмийн ургамал тариалах, хүлэмжийн аж ахуй эрхлэх, загас үржүүлэх зэрэг байгаль орчинд ээлтэй бизнес эрхлэх сонирхол нэмэгдсэн байна.	-	-	ХХААХҮЯ: 1.Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах зарим арга хэмжээний тухай УИХ-ын 36 тогтоолд 50 га өвлийн хүлэмжийн цогцолбор аж ахуй, 100 га зуны хүлэмж шинээр байгуулахаар тусган хэрэгжилтийг зохион байгуулж байна. Тус арга хэмжээний хүрээнд 2023 оны улсын төсөвт зээлийн хүүгийн хөнгөлөлт үзүүлэхээр 12.0 тэрбум төгрөгийг тусгаж хүлэмж байгуулахад хөнгөлөлттэй зээл олгохоор төлөвлөн ажиллаж байна. Засгийн газрын 2022 оны 118 дугаар тогтоолд хүлэмжийн аж ахуйд өвлийн улиралд хэрэглэсэн цахилгааны төлбөрийг 2022 оны 11 сарын 01-ээс 2023 оны 05 сарын 01 хүртэл оройн 22 цагаас өглөөний 06 цаг хүртэл 1 м2 талбайд 0768/кв.цагаар хөнгөлж байсныг 10 дугаар сарын 15-аас эхлэн 05 сарын 01 хүртэл оройн 18 цагаас өглөөний 06 хүртэл болгож хөнгөлөлтийн хугацааг уртасгаснаар өвлийн хүлэмжийн аж ахуй хөгжих суурь нөхцөлийг бүрдүүлэв. Энэхүү тогтоолын дагуу 255 иргэн, аж ахуйн нэгжийн нийт 36 га өвлийн хүлэмжийг хөнгөлөлтөд хамруулаад байна. 2. ХААИС нь БНСУ-ын Эрчим хүчний технологийн үнэлгээ төлөвлөлтийн газрын санхүүжилтээр 2250 м2 нарны эрчим хүч үйлдвэрлэх систем бүхий орчин үеийн давхар нийлэг хальсан хүлэмж, Скай хайпермаркет ХХК 4000 м2 тавцант тариалан бүхий хүлэмж , Ногоон өндрийн хишиг ХХК 3900 м2 өвлийн нарлаг хүлэмжийн аж ахуйг ашиглалтад оруулаад байна. 3. Төгс ургац ХХК Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүрэгт 2 га талбай бүхий орчин үеийн дэвшилтэд технологи бүхий өвлийн шилэн хүлэмж, Премиум групп ХХК БНСУ-ын Plant farm компанитай хамтран 4000 м2 өвлийн гидропоник хүлэмж байгуулж байна.2022 онд хувийн хэвшлийн 55 аж ахуйн нэгж шинээр 3.6 га өвлийн хүлэмж байгуулж ашиглалтад оруулсан ба 2.4 га хүлэмж байгуулж байна. 4. 2022 онд улсын төсвийн 900.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн суманд 400 м2, Хөвсгөл аймгийн Мөрөн суманд 500 м2 өвлийн хүлэмж , АХБ-ны 1.2 тэрбум төгрөгийн санхүүжилтээр 800 м2 дэвшилтэт технологийн хүлэмжийг Улаанбаатар хотод байгуулж байна. Мөн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Сэлэнгэ аймгийн Зүүнбүрэн суманд үрсэлгээний болон өрхийн 5,700 м2 талбайтай 75 иж бүрдэл хүлэмж бүхий зуны хүлэмжийн цогцолбор аж ахуй байгуулав. Шинэ хөдөө төслийн хүрээнд Булган, Дорнод аймагт 6,080 м2 талбайтай 67 иж бүрдэл нийлэг хальсан хүлэмж нийлүүлж өрхийн аж ахуй эрхлэгчдэд олгов. 5. 2021 оны 5-р сарын 12-ний А-135 тоот тушаалын дагуу улсын төсвийн хөрөнгөөр 2021 онд худалдаж авсан 410.0 сая төгрөгийн 244 тонн тэжээлийн овъёосны элит үрийн үнийг 50 хувь хөнгөлж 13 аж ахуйн нэгжид ХХААХҮЯ, ХААДС, аж ахуйн нэгжтэй бодлогын гэрээгээр олгосон. Мөн царгасны 8 тонн үрийг улсын төсвийн 240.0 сая төгрөгөөр худалдан авч, 30.0 хувийн урьдчилгаа нөхцөлтэйгөөр тариаланчдад олгосон. Уламжлалт эмийн 7 үйлдвэр нийт 74.9 га талбайд давхардсан тоогоор 98 төрлийн эмийн ургамлыг тарималжуулж, жилд дунджаар 6 тонн орчим эмийн түүхий эдийг хурааж авч байна. Цаашид 23 төрлийн эмийн ургамлыг тарималжуулах бэлтгэл ажлыг хангаад	ХХААХҮЯ, ЭМЯ	90.0

					байна. Мөн уламжлалт эмийн үйлдвэрээс гадна Монос фарм ХХК, Тавин-Ус ХХК нийт 120 гаруй га талбайд 8 төрлийн эмийн ургамлын масс тариалалт хийж байна. Түүнчлэн үндэсний уламжлалт эмийн үйлдвэрүүдийг дэмжих зорилгоор судалгаа авч 4 үйлдвэрийн хүсэлтийг Монгол банкнаас хэрэгжүүлж байгаа Репо санхүүжилтийн зээлд хамруулах хүсэлтийг ЭМЯ-аас албан ёсоор хүргүүлээд байна. ЭМЯ: Уламжлалт эмийн 7 үйлдвэр нийт 74.9 га талбайд давхардсан тоогоор 98 төрлийн эмийн ургамлыг тарималжуулж, жилд дунджаар 6 тонн орчим эмийн түүхий эдийг хурааж авч байна. Цаашид 23 төрлийн эмийн ургамлыг тарималжуулах бэлтгэл ажлыг хангаад байна. Мөн уламжлалт эмийн үйлдвэрээс гадна Монос фарм ХХК, Тавин-Ус ХХК нийт 120 гаруй га талбайд 8 төрлийн эмийн ургамлын масс тариалалт хийж байна. Түүнчлэн үндэсний уламжлалт эмийн үйлдвэрүүдийг дэмжих зорилгоор судалгаа авч 4 үйлдвэрийн хүсэлтийг Монгол банкнаас хэрэгжүүлж байгаа Репо санхүүжилтийн зээлд хамруулах хүсэлтийг ЭМЯ-аас албан ёсоор хүргүүлээд байна.		
ТАВ.НОГООН ХӨГЖЛИЙН СЭРГЭЛТ							
Зорилт 5.1.Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулахад дорвитой хувь нэмэр оруулах зорилгоор "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг үр дүнтэй өрнүүлж, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг дэмжих хууль, эрх зүйн орчныг бүрдүүлнэ.							
76	5.1.1. "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд мод тарьж, арчилж ургуулах ажлыг нарийвчилсан стратеги, төлөвлөгөөний хүрээнд үр дүнтэй хэрэгжүүлэх	Шинээр тарьж, арчилж ургуулсан мод, ойгоор бүрхэгдсэн талбайн хэмжээ нэмэгдсэн байна.	/орон нутийн төсөв, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хөрөнгө, хандив/	-	БОАЖЯ: "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хэрэгжүүлэх нарийвчилсан стратеги төлөвлөгөөний төслийг боловсруулсан. Төлөвлөгөөний төслийг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2022 оны А/83 дугаар тушаалаар байгуулсан ажлын хэсгийн 2022 оны 8 дугаар сарын 19-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлсэн. "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх хүрээнд 3,148.2 га талбайд ойжуулалт, 168 га талбайд байгалийн сэргэн ургалтыг дэмжих ажил, 608.4 га талбайд хамгаалалтын ойн зурвас, 445.4 га талбайд ногоон байгууламж, нийт 4,370 га талбайд ойжуулалт нөхөн сэргээлт, ногоон байгууламжийн ажлыг хэрэгжүүлсэн. Үүнээс улсын төсвийн хөрөнгөөр 532 га талбайд, байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар 1,000.1 га талбайд, төсөл, хөтөлбөр, аж ахуйн нэгж байгууллагын хөрөнгөөр 1,989.8 га талбайд тус тус хэрэгжүүлсэн. "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөн болон "Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр"-ийн хүрээнд мод тарих ажилд 355,923 иргэн, 16,104 аж ахуйн нэгж, байгууллага оролцож, нийт 10,129.0 мянган ширхэг мод, сөөгийг тарьсан. Дээрх арга хэмжээг авч хэрэгжүүлсний үр дүнд ойгоор бүрхэгдсэн талбайн хэмжээ 8.0 хувьд хүрсэн. ХХААХҮЯ: Хүнсний хангамж, аюулгүй байдлын талаар авах зарим арга хэмжээний төлөвлөгөөний батлах тухай УИХ-ын 36 дугаар тогтоолд жимс жимсгэний талбайг 20.0 мянган га-д хүргэх, бүх аймагт суулгац үржүүлгийн төв байгуулах, агро-ойн аж ахуй байгуулах асуудлыг тусган хэрэгжилтийг зохион байгуулж байна. 2022 оны 04 сарын 14-ний өдөр "Жимс, жимсгэнэ тариаланчдын улсын зөвлөгөөн"-ийг Улаанбаатар хотод зохион байгуулж, нийт 22 аймаг, нийслэлийн 150 гаруй төлөөлөгчид оролцуулсан. Жимс жимсгэний салбарын чиглэлээр хэрэгжүүлэх ажлын талаар санал солилцож 16 зүйл заалт бүхий цаашид хэрэгжүүлэх ажлын зөвлөмж боловсруулж гаргав. Япон улсын Жайка олон улсын байгууллагын санхүүжилтээр хэрэгжиж буй "Монголын хөдөө аж ахуйн салбарын нэмүү өртгийн сүлжээний мастер төлөвлөгөө боловсруулах" төслийн 60.0 сая төгрөгийн санхүүжилтээр Төв аймгийн Борнуур суманд жимс	БОАЖЯ, ХХААХҮЯ	90.0

					жимсгэний судалгаа, суулгац үржүүлгийн загвар төв байгуулав. “Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд суулгац үржүүлгийн төв байгуулах” ТШ/2022/суулгац төв тендер шалгаруулалт зохион байгуулж Төв аймгийн Борнуур сум дахь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн Судалгаа хөгжлийн төв болон Говь-сүмбэр аймгийн ХХААГ-т тус бүр 3 га талбай, ойн зурвас бүхий суулгац үржүүлгийн төв байгуулж 8 төрлийн жимсний 3000 гаруй ширхэг эх модны суулгац тариалж нутагшсан, чанарын баталгааны бүхий дотоодын суулгац үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх боломж бүрдүүлэв. Тэрбум мод хөдөлгөөний хүрээнд жимс жимсгэний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх агро-ойн аж ахуй байгуулах зорилгоор улсын төсвийн 500.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн суманд 11 га талбай бүхий агро-ойн аж ахуй байгуулах, 400 м2 өвлийн хүлэмж байгуулах, хашаажуулах, эрчим хүчний шугам татах, 1000 ширхэг жимсний мод тариалах ажлын тендер шалгаруулж гэрээ байгуулан ажлыг гүйцэтгүүлж, 2023 онд ашиглалтад оруулахаар ажиллаж байна. Агро ой аж ахуй, Агро паркын техник эдийн засгийн үндэслэл, нэг маягийн зураг төсөл боловсруулж дуусаж байна. Жимс, жимсгэний үндэсний холбоотой хамтран 30.0 сая ам.долларын өртөг бүхий "Жимс жимсгэнэ" төсөл боловсруулж, Ерөнхийлөгчийн тамгын газарт хүргүүлсэн.		
Зорилт 5.2.Усны нөөцийг хамгаалж, хүн амыг баталгаат ундны усаар хангах, бэлчээрийг усжуулах, говийн бүс нутгийн усан хангамжийг нэмэгдүүлэх, саарал усыг дахин ашиглах, хиймэл нуур, хөв цөөрөм байгуулж, ширгэсэн гол горхи, булаг, шандыг нөхөн сэргээнэ.							
77	5.2.1. Усны нөөцийг хамгаалах, зүй зохистой ашиглах бодлого хэрэгжүүлж, хүн амыг эрүүл ахуйн шаардлага хангасан ундны усаар хангаж, үйлдвэрлэл, хөдөө аж ахуйн ус хангамжийг сайжруулж, нөөцийн хуримтлал бий болгох	Хамгаалалтад авсан гол мөрний урсац бүрэлдэх эх, ус хангамжийн эх үүсвэрийн болон томоохон голуудад барьсан усан сангийн тоог нэмэгдүүлж, эрүүл ахуй, стандартын шаардлага хангасан ундны усаар хангагдсан хүн амын эзлэх хувийг нэмэгдүүлсэн байна.	-	-	БОАЖЯ: 1.Гол мөрний урсац бүрэлдэх эх нь нийт 143998.8 км2 талбайг хамаардаг бөгөөд энэ нь Монгол Улсын нийт нутаг дэвсгэрийн 9.2 хувийг эзэлдэг. 2021 оны байдлаар гол мөрний урсац бүрэлдэх эхийн 49.91 хувь болох 71,949.05 км2 талбайг улсын тусгай хамгаалалтад авсан. Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн 02 дугаар тогтоолоор “Ямаат-Шаварын голын эх” орчмын газар нутаг болох 226,175.9 га газрыг орон нутгийн тусгай хамгаалалтад 2042 оны 03 дугаар сарын 31-ний өдөр хүртэл 20 жилийн хугацаагаар авсан. 2022 онд улсын төсвийн хөрөнгөөр дараах 4 сумын хүн амын ус хангамжийн эх үүсвэрийн нөөцийг тогтоох хайгуул, судалгааны ажлыг хийхээр төлөвлөсөн. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу дээрх 4 багц ажлын зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг 2022 оны 1 дүгээр улиралд зохион байгуулж, шалгаруулсан боловч, Улсын төсвийн тодотголоор батлагдсан 1.2 тэрбум төгрөгийн санхүүжилт хасагдаж, 240 сая төгрөгийн санхүүжилт үлдсэн тул Дорноговь аймгийн Дэлгэрэх суманд хайгуул хийхээр шийдвэрлэсэн. Гүйцэтгэгчээр усны хайгуул судалгаа хийх эрхтэй “Таширын хүрээ” ХХК шалгарсан бөгөөд 2022 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр Дугаар № БОАЖЯ/202211021/01/01 дугаартай гэрээ байгуулж, Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын төвийн хүн амын унд ахуйн ус хангамжийн зориулалттай газрын доорх усны хайгуул судалгааны ажлыг бүрэн хийж дууссан. 2022 онд Хөвсгөл аймгийн Түнэл, Хэнтий аймгийн Дэлгэрхаан, Өмнөговь аймгийн Даланзадгад, Баяндалай, Сэлэнгэ аймгийн Орхонтүүл суманд 110.541.0 м3 багтаамжтай 5 ширхэг хөв цөөрмийг	БОАЖЯ, ЭМЯ	50.0

					барьж ашиглалтад оруулсан. Усалгаатай Увс аймгийн Хяргас суманд газар тариалангийн усалгааны зориулалттай 1800 мянган м3 багтаамжтай хөв цөөрөм байгуулж хүлээн авч, ашиглалтад оруулаад байна. ЭМЯ: Ундны ус, ариун цэврийн байгууламжийн аюулгүй байдлын төлөвлөгөөг боловсруулж, улсын хэмжээнд хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2022 онд Орхон аймгийн Жаргалант сум, Архангай аймгийн Эрдэнэмандал, Тариат, Өндөр-Улаан сум зэрэг 4 газрын ундны усны аюулгүй байдлыг төлөвлөгөөний хэрэгжилтэд хөндлөнгийн аудит, ус хангамжийн тогтолцоонд эрсдэлийн үнэлгээ хийж, төлөвлөгөөний төслийг боловсруулан ус хангагч байгууллагын ажилчдад талбарын дадлага ажил зохион байгуулан ажилласан.		
78	5.2.2. Нийгмийн үйлчилгээний зориулалттай барилга байгууламжийг барихад эрчим хүчний хэмнэлттэй, саарал усыг дахин ашиглах технологийн шаардлагыг хангах	Нийгмийн үйлчилгээний зориулалттай барилга байгууламжийг ногоон технологийн дагуу барьж, урсгал зардлыг бууруулсан байна.	-	-	БОАЖЯ: Улсын хэмжээнд 2020 онд 307 иргэн, аж ахуйн нэгж байгууллага 444 тоолуур шинээр, 2021 онд 420 иргэн, аж ахуйн нэгж байгууллага 850 тоолуурыг суурилуулсан. 2020 онд ус ашиглуулах дүгнэлтээр нийт ашиглах усны хэмжээ 1,620,347.9 м3/хоног үүнээс эргэлтээр ашиглах усны хэмжээ 1,148,164.2 м3/хоног, нөхөн сэлбэлтээр 430,455.8 м3/хоног байна. 2021 онд нийт ашигласан усны хэмжээ 594.8 сая.м3/жил ба уул уурхайн салбарт нөхөн сэлбэлтээр ашигласан усны хэмжээ 113.4 сая.м3/жил байна. Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн 8.1.2 дахь заалтын дагуу хаягдал усыг цэвэрлэж, эргүүлэн үйлдвэрлэлд ашигласан хэмжээгээр ус бохирдуулсны төлбөрөөс 100 хувь чөлөөлсөн. Үүнд: 2020 онд 3.17 тэрбум төгрөг, 2021 онд 3.18 тэрбум төгрөг, 2022 онд 680.0 сая төгрөг тус тус чөлөөлсөн байна. Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлж байгаа төслийн хүрээнд Архангай, Хархорин, Хужирт хашаан, Хан хужирт сувиллын газруудад туршилтаар хаягдал усны тоолуурыг суурилуулж байна. БХБЯ: "Саарал усны систем. Ерөнхий шаардлага" MNS BS 8525-1:2015, "Дахин ашиглах цэвэрлэсэн ус. Техникийн ерөнхий шаардлага" MNS 6743:2018 стандартуудыг боловсруулж батлуулсан; АНУ-ын МСК-ийн буцалтгүй тусламжаар хэрэгжиж буй "Хаягдал ус дахин боловсруулах үйлдвэр" шинээр барих төслийн хүрээнд зураг төсөл боловсруулах Фихтнер Ватэр энд Транспортейшн (ФБТ) компани нь дараах зураг төслийн ажлуудыг гүйцэтгэсэн. Үүнд: 1. ДЦС-3, 4 ТӨХК-ийн техникийн усны зураг төсөл; 2. Ус дамжуулах гол магистраль хоолойн трасс; 3. Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ; 4. Байгаль орчин, нийгэмд нөлөөлөх байдлын үнэлгээ; 5. Ус дамжуулах хоолойн трассын дагуу газар чөлөөлөх болон нүүлгэн шилжүүлэх ажлын төлөвлөгөөг тус тус боловсруулсан. Үйлдвэрийн барилгын зураг төсөл, барилга угсралтын ажлын гүйцэтгэгчийг шалгаруулах тендерт шалгарсан "М-Си-Эс Проперти" ХХК, туслан гүйцэтгэгч Францын "Egis Water and Maritime" болон "Veolia Water Technologies" компанитай 2022 оны 05 дугаар сарын 10-нд гэрээ байгуулж, үйлдвэрийн барилга угсралтын ажлыг 2022 оны 08 дугаар сарын 25-нд эхлүүлсэн. Үйлдвэрийн техникийн зураг төслийг 2022 оны 09 дүгээр сарын 19-нд хүлээн авсан. Төслийн хэрэгжилт 20 хувьтай явж байна. "Ахуйн бохир ус цэвэрлэх байгууламж"-ийн нэг маягийн зураг төсөлд цэвэрлэх байгууламжийн цэвэрлэсэн усыг зам, талбайн угаалгад	БОАЖЯ, БХБЯ, ЭМЯ	70.0

					ашиглахаар төлөвлөж, 2021 оны 12 дугаар сарын 17-ны ЕД-2075 дугаар магадлалын дүгнэлтээр баталгаажуулан сумдад шинээр барих цэвэрлэх байгууламжийн зураг төсөл боловсруулахад ашиглаж байна. Шинэ Зуунмод хотын бохир ус цэвэрлэх байгууламжийн цэвэрлэсэн усыг дахин ашиглахаар зураг төслийн даалгаварт тусгасан. Бүгд Найрамдах Польш Улсын зээлээр Баян-Өлгий, Говьсүмбэр, Дорнод, Завхан, Увс аймгийн төвд шинээр барих бохир ус цэвэрлэх байгууламжийн ажлын зураг төсөлд цэвэрлэх байгууламжийн цэвэрлэсэн усыг дахин ашиглахаар тусгасан. Зураг төслийн боловсруулалт 90 хувьтай, магадлалаар баталгаажуулахаар хүлээгдэж байна. Говь-Алтай аймгийн төв болон УБ хотын Багануур дүүргийн бохир ус цэвэрлэх байгууламжийг шинээр барих зураг төсөл боловсруулах ажлын даалгаварт цэвэрлэх байгууламжийн цэвэрлэсэн усыг дахин ашиглахаар тусгаж, тендер зарлаж, Говь-Алтай аймгийн төвийн бохир ус цэвэрлэх байгууламжийг шинээр барих зураг төсөл боловсруулах зөвлөхөөр "Наран рашаан" ХХК шалгарсан, ажлын гүйцэтгэл 70 хувьтай, УБ хотын Багануур дүүргийн бохир ус цэвэрлэх байгууламжийн зураг төсөл боловсруулах зөвлөхөөр "Хайдродизайн прожект" ХХК ажиллаж, цэвэрлэх байгууламжийн технологийн шийдлийн танилцуулгыг "Инженерийн мэргэжлийн зөвлөл"-ийн 2022 оны 06 дүгээг сарын .24-ний хурлаар хэлэлцүүлж дэмжигдсэн. Зураг төслийн боловсруулалт 90 хувьтай. ЭМЯ: Эрүүл мэндийн салбарт АХБ-ны дэмжлэгтэй “Эмзэг бүлгийн хүн амын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг сайжруулах хөрөнгө оруулалтын хөтөлбөр” төсөл хэрэгжиж байна. Энэ төслөөр Улаанбаатар хотын Хан-Уул, Чингэлтэй дүүргийн нэгдсэн эмнэлэг, Увс, Ховд аймгийн нэгдсэн эмнэлэг, 10 өрхийн эрүүл мэндийн төв (Баянзүрх дүүргийн 2, Сонгинохайрхан дүүргийн 1, Чингэлтэй дүүргийн 2, Хан-Уул дүүргийн 3, Баянгол дүүргийн 2), 6 сумын эрүүл мэндийн төв (Архангайн Эрдэнэмандал, Булганы Дашинчилэн, Дорноговийн Эрдэнэ, Хөвсгөлийн Тариалан Ринчинлхүмбэ, Өвөрхангайн Баян-Өндөр), Үндэсний түргэн тусламжийн төвийн барилгын ажил 2019-2029 онд хийгдэнэ. Эдгээр барилгуудыг барихад “нүүрстөрөгчийн хийн ялгарал багатай технологи” (LCT–Low carbon technology) нэвтрүүлэх бөгөөд энэ чиглэлээр Японы “Azusa Sekkei” компанитай зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулан ажиллаж байна. Azusa Sekkei ХХК нь 2022 оны 6 дугаар сард ХУД-ийн Нэгдсэн эмнэлэгт, 10 дугаар сард ХУД-ийн 14-р хорооны ӨЭМТөвийн газар дээр ажиллаж, барилгын иж бүрэн зураг төсөлтэй танилцан LCT барихтай холбоотой ажлын зураг, техникийн тодорхойлолтыг боловсруулан зурган дээр техникийн шаардлагуудыг сайжруулж, тендерийн баримт бичигт тусгах шаардлагуудыг эцэслээд байна.		
Зорилт 5.3.Байгальд ээлтэй дэвшилтэт технологи бүхий хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэрүүдийг аймаг, нийслэлд бүсчлэн байгуулна.							
79	5.3.1. Нийслэл хот болон аймгийн төвүүдэд хог хаягдлыг ангилан ялгах, эх үүсвэр дээр нь бууруулах, дахин боловсруулж, эдийн засгийн эргэлтэд оруулах үйл	Хог хаягдлын дахин боловсруулалтын хэмжээг 27 хувьд хүргэсэн байна.	Гадаадын зээл тусламж	-	БОАЖЯ: Нийслэл хот болон аймгийн төвүүдэд хог хаягдлыг ангилан ялгах, эх үүсвэр дээр нь бууруулах, дахин боловсруулж, эдийн засгийн эргэлтэд оруулах үйл ажиллагааг дэмжиж чиглэлээр: 1. 2022 онд нийт 19 удаагийн танхимын болон цахим сургалтыг зохион байгуулж 1,836 гаруй хүн хамрагдав. Үүнээс ЕБС-ийн сурагчид 920, СӨХ 132, ТҮК 268, ААНБ 516 хамрагдсан байна. Мөн	БОАЖЯ, БХБЯ, ЭМЯ	70.0

	ажиллагааг дэмжиж, хог боловсруулах үйлдвэрийг барьж байгуулах				“Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба”-аас санаачлан “Эрүүл мэнд нийгмийн бодлогын хүрээлэн”-ээс хэрэгжүүлж буй “Хогоо ангилах хөдөлгөөн”-ний хүрээнд “Автобустай эко аялал”-ыг 2022 оны 10 дугаар сарын 18, 19, 20-ны өдрүүдэд Нийслэлийн ерөнхий боловсролын 14 сургуулийн эко клубийн 91 багш сурагчдыг хамруулан зохион байгууллаа. Нийслэлийн хэмжээнд 600 дахивар нөөцийн цэгт 109 хорооны нутаг дэвсгэрт байх 58,503 өрх, 165 байгууллага, 25 ерөнхий боловсролын сургууль, 26 цэцэрлэг, бусад 83 цэгт хог ангилан ялгалт хийгдэж давхардсан тоогоор 524,808 хүн хог хаягдлаа эх үүсвэр дээр ангилан ялгалт хийж, хог хаягдлыг дахин боловсруулах 17 үйлдвэрүүд рүү шилжүүлж эдийн засгийн эргэлтэд оруулсан. 2. Швейцарийн хөгжлийн агентлагийн санхүүжилтээр хэрэгжиж буй УБ хотын хог хаягдлын цуглуулалт, тээвэрлэлтийн менежментийг сайжруулах төслийн хүрээнд Нарангийн энгэрийн төвлөрсөн хогийн цэгт өдөрт 10 тонн хог хаягдал ангилан ялгах хүчин чадал бүхийн ангилан ялгах үйлдвэрийн барилгын зураг төслийг батлуулсан, Хөрсний ус илэрсэнтэй холбоотой барилгын зүүн хойд хэсэгт Инженер геологийн судалгаа хийлгэж, Гадна цахилгаан холбоход ажлын комисс ажиллуулсан. Барилгын хавтанг угсарч дууссан. Тоног төхөөрөмжүүдийг БНХАУ-аас нийлүүлсэн. 3. М-Си-Эс Кока-Кола” компанийн хуванцар савны нийлүүлэгч “Ти Эм Эл” үйлдвэр нь жилд 20 мянган тонн, PET хуванцар дахин боловсруулах хүчин чадалтай үйлдвэр Нийслэлийн Баянзүрх дүүрэгт ашиглалт орсон. Уг үйлдвэр нь хувцас үйлдвэрлэл болон ахуйн хэрэгцээний бусад эд зүйлсэд ашиглах шаардлага хангасан хуванцар дахин боловсруулж, гадаад улс орон руу экспортолж байгаа бол ирэх жилээс нэмэлт тоног төхөөрөмж суурилуулснаар хүнсний зориулалттай хуванцар сав үйлдвэрлэх аж. Ингэснээр “Ти Эм Эл” үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний 30.0 хувийг дахин боловсруулсан хуванцар сав эзлэх юм. 4. Хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэр технологийн Эко парк төслийн хүрээнд Нарангийн энгэрийн төвлөрсөн хогийн цэгийн дэргэд хуванцар хог хаягдлыг дахин боловсруулж цахилгааны хоолой үйлдвэрлэх “Инфинити пластик” ХХК -ийн үйлдвэр ашиглалтад орж үйл ажиллагаа явуулж байна. Тус үйлдвэр нь 100 хувь компанийн хөрөнгө оруулалтаар баригдсан ба дотоодын нийт бүтээгдэхүүний 3,6 хувийг эзэлж байна. Хог хаягдал дахин боловсруулах чиглэлээр 17 үйлдвэр идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа ба нийт 200,000 тонн хог хаягдал буюу нийт хаягдлын 27 хувийг дахин боловсруулалтад оруулж зорилтот түвшинд хүрсэн. БХБЯ: 1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2018 онд УБ хотын БЗД-ийн нутаг дэвсгэрт байрлах Цагаан даваанд хог ангилах, боловсруулах үйлдвэрийн барилгыг барьж байна. 2021 оны байдлаар гадна цахилгаан хангамжийн ажил бүрэн дууссан, үйлдвэрийн барилга угсралтын ажил 90 хувьтай байна. Үйлдвэрийн тоног төхөөрөмж угсрагдаагүй шалтгаан нь /Ковид-19/ цар тахлын улмаас хил хаагдсан тул гадаад худалдан авалтууд удааширсан тухайлбал, хог ангилан ялгах туузан дамжуулгын тоног төхөөрөмжүүд нь овор хэмжээ ихтэй, контейнерээр задалж тээвэрлэх боломжгүй томоор нь нэвтрүүлэх шаардлагатай байдаг тул хил дээр хүлээгдэж байна. Ядуурлыг бууруулах Японы сангийн 2.0 сая ам долларын буцалтгүй тусламжаар “Аймгуудын төвийн хатуу хог хаягдлын менежментийн		
--	--	--	--	--	--	--	--

					G9206 төсөл"-ийг Сүхбаатар, Дархан-Уул, Өвөрхангай, Говь-Алтай аймгийн төвд 2020-2022 онд хэрэгжүүлсэн. Төслийн хүрээнд Говь-Алтай, Сүхбаатар, Дархан-Уул, Өвөрхангай аймгийн төвд хог хаягдлын төвлөрсөн байгууламжийг шинээр барьсан, дахивар хүлээн авах, хог хаягдал нягтруулан тээвэрлэх байгууламж, автопүүний ажлыг бүрэн гүйцэтгэж байнгын ашиглалтад оруулсан. ЭМЯ: Орон нутагт 8 аймгийн (Дархан-Уул, Булган, Орхон, Сэлэнгэ, Өмнөговь, Дорноговь, Хэнтий, Увс) эмнэлгийн хог хаягдлын 521.3 м2 талбай бүхий барилгын ажлыг нийтдээ 1.2 тэрбум төгрөгөөр хийж гүйцэтгэн, 2019-2020 онд байнгын ашиглалтад оруулсан бөгөөд энэ жишгээр үлдсэн аймгуудад эмнэлгийн хог хаягдлын менежментийг сайжруулахаар ажиллаж байна.		
Зорилт 5.4.Эдийн засаг, аж үйлдвэржилтийн сэргэлтийн бодлогыг хэрэгжүүлэхдээ байгаль хамгаалах үндэсний уламжлалт ёс заншлыг хадгалж, дэлхийн хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн ногоон хөгжлийн жишиг загварыг тодорхойлно.							
80	5.4.1. Хүрээлэн байгаа орчны аюулгүй байдлыг хангах, хүн амын эрүүл, аюулгүй амьдрах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор байгаль орчны хяналт, шинжилгээ, үнэлгээг боловсронгуй болгон хэрэгжүүлэх	Байгаль орчны хяналт, шинжилгээ, үнэлгээ сайжирсан байна.	-	-	БОАЖЯ: БОАЖ-ын сайдын 2022 оны 08-р сарын 03-ны өдрийн А/281 дүгээр тушаалаар Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, хууль тогтоомжийг боловсронгуй болгох үүрэг бүхий Ажлын хэсгийг Хүний эрхийн Үндэсний комисс, ХЗДХЯ, ЭЗХЯ, БХБЯ, ХНХЯ, ЭХЯ, ЗТХЯ, УУХҮЯ, ХХААХҮЯ, ЭМЯ, МХЕГ, НЗДТГ-ын төлөөллийн бүрэлдэхүүнтэй Ажлын хэсгийг байгуулан ажиллаж байна. Ажлын хэсэг Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу холбогдох судалгааны ажлыг Зөвлөх багаар гүйцэтгүүлж, судалгааны үр дүнд тулгуурлан БОНБУ-ний тухай хуульд шинэчилсэн найруулга хийх үзэл баримтлалын төсөл, хуулийн төслийг боловсруулсан. БОНБУ-ний тухай хуулийн шинэчилсэн найруулга хийж байгаатай холбогдуулан ЭЗХЯ, УУХҮЯ, ХНХЯ, ЭХЯ, ЗТХЯ зэрэгтэй албан ажлын уулзалт хийхээр төлөвлөөд байна. Яамны удирдлагаас өгсөн чиглэлийн дагуу БОАЖ-ын сайдын 2022 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн А/535 дугаар тушаалаар Ажлын хэсгийг шинэчлэн байгуулсан. Засгийн газрын 2013 оны 374 дүгээр тогтоолоор батлагдсан "Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журам"-д нэмэлт, өөрчлөлт оруулах Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулж, Засгийн газрын гишүүд, Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийх эрх бүхий мэргэжлийн байгууллагууд, аймаг, нийслэлийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Нийслэлийн Засаг даргаас нийт 332 санал /давхардсан тоогоор/ ирүүлснийг журамд тусган эцэслэн боловсруулав. Журмын төслийг БОАЖС-ын зөвлөлийн 2022 оны 11 дүгээр сарын ээлжит хурлаар хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг хангаад байна. Засгийн газрын бүтэц өөрчлөгдсөнтэй холбоотойгоор журмын төсөлд дахин санал авахаар Засгийн газрын гишүүдэд 2022 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 01/6707, 6708, 6709 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.	БОАЖЯ	50.0
81	5.4.2. Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, цөлжилт, газрын доройтлыг бууруулах үндэсний зорилтыг хэрэгжүүлэх	Цөлжилтийн нэн хүчтэй, хүчтэй зэрэглэлд өртсөн газар нутгийн хэмжээг нэмэгдүүлэхгүй тогтоон барьсан байна.	-	-	Цөлжилтөд нэн хүчтэй, дунд зэрэг өртсөн Дундговь, Дорноговь, Өвөрхангай, Баянхонгор аймагт цөлжилт, газрын доройтлыг бууруулах, элсний нүүлтийг сааруулах зорилгоор Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2022 оны А/233 дугаар тушаалаар нийт 32 га талбайд хамгаалалтын ойн зурвас байгуулахад зориулан 370.1 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэсэн. Дундговь 8 га , Дорноговь 6 га, Өвөрхангай 8 га, Баянхонгор 5 га талбайд цөлжилтийг сааруулах, хамгааллын арга хэмжээ авах ажлын хүрээнд нийт 27 га талбайд хамгаалалтын зурвас, Байгаль орчин. аялал жуулчлалын сайдын А/166 дугаар тушаалаар Дорноговь аймаг Мандах сум 9 га, Дорноговь аймаг Хатанбулаг сум 8 га,	БОАЖЯ	50.0

					Завхан аймаг 50 га, Сүхбаатар аймаг 20 га нийт 87 га талбайд ойжуулалт, нөхөн сэргээлтийн ажлыг ТБОНӨХБАҮХАТХ-ийн дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулж, ажлыг хүлээн авч санхүүжилтийг олгосон. Төслийн хүрээнд БНСУ-ын "Ногоон Ази" Монгол орны цөлжилттэй тэмцэх, шар шороон шуурга, нарийн ширхэгт тоосонцрыг бууруулах 2022-2027 онд хэрэгжих төслийн хүрээнд Төв аймгийн Баянхангай суманд "Хамтын төгөл" ойжуулалтын 100 га талбайд ойжуулалт, нөхөн сэргээх төслийн хүрээнд худаг, хашааны усалгааны төхөөрөмж, хүлэмж, ил талбайн мод үржүүлэг, зоорь зэрэг ажлыг гүйцэтгэсэн. БНСУ-ын "Ногоон хэрэм" төслийн хүрээнд Өвөрхангай аймаг Арвайхээр хотод "Цөлжилтийг бууруулах, шар шороон шуурга, элсний нүүдлээс байгаль орчныг хамгаалах" зорилгоор 15 га газарт агро ойг байгуулахаар ажиллаж байна. Нийт 229 га талбайд цөлжилтийг сааруулах хамгаалалтын арга хэмжээ авсан. Газарзүй, геоэкологийн хүрээлэнтэй хамтран "Хөдөлгөөнт махан элсний нүүлтийг сааруулах, байгальд ээлтэй механик хаалт хийх аргачлал", "Цөлжилт газрын доройтлыг бууруулах хамгаалалтын зурвас байгуулах арга технологи аргачлал"-ыг боловсруулан Шинжлэх ухаан технологийн зөвлөлөөр 2022 оны 11 дүгээр сарын 10-нд орж зөвлөмж гарсан. Дэлхийн ган, цөлжилтийн өдрийг 2022 оны 6 дугаар сарын 16-17-ны өдрүүдэд ШУА-ын Газарзүй, Геоэкологийн хүрээлэнтэй хамтран салбарын төлөөллүүдийн дунд уулзалт хэлэлцүүлэг, Монголын цөлжилтийн судалгааны анхны эрдэмтэн П.Цолмонгийн мэндэлсний 70 жилийн ойг тохиолдуулан "Гандуу нутгийн газарзүй: Ган, газрын доройтол, цөлжилт" сэдэвт залуу эрдэмтдийн өгүүллэгийн уралдаан ба эрдэм шинжилгээний хурал, 21 аймгийн хүүхэд залуучуудын фото зургийн уралдаан, Сүхбаатарын талбай дээр "Цөлжилт ба ой" арга хэмжээг тус тус зохион байгуулсан. БНХАУ-ын Ойн бэлчээрийн газартай хамтран 2022 оны 11 дүгээр сарын 21-25-ны өдрүүдэд "Цөлжилт, шар шороон шуургатай тэмцэх арга технологи" сэдэвт сургалтыг 21 аймаг, их дээд сургууль, аж ахуй нэгж байгууллага нийт 100 гаруй хүмүүст сургалтыг цахимаар зохион байгуулсан.		
82	5.4.3 Байгаль орчинд ээлтэй, хүлэмжийн хий бага ялгаруулдаг, эрчим хүч, цэвэр усны хэмнэлттэй ногоон төсөл хэрэгжүүлэх, бараа бүтээгдэхүүн худалдан авахад хөнгөлөлттэй зээл, урамшуулал олгох	Парисын хэлэлцээр, Тогтвортой хөгжлийн зорилгууд зэрэг олон улсын шаардлагад нийцсэн барилга байгууламж, үйлдвэр, технологи бий болж, байгаль орчинд эерэг нөлөөлөл бий болсон байна.	-	-	БОАЖЯ: 1. Ногоон зээлийн хүүгийн хөнгөлөлтийг санхүүжүүлэх ажлын хүрээнд бүтээгдэхүүн хөгжүүлэлтийг хийж, 2021 оныхтой харьцуулахад ногоон зээлд хамрагдах бүтээгдэхүүний тоог 9-өөр нэмэгдүүлж нийт 34 бүтээгдэхүүн болгосон. Бүтээгдэхүүн бүрд шалгуур үзүүлэлтийг шинэчлэн боловсруулж, Төрийн банк, Хаан банк, Хас банктай 2022 оны 4 дүгээр сард гэрээг шинэчлэн байгуулсан. Орчны бохирдлыг бууруулах, ногоон төсөл хөтөлбөрийг дэмжих, "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг эрчимжүүлэх зорилгоор "Ногоон зээлийн бүтээгдэхүүн бий болгоход дэмжлэг үзүүлж, зээлийн хүүгийн зардлыг хөнгөлөх татаас олгох" арга хэмжээг хэрэгжүүлж, одоогийн байдлаар иргэн, аж ахуйн нэгжид жилийн 3-8 хувийн хүүтэйгээр санал болгож байна. Ногоон зээлийг дэмжих чиглэлээр 2022 онд 1.7 тэрбум төгрөгийн зээлийн хүүгийн зардлыг хөнгөлөх татаасын эх үүсвэрийг төсөвлөсөн. Зээл олголтыг Сангийн яамнаас холбогдох санхүүжилт шийдэгдсэн даруйд буюу 2022 оны 06 дугаар сарын 02-ны өдрөөс олгож эхэлсэн бөгөөд 2022 оны 08 дугаар сарын 29-ний байдлаар нийт 5 байгууллагад 158.2 сая төгрөг, 151 иргэнд 382.3 сая төгрөгийн зээлийн хүүгийн санхүүжилт олгосон байна. 2. Тогтвортой санхүүжилтийг дэмжих, ногоон бүтээгдэхүүн хөгжүүлэх	БОАЖЯ, БХБЯ	70.0

					чиглэлээр судалгаа хийх “Бэлэн байдлын дэмжлэг” хүссэн саналыг Монголын тогтвортой санхүүгийн холбоотой хамтран боловсруулж, НҮБ-ын Уур амьсгалын ногоон сан (УАНС)-ийн Удирдах хорооны хуралдаанаар 2021 оны 10 дугаар сарын 29-ний өдөр батлуулсан. “Бэлэн байдлын дэмжлэг”-ийн Санхүүжилтийн гэрээ 2022 оны 05 дугаар сарын 18-ны өдөр зурсан. 2022 онд багтаан судалгаа хийх салбарыг сонгож, ногоон санхүүгийн бүтээгдэхүүн хөгжүүлэлтийг гүйцэтгэх бэлтгэл хангагдсан. БХБЯ: “Барилгын дулаан хамгаалалт” /БНБД 25-01-20/ барилгын норм, дүрмийг Барилга, хот байгуулалтын сайдын 2020 оны 146 дугаар тушаалаар батлуулсан. “Барилгын эрчим хүчний гэрчилгээ олгох журам”-ыг Барилга, хот байгуулалтын сайд болон Эрчим хүчний сайдын хамтарсан 2021 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн А/257, А/252 дугаар тушаалаар баталсан. Монгол улсын нутаг дэвсгэрт шинээр барих, өргөтгөх, шинэчлэх, сэргээн засварлах, ашиглагдаж буй барилга байгууламжийн эрчим хүчний хэрэглээг тооцож, үр ашгийн үзүүлэлтээр нь ангилж, гэрчилгээ олгох нөхцөл бүрдсэн. Амины орон сууц барих иргэдэд ипотекийн 6 хувийн хүүтэй зээлийг олгож байна. Цаашид барилгын салбар өсөн тэлэх хирээр эрчим хүчний хэрэглээ нэмэгдэж, эрчим хүчний үйлдвэрлэл, дамжуулалтад ихээхэн нөлөөлж, хүлэмжийн хийн ялгарал нэмэгдэх тул эрчим хүчний хэмнэлттэй барилга барьсан, материал үйлдвэрлэсэн, импортолсон болон эрчим хүчний үр ашгийг дээшлүүлж хэмнэлт гаргасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад дэмжлэг үзүүлэх, урамшуулал олгох боломжийн талаар судалгаа хийх ажлыг БХБЯ-ны 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж байна. Энэ ажлын хүрээнд хэд хэдэн байгууллага, төсөлтэй хамтран ажиллаж байна. 2022 онд судалгаанд нэмэгдсэн мэдээлэл: • НОСК, Германы хамтын ажиллагааны нийгэмлэг, “Хабрид хауз” компани хамтран Чингэлтэй дүүргийн Дэнжийн мянга орчимд эрчим хүчний хэмнэлттэй, ногоон орон сууцны төслийн хүрээнд гурван айлын 2,100 ам метр орчим газрыг чөлөөлж, долоон айлын жишиг хотхоныг 2022 оны 04 дүгээр сарын 27-ны өдөр ашиглалтад оруулсан. • “Голден бизнес групп”-ийн CLT технологиор үйлдвэрлэсэн модон хавтангуудыг ашиглах технологи; • Кинг спан Монголиа ХХК-ийн импортолж байгаа технологи; • Өмнөговь аймгийн Цогтцэций суманд эрчим хүчний хэмнэлттэй 10 айлын амины орон сууцны төслийн урьдчилсан тооцоолол, зураг төслийг боловсруулж, төслийн санхүүжилтийг сумын төсвийн хөрөнгөөр шийдвэрлэх ажлууд хийгдсэн. • Өмнөговь аймгийн Даланзадгад суманд хэрэгжих эрчим хүчний хэмнэлттэй 90 айлын амины орон сууцны хотхоны эхний ээлжийн 10 айлын орон сууцыг хувийн хэвшлийн байгууллагатай хамтран хэрэгжүүлэх ажлын бэлтгэл хангагдсан.		
83	5.4.4. Ногоон хөгжлийг дэмжих санхүүжилтийн тогтолцоо, зээл, урамшууллын оновчтой хөшүүргийг нэвтрүүлж, цэвэр технологийг нутагшуулах	Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын ногоон төсөл, ногоон зээлийн үр өгөөжийг нэмэгдүүлсэн байна.	-	-	1. 2022 оны 03 дугаар сард Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар зохион байгуулагдсан “Ногоон санхүүжилт-Бүс нутгийн чуулган”-аар байгаль хамгаалах итгэлцлийн сан байгуулах асуудлыг хэлэлцүүлсэн. Монгол Улсад БХИС байгуулах чиглэлээр хамтран ажиллах харилцан ойлголцлын санамж бичигт 2022 оны 05 дугаар сарын 19-нд гарын үсэг зурсан. Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2022 оны А/193 тоот тушаалаар Сангийн яам, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, холбогдох олон улсын байгууллагын	БОАЖЯ	70.0

					төлөөллийг оролцуулан БХИС байгуулах ажлын хэсэг байгуулсан. 2. Байгаль орчин, аялал жуулчлалын салбарт хэрэгжүүлж байгаа "Монголын унаган байгалийн хүлцэл, тогтворжилтыг хангах нь" төслийн хүрээнд байгаль орчны бичил зээл, "Биологийн олон янз байдал ба уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох нь" төслийн хүрээнд орчны бүсийн эргэлтийн сангийн зээл олгох ажлын бодлогын удирдамжаар ханган ажиллаж, 2022 оны байдлаар нийт 500 орчим иргэн, аж ахуйн нэгж хөнгөлөлттэй зээлд хамрагдсан.		
ЗУРГАА.ТӨРИЙН БҮТЭЭМЖИЙН СЭРГЭЛТ							
Зорилт 6.1.Төрөөс үзүүлэх үйлчилгээг цахимжуулж, төрийн хүнд суртлыг бууруулна.							
84	6.1.1. “Цахим үндэстэн” болох арга хэмжээг эрчимжүүлж, нийтийн мэдээллийн дэд бүтцийг боловсронгуй болгож, цаасан суурьтай үйл ажиллагааг багасган цахим харилцаанд шилжиж, нийтийн мэдээллийн системээс олж авах, солилцох боломжтой мэдээллийг иргэн, хуулийн этгээдээс шаардахгүй байх нөхцөлийг хангаж, цахимаар үзүүлэх төрийн үйлчилгээний хүртээмж, тоог нэмэгдүүлж, иргэнийг цахим гарын үсгээр хангах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэх	2020 оны 10 дугаар сарын 01-ний өдөр нээлтээ хийсэн төрийн үйлчилгээний нэгдсэн систем болох "E-Mongolia"-д нэвтрүүлсэн төрийн 57 байгууллагын 563 үйлчилгээг 1000-д хүргэн нэмэгдүүлж, цахим гэрээ хэлцлийг байгуулах нөхцөл бүрдэж, иргэд цаг хугацаа, орон зайнаас үл хамаарч төрийн үйлчилгээг шуурхай авах нөхцөл бүрдсэн байна.	-	-	ХЗДХЯ: Монгол Улсын Их хурлаас 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдөр Цахим гарын үсгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг эцэслэн баталж, энэ оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр хуульчилсан. Энэ ажлын хүрээнд тоон гарын үсгийг олгох дэд бүтцийг бий болгох, дипломат төлөөлөгчийн газруудыг улсын бүртгэлийн нэгдсэн сүлжээнд холбох, иргэдэд тоон гарын үсэг олгох журмын төслийн талаар зэрэг асуудлаар Улсын бүртгэлийн ерөнхий газар, Үндэсний дата төв УТҮГ, Тагнуулын ерөнхий газартай хамтарсан ажлын хэсгийн уулзалтыг зохион байгуулж технологийн шийдлийг боловсруулсан. Түүнчлэн техник технологи болон төсвийн холбогдох судалгааг хийж, 2022 оны Монгол Улсын нэгдсэн төсөвт тусгасан. УБЕГ-тай хамтран Цахим гарын үсгийг иргэдэд олгох журмын төслийг боловсруулж батлуулсан бөгөөд 2022 оны 11 дүгээр сарын 21-ны өдрийн байдлаар нийт 452,893 иргэнд иргэний үнэмлэх болон зөөврийн төхөөрөмжид тоон гарын үсэг олгоод байна. Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны гэрээг цахимаар бүртгэх болон банк, нотариат, Улсын бүртгэлийн ерөнхий газар хоорондоо мэдээлэл солилцох, тоон гарын үсгээр баталгаажсан цахим баримтыг хэрхэн дамжуулах, банк хөрөнгө барьцаалан зээл олгоход тоон гарын үсэг ашиглан цахимаар шийдвэрлэж болох талаар технологийн шийдэл, мөн нотариатын зуучийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх ажлын технологийн шийдлийг танилцуулж, хэрэгжүүлэх талаар хэлэлцэж, дээрх үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэхэд тулгарч болох хүндрэлүүд, мөн хууль, эрх зүйн баримт бичгүүдийг шинэчлэх талаар санал солилцов. ХНХЯ: Төрийн үйлчилгээг цахимжуулан иргэдэд түргэн шуурхай хүргэх зорилтын хүрээнд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, харьяа байгууллагууд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэн ажиллалаа. Үүнд: 1.Нийгмийн даатгалын үйлчилгээг үе шаттай цахимжуулж байна. Нийгмийн даатгалын 34 үйлчилгээнээс 24 үйлчилгээ бүрэн цахим болж, E-mongolia системд 12 үйлчилгээг холболоо. Мөн E-Mongolia системээс тэтгэвэр тогтоолтын хуудсыг англи хэлээр авах боломжийг бүрдүүлэв. Цахимжуулсан үйлчилгээний үр дүнд 1 жилд 11.2 тэрбум төгрөг иргэд хэмнэжээ. Үүнд: •Нийгмийн даатгалын дэвтэр бүрэн цахим хэлбэрт шилжлээ. Ингэснээр нийгмийн даатгалын үйлчилгээг цаг хугацаа, орон зайнаас үл хамааран чирэгдэлгүй авах, даатгуулагч ажил олгогчийнхоо нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийг хянах, шимтгэлийн өр үүсгэж байгаа эсэхийг тогтмол хянах, дэвтэрт сар бүр бичилт хийж, нийгмийн даатгалын байцаагчаар баталгаажуулалт хийлгэх шаардлагагүй болсон. •Цахим тэтгэврийн дэвтэр - 2021 оноос эхлэн тэтгэврийн цаасан	ХЗДХЯ, ЦХХХЯ, ЭМЯ, ХНХЯ	100.0

				дэвтэр олгохгүй, үүний оронд тэтгэвэр тогтоолтын хуудсыг цахимаар эсвэл цаасаар авах боломжтой болсон. Энэхүү тогтоолтын хуудаст тухайн хүний тэтгэврийг хэрхэн бодсон тухай мэдээлэл дэлгэрэнгүй байх тул тогтоогдсон тэтгэврээ шалгах, хянах боломж тэтгэвэр авагчид бүрдлээ. •Цахим эмнэлгийн хуудас -2022 оны 01 дүгээр сараас эмнэлгийн хуудсыг цахимаар олгох ажлыг үе шаттай хэрэгжүүлээ. •Цахим тэтгэмж - 2021 оны 12 дугаар сараас эхлэн нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмж авах хүсэлтийг цахимаар хүлээн авч, шийдвэрлэж эхэлсэн. •Цахим лавлагаа •Цахим гэрээ - Нийгмийн даатгал аппликейшныг зах зээлд нэвтрүүлж, сайн дурын даатгуулагчийн гэрээг цахимаар байгуулах, сунгах, нийгмийн даатгалын шимтгэлийг цахимаар төлөх, хянах боломжийг бүрдүүлэв. Нийгмийн даатгалын цахим үйлчилгээний ач холбогдол: -Нийгмийн даатгалын үйлчилгээг ил тод, түргэн шуурхай хүргэх; -Хүнд суртал, чирэгдэл багасаж, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх боломж бүрдэх. -Нийгмийн даатгалын ажилтны ачаалал тодорхой хэмжээгээр буурч, нийгмийн даатгалын хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, таниулах ажилд цаг зарцуулах боломж нэмэгдсэн. Үлдсэн үйлчилгээг 2024 он хүртэл үе шаттайгаар цахимжуулах ажлыг зохион байгуулна. 2.Нийгмийн халамжийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх ажлын хүрээнд ХНХЯ-наас төрд байгаа иргэний мэдээллийг тухайн иргэнээс шаардахгүйгээр төрөөс үзүүлж буй халамжийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, тусламжийг чирэгдэлгүй, шуурхай хүргэх зорилгоор “Нийгмийн халамжийн нэгдсэн систем”-ийг хөгжүүлж, 2020 онд анх нэвтрүүлсэн. 2020 онд “Насны хишиг”, “Жирэмсэн эхийн тэтгэмж”, “0-3 хүртэлх насны хүүхэд асарсны тэтгэмж”, “Ихэр хүүхдийн тэтгэмж”, “Өрх толгойлсон эх, эцгийн тэтгэмж”, “Эхийн алдар” одонгийн мөнгөн тусламж гэсэн 6 үйлчилгээг, 2021 онд халамжийн тэтгэвэр, асаргааны тэтгэмж, амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж зэрэг 20 төрлийн тэтгэвэр, тэтгэмжийн үйлчилгээг нэмж нэвтрүүлэн олголтыг хийж байна. Нийгмийн халамжийн сангаас ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлэх бүх төрлийн дэмжлэг, хөнгөлөлтийн мэдээллийг ehalamj.mn систем рүү шилжүүлэхэд ХХҮЕГ, Гааль татвар, санхүү, мэдээллийн технологийн төвтэй хамтран ажиллав. 2022 оны 5 дугаар сараас ахмадын 6 үйлчилгээг, 6 дугаар сараас эхлэн хөгжлийн бэрхшээлтэй иргэний 10 үйлчилгээний олголтыг иргэд, үйлчилгээ үзүүлж байгаа аж ахуйн нэгж, байгууллага руу Төрийн сангаар дамжуулан хийж байна. 2022 онд 36 төрлийн үйлчилгээг цахимжуулсан бөгөөд одоогийн байдлаар халамжийн 72 нэр төрлийн үйлчилгээнээс 64 үйлчилгээг цахимжуулсан ба харьяалах яамдад шилжсэн 2 төрлийн үйлчилгээ, холбогдох журам гараагүйн улмаас хэрэгжихгүй байгаа 2 төрлийн үйлчилгээ, цахимжих боломжгүй 3, тусгай программаар үзүүлж байгаа 1 төрлийн үйлчилгээ тус тус байна. 2022 оны эхний 10 дугаар сарын байдлаар нийгмийн халамжийн үйлчилгээнд давхардсан тоогоор 1,2 сая иргэн хамрагдаж, 433.6 тэрбум төгрөг зарцуулсан /хүүхдийн мөнгөн хуримтлалыг	
--	--	--	--	---	--

				тооцохгүйгээр/ байна. Нийт хамрагдсан иргэний 89.8 хувь нь нийгмийн халамжийн үйлчилгээг цахимаар авч байна. Мөн 21 аймаг 330 сум, 9 дүүргийн 171 хороонд хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээг цахим эрхийн бичиг (банкны карт)-ээр үзүүлж байна. “Нийгмийн халамжийн нэгдсэн систем” нэвтэрснээр иргэн нийгмийн халамжид хамрагдах хүсэлтээ төрийн байгууллагад очилгүйгээр нийгмийн халамжийн цахим хуудас болох ehalamj.mn, төрийн үйлчилгээний цахим машин "ТҮЦ машин", ebarimt аппликейшныг ашиглан гаргах, олон байгууллагаар явж цаасаар бүрдүүлдэг баримт бичгийн тоо багасах, өргөдөл, хүсэлтийнхээ шийдвэрлэлтийн явцад хяналт тавих, өөрийн нэр дээрх арилжааны банкин дахь харилцах дансаараа дамжуулан халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн мөнгөө авах зэрэг иргэнд ээлтэй олон давуу талууд бий болов. Иргэдэд хүрэх төрийн халамжийн үйлчилгээ цахимжснаар иргэд илүү хурдан шуурхай байдлаар үйлчилгээг авах боломж бүрдсэн. Түүнчлэн нийгмийн халамжийн ажилтан, албан хаагчид цахим системээр дамжуулан иргэдийн хүсэлтийг хүлээн авдаг болсноор иргэний цаасан материалыг бүрдүүлэх, архивлах зэрэгт зарцуулдаг хугацаа багасаж, халамж шаардлагатай иргэнд зөвлөгөө мэдээлэл өгөх, гэрээр нь очиж нөхцөл байдлын үнэлгээ хийх зэрэг нийгмийн ажлын үйлчилгээнд илүү хугацаа зарцуулах боломж бүрдлээ. 3. Дэлхийн банкны санхүүжилтээр Монгол Улсын хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн системийг шинэчлэн хөгжүүлэх, e-job платформын нэвтрүүлэх зорилгоор аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсийн мэргэжилтэн, удирдах ажилтан, төрийн болон төрийн бус байгууллагын төлөөллүүдийг оролцуулж, саналыг авч тусган бизнес шинжилгээний өнөөгийн 85 зураглал, ирээдүйн 72 зураглалыг гаргаж, мэдээллийн нэгдсэн сан болон сүлжээний хөгжүүлэлтийг хийж байна. 2022 онд хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн системийг шинэчлэн хөгжүүлэх, e-job платформын нэвтрүүлэх ажлын хэсэг 1 удаа, системийн дизайны хөгжүүлэлтэд санал өгөх, хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний процессын зураглалыг шинэчлэхэд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх, дэд ажлын хэсэг 2 удаа, шаардлагатай бусад уулзалт хэлэлцүүлгийг тухай бүр зохион байгуулсан. Төслийн хүрээнд Монгол Улсын төрийн хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний мэдээллийн системийг шинэчлэн боловсруулж, системийг хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ хариуцсан мэргэжилтнүүдээс ашиглахаас гадна хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээний бүртгэл, тайлангийн модуль, ажил хайгч иргэн болон ажил олгогч байгууллагууд, хөдөлмөрийн хувийн биржүүдэд зориулсан хөдөлмөр зуучлалын онлайн портал сайтыг шинэчлэн хөгжүүлэх юм. “E-job” платформын нээлтийн үйл ажиллагааг 2022 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр зохион байгуулсан. “Ejob” платформын давуу тал: -Ажил олгогчид Тохирох ажил хайгчдыг, Ажил хайгчид Тохирох ажлын байруудыг Job matching алгоритмын тусламжтай системээс санал болголт хийх боломжтой. -Ажил зуучлал, Төсөл хөтөлбөрүүдийн нэгдсэн тайлан мэдээг боловсруулах боломжтой. -Төрийн байгууллагуудын сервисүүдтэй холбогдсон. (ХУР, ДАН, НДЕГ) -Дэд системүүд хоорондоо мэдээлэл солилцох боломжтой бөгөөд	
--	--	--	--	---	--

					ингэснээр мэдээллийн давхардал үүсэхгүйгээр адилхан байдаг бүртгэлийг нэг газраа бүртгэж, бусад ашиглагдах хэсэгт мэдээллийг дуудаж, холбогдох боломжтой. -Ачаалал тэнцвэржүүлж ажиллах шийдлүүдийг дэд бүтцийн түвшинд болон application server, database server түвшинд хийж өгснөөр, мөн Тайлангийн хэсэг дээр data warehouse-ийн зохион байгуулалтыг хийж өгснөөр системийн ачаалал даах болон хурдтай ажиллах боломжийг хангасан. -Хэрэглэгч өөрийн анкет /CV/-ыг илгээх -Байршлаас үл хамааран ажлын байртай болох зэрэг болно. 4. Нийгмийн ажлын үйлчилгээг цахимжуулах зорилгоор: etuslamj.mn, NAMS программыг шинээр нэвтрүүлж, хөгжүүлэлт хийгдэж байна. Тухайлбал, -Нийгмийн ажил, үйлчилгээний мэдээллийн сан: Хамтарсан багаас гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдод түргэн шуурхай хүрч үйлчлэх, нийгмийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх, баримтжуулах, нийгмийн ажилтны өдөр тутмын үйл ажиллагааг хөнгөвчлөх, бүртгэл, мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх зорилготой. Хамтарсан баг гэр бүлийн болон хүүхдийн эсрэг хүчирхийллийн хохирогчийн мэдээлэл хүлээн авах, бүртгэх, нөхцөл байдлын үнэлгээ хийх, үйлчилгээ үзүүлэх, дүгнэлт гаргах үйл ажиллагааг цахимжуулж, нэгдсэн мэдээллийн санг бүрдүүлэн системийн хэрэглэгчид тайлан мэдээллийг цаг алдалгүй харж, бодлого төлөвлөлт, төсөвлөлт хийх боломжийг бүрдүүлж өгснөөр онцлогтой юм. -Хүүхэд, гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдод мэдээлэл өгөх, урьдчилан сэргийлэх, хамгааллын үйлчилгээний мэдээллийн сан буюу etuslamj: Гэр бүлийн хүчирхийллийн хохирогч хүүхэд, эмэгтэйчүүдтэй холбоотой тохиолдол бүрийг бүртгэх, хохирогчид үзүүлэх нийгмийн үйлчилгээний явцыг тодорхойлох, тухайн үеийн бодит мэдээллийг албажуулах, үйлчилгээний бүртгэл, мэдээллийг бүрэн цахимжуулах, төрийн үйлчилгээний ил тод байдал, мэдээллийн цогц урсгал, үйлчилгээний хяналт, хариуцлагыг бий болгох, бусад төрийн үйлчилгээний мэдээллийн сантай холбож, нэгдсэн мэдээллийн урсгал бүрдүүлэх, анхан шатны бүх үйлчилгээг нийгмийн ажлын мэргэжлийн удирдлага, арга зүйгээр хангах, хяналт, хариуцлагын удирдлагын тогтолцоог сайжруулах ач холбогдолтой. Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас ABLE программын шинэчлэлийг эхлүүлсэн. Хүүхдийн тусламжийн 108 утасны программын шинэчлэлийн хүрээнд утас, мессеж, чатаар хүүхдээс дуудлага, мэдээлэл хүлээн авах боломжтой болж, өргөжсөн. Уг программын бүртгэлийн ангиллыг Монгол Улсын хууль, тогтоомж, олон улсын дуудлагын ангилал, төрөлтэй нийцүүлэн сайжруулсан. ЭМЯ: E-Mongolia-г ашиглан эмнэлгийн цаг захиалах боломжийг бүрдүүлж Эрүүл мэндийн яамны харьяа төрөлжсөн мэргэшлийн төвүүд болон нийслэлийн 9 дүүргийн эмнэлгийн цагийг цахимаар захиалж байна. Мөн төрийн үйлчилгээний E-Mongolia цахим системийг ашиглан шинжилгээний хариу, эмнэлгийн магадалгаа, цусны бүлгийн мэдээлэл, эрүүл мэндийн даатгалын төлөлт шалгах, эмнэлгийн цаг захиалах, цаг цуцлах, вакцины гэрчилгээ авах, олон улсын аялалын гэрчилгээ авах, эрт илрүүлэх үзлэг, оношилгооны	
--	--	--	--	--	---	--

				асуумж бөглөх, дүгнэлт авах зэрэг нийт 12 үйл ажиллагааг төрийн байгууллагууд хооронд мэдээлэл солилцон нэг системээр үзүүлж байна. Тус үйлчилгээ нэвтэрснээр давхардсан тоогоор 3,759,340 удаагийн эрүүл мэндийн үйлчилгээг иргэд цахимаар аваад байна. /100 хувь/ ЦХХХЯ: 1. Танилт, нэвтрэлтийн ДАН системд гар утасны дугаараар нэвтрэх үед баталгаажуулах кодыг иргэн өөрөө 130092 тусгай дугаарт илгээж өөрийгөө баталгаажуулан үйлчилгээ авах нөхцөлөөр бүрэн хангагдаж, үйлчилгээг хэвийн горимоор ажиллуулж байна. 2.Төрийн үйл ажиллагааг цахим хэлбэрээр явуулах, төрийн үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгож, нээлттэй, ил тод, шуурхай байлгах зорилгоор төр, иргэнийг холбосон мэдээлэл дамжуулах цахим суваг болох “ҮНДЭСНИЙ ЦАХИМ ШУУДАН”-ийн систем /www.mail.e-mongolia.mn/-ийг нэвтрүүлж иргэдэд шаардлагатай мэдээлэл, мэдэгдлийг хүргүүлэх, өргөдөл, гомдлыг хүлээн авч, хариу хүргүүлэх боломжтой болсон. Энэхүү системд Монгол Улсын 16 ба түүнээс дээш насны иргэдэд иргэний улсын бүртгэлийн дугаараар 777,541 цахим шуудангийн хаягийг үүсгээд байна. Мөн “Үндэсний цахим шуудан”-ийн системийг хэрэглээнд нэвтрүүлж, мэдээлэл хариуцагч иргэний мэдээллийг гуравдагч этгээдэд дамжуулсан тухай 1,211,172 мэдэгдлийг хүргүүлээд байна. 3. Төрийн үйлчилгээний нэгдсэн И-Монгол системд нийслэлийн цэцэрлэгийн насны хүүхдүүдийг хамруулах хүсэлт, төрийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн нэгдүгээр ангид элсэн орох хүсэлт, өөрөө хариуцан төлсөн НДШ-ийн 50 хувийг буцаан олгох шийдвэрийн дагуу иргэд дансны мэдээлэл бүртгүүлэх үйлчилгээ зэрэг Нийслэлийн 782 үйлчилгээ, орон нутгийн 1285 үйлчилгээг тус тус нэвтрүүлээд байна. 4. Тус яамнаас Сонгуулийн ерөнхий хороо, Хил хамгаалах ерөнхий газар, Улсын бүртгэлийн ерөнхий газар болон Хөдөлмөр халамж үйлчилгээний газар болон бусад төрийн байгууллагын нийт 1230 гаруй албан хаагчид, аймаг нийслэлийн 4618 иргэнийг хамруулан "Цахим засаглалын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх" сургалтыг зохион байгуулсан. 5. Төрийн мэдээлэл солилцооны Хур системээр нийт 1,156,908,549 үйлчилгээ дуудагдсанаас 974,788,359 үйлчилгээг амжилттай дамжуулаад байна. 6.Засгийн газрын 2022 оны 09 дүгээр сарын 22-ны өдрийн 352 дугаар тогтоолоор "Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам" батлагдсан бөгөөд уг журам нь төрийн байгууллагын үйл ажиллагааны хүрээнд цуглуулсан мэдээллийг нээлттэй, ил тод болгох замаар Монгол Улсын Үндсэн хуульд заасан иргэнийг хайх, хүлээн авахыг баталгаажуулж, хүнд суртал, авлига, ашиг сонирхлын аливаа зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх боломж бүрдэнэ. Мөн Цахим гарын үсгийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалтад заасны дагуу Улсын бүртгэлийн ерөнхий газар, “Монпасс СА” ХХК, “Тридум Э-Секьюрити” ХХК, “Ви Эс Эм” ХХК, “Нью-Компас” ХХК нар гэрчилгээжүүлэх байгууллагын чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байгаа бөгөөд 2022 оны 11 сарын 25-ны өдрийн байдлаар нийт 422,311 мянган иргэн, аж ахуйн нэгжид тоон гарын үсэг олгоод байна. Төрийн үйлчилгээний нэгдсэн системд иргэд гар утасны аппликейшнд суурилсан тоон гарын үсгээр нэвтрэх боломжийг бүрдүүлсэн.		
--	--	--	--	--	--	--

					7. Боловсролын үнэлгээний төвийн Элсэлтийн ерөнхий шалгалтын лавлагаа болон АТҮТ-ийн мэргэшсэн жолоочийн үнэмлэхийн лавлагаа үйлчилгээнүүд нэмэлтээр цахимжуулсан байна. 8. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 35.2.1 дэх заалтад Нийтийн мэдээллийн дэд бүтэц болон төрийн цахим үйл ажиллагааны талаар хүн, хуулийн этгээд нь "Мэдээллийн эзний зөвшөөрлийн үндсэн дээр хязгаарлалттай мэдээллийг ашиглах;" үүрэгтэй гэж заасны дагуу хүн, хуулийн этгээд үндсэн систем ашиглан үйлчилгээ мэдээллийн эзний зөвшөөрөлд үндэслэн хязгаарлалттай мэдээлэлд хандах, төрийн үйлчилгээний нэгдсэн системээс гарах лавлагаа, тодорхойлолтыг файл (pdf) хэлбэрээр авах боломжийг бүрдүүлэн "lavlagaa.e-mongolia.mn" системийг хөгжүүлээд байна. Мөн "Үндсэн систем (ХҮР)-ийг ашиглан үйлчилгээ үзүүлэх гэрээ"-ний 8.2 дахь хэсгийг үндэслэн нэмэлт гэрээний загварт "lavlagaa.e-mongolia.mn" ашиглах талаар тусгасан болно. "lavlagaa.e-mongolia.mn" системийн танилцуулга, гэрээний нэмэлтийн талаарх мэдээллийг 2022 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн 03/2046 дугаар албан бичгээр Монголын банкны холбоо, Монголын банк бус санхүүгийн байгууллагын холбоо, Санхүүгийн зохицуулах хороонд тус тус хүргүүлсэн.		
85	6.1.2. Орон зайн өгөгдөл, мэдээллийг бүрдүүлэгч бусад байгууллагын санг нэгдсэн стандартад шилжүүлэх, геопорталаар дамжуулан төрийн бодлого төлөвлөлт, шийдвэр гаргалтын "Нэг газрын зураг", иргэд, олон нийт, бизнесийн зориулалттай "Нээлттэй газрын зураг" цахим үйлчилгээг улсын хэмжээнд нэвтрүүлэх	Орон зайн өгөгдлийн дэд бүтцэд суурилсан нээлттэй цахим системийг хөгжүүлж, хэрэглээнд нэвтрүүлсэн байна.	-	-	Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтын XII.4.5-д тусгагдсан "Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар дараа онуудад хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв /Улсын хэмжээнд/" төсөл, арга хэмжээний хүрээнд хэрэгжүүлэх зураг төслийн жагсаалтыг Барилга, хот байгуулалтын сайдын 2022 оны "Жагсаалт батлах тухай" 37 дугаар тушаалаар баталсан. Уг тушаалын дагуу "Нэг газрын зураг", иргэд, олон нийт, бизнесийн зориулалттай "Нээлттэй газрын зураг" цахим үйлчилгээг улсын хэмжээнд нэвтрүүлэх ажлын техник, эдийн засгийн үндэслэл /ТЭЗҮ/ боловсруулах ажлын даалгаврыг БХБЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга 2022 оны 03 дугаар сарын 02-ны өдөр баталж, Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн А/39 дүгээр тушаалаар байгуулагдсан үнэлгээний хороо зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг холбогдох хуулийн дагуу зохион байгуулсан. "Геопорталаар дамжуулан төрийн бодлого, төлөвлөлт, шийдвэр гаргалтын "Нэг газрын зураг", иргэд, олон нийт, бизнесийн зориулалттай "Нээлттэй газрын зураг" цахим үйлчилгээг улсын хэмжээнд нэвтрүүлэх ажлын техник, эдийн засгийн үндэслэл" БХБЯ/202202153 дугаартай зөвлөх үйлчилгээний гэрээг "Нэкст Жи Ай Эс" ХХК-тай 2022 оны 06 дугаар сарын 03-ны өдөр байгуулан ажиллаж байна. Уг төсөл, арга хэмжээний дунд шатны тайланг хүлээн авч 2022 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 2022/03 тоот актын дүгнэлтээр баталгаажуулсан.	БХБЯ	90.0
86	6.1.3. Хаягийн нэгдсэн системийг хэрэглээнд нэвтрүүлэх	Улсын хэмжээнд хаягжуулалтын ажлыг нэгдсэн тогтолцоонд шилжүүлж хэрэгжүүлсэн байна.	-	-	1. "Улсын хэмжээнд хаягийн мэдээллийн нэгдсэн системийг байгуулж, хэрэглээнд нэвтрүүлэх" ажлын гүйцэтгэл, үр дүнгийн талаарх мэдээллийг Засгийн газрын хуралдаанд танилцуулахаар Барилга, хот байгуулалтын сайдын 2022 оны 1/725 тоот албан бичгээр тус ажлын танилцуулгыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлж, Засгийн газрын 2022 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн хуралдаанд танилцуулж, 15 дугаар тэмдэглэл гарсан. Энэ тэмдэглэлийн дагуу "Хаягийн мэдээллийн нэгдсэн системийг хэрэглээнд нэвтрүүлэх тухай", Засгийн газрын 2019 оны 325 дугаар тогтоолоор баталсан "Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийг хаягжуулах журамд өөрчлөлт оруулах тухай" Засгийн газрын тогтоолын төслийг тус тус боловсруулж, улмаар Барилга, хот	БХБЯ	70.0

					байгуулалтын сайдын 2022 оны 04 дүгээр сарын 19-ны өдрийн 1/1832 тоот албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлж, Засгийн газрын 2022 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн хуралдаанаар тус тус хэлэлцүүлсэн. “Хаягийн мэдээллийн сангийн нэгдсэн системийг хэрэглээнд нэвтрүүлэх тухай” Засгийн газрын тогтоолын төслийг Засгийн газрын 2022 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн өдрийн 180 дугаар тогтоолоор, “Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийг хаягжуулах журамд өөрчлөлт оруулах тухай” Засгийн газрын тогтоолын төслийг 181 дүгээр тогтоолоор тус тус баталсан. 2. БХБЯ, ЦХХХЯ, ГЗБГЗЗГ, УБЕГ, нийслэлийн ЗДТГ, хувийн хэвшлүүдийн оролцсон хаягийн мэдээллийн сангийн нэгдсэн системийн асуудлаар 2022 оны 10 дугаар сарын 27-ны өдөр уулзалт зохион байгуулж, “Хаягийн мэдээллийн сангийн нэгдсэн системийг хэрэглээнд нэвтрүүлэх тухай” Засгийн газрын 2022 оны 180 дугаар тогтоолыг хэрэгжүүлэхэд тулгамдаж байгаа асуудлыг судлан тодорхойлж, цаашид авах арга хэмжээний санал, дүгнэлтийг боловсруулах, салбар хоорондын уялдааг ханган хамтран ажиллах үүрэг бүхий ажлын хэсгийг Барилга, хот байгуулалтын сайд, Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2022 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн 227/А/76 дугаар хамтарсан тушаалаар байгуулсан. Тус ажлын хэсгийн хурлыг 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр зохион байгуулж, ажлын төлөвлөгөөг гарган ажиллаж байна.		
87	6.1.4. Хиймэл оюун ухаан, блокчейн болон газар зүйн мэдээллийн системд суурилсан 3 болон 4 хэмжээст газар, үл хөдлөх хөрөнгийн бүртгэл, үнэлгээ, татвар, төлбөрийн нэгдсэн системийг олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлэх	Газрын кадастрын мэдээллийн санд бүртгэлтэй 500 мянга гаруй барилгын зурган болон бүртгэлийн мэдээллийг засварлаж, өгөгдлийн санг байгуулан 3 болон 4 хэмжээст газар, үл хөдлөх хөрөнгийн бүртгэл, үнэлгээ, татвар, төлбөрийн нэгдсэн системийг хэрэглээнд нэвтрүүлж, төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудын системтэй холбосон дундын мэдээллийн санг байгуулж, салбар хоорондын уялдааг хангасан байна.	-	-	Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтын XII.4.5-д тусгагдсан “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар дараа онуудад хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв /Улсын хэмжээнд/” төсөл, арга хэмжээний хүрээнд хэрэгжүүлэх зураг төслийн жагсаалтыг Барилга, хот байгуулалтын сайдын 2022 оны “Жагсаалт батлах тухай” 37 дугаар тушаалаар баталсан. “Улсын хэмжээнд 3D, 4D /хэмжээст/ кадастрын мэдээллийн нэгдсэн системийг байгуулах, хэрэглээнд нэвтрүүлэх” ажлын техник, эдийн засгийн үндэслэл” боловсруулах ажлын 2021/91 тоот даалгаврыг Төрийн нарийн бичгийн даргаар батлуулан зөвлөн үйлчилгээний сонгон шалгаруулалтыг хийж, Б.Галмандах ахлагчтай зөвлөх багийг шалгаруулан 2022 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр 2022/96 тоот зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулсан. Уг гэрээт ажлын тайланг ГЗБГЗЗГ-ын даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар 2022 оны 09 дүгээр сарын 16-ны өдөр, ГЗБГЗЗГ-ын дэргэдэх салбарын орон тооны мэргэжлийн зөвлөлийн хурлаар 2022 оны 9 дүгээр сарын 23-ны өдөр тус тус хэлэлцүүлж зөвлөмж гарсан. Мөн зөвлөх багийн боловсруулсан ТЭЗҮ-д хөндлөнгийн шинжээчийн дүгнэлтийг 2022 оны 10 дугаар сарын 13-ны өдөр гаргуулж, эцсийн шатны тайланг хүлээн авч, ГЗБГЗЗГ-аас захиалагчийн хяналтын дүгнэлтийг гаргаад байна. Улсын хэмжээнд 3D, 4D /хэмжээст/ кадастрын мэдээллийн нэгдсэн системийг байгуулах, хэрэглээнд нэвтрүүлэх” ажлын техник, эдийн засгийн үндэслэл”-ийг БХБЯ-ны ШУТТЗХ-аар хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулж байна.	БХБЯ	70.0
88	6.1.5. Улсын хэмжээнд хот, суурины төвийн 1:1000-ны масштабтай байр зүйн зураг, газар доорх шугам сүлжээний зургийг солбицлын ITRF2020 эринд шилжүүлэх ажлыг	ITRF2020 эринд 2,400 цэг В ангийн сүлжээг байгуулж, АА ангийн сүлжээг шилжүүлэн 21 аймаг, 330 сум,	-	-	1. Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн хуралдаанаар "Геодезийн солбицол, өндөр, тусгагдгийн нэгдсэн тогтолцоог шинэчлэн батлах тухай" асуудлыг хэлэлцүүлж, Засгийн газрын 267 дугаар тогтоолоор батлуулсан. 2. Засгийн газрын 2022 оны 267 дугаар тогтоолын 2 дахь заалтын дагуу геодезийн солбицлын ITRF2020 тогтолцоонд шилжсэнтэй	БХБЯ	100.0

	зохион байгуулах	Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт 1:1000-ны масштабтай тоон байр зүйн зургийг шинээр гүйцэтгэсэн байна.			холбогдуулан хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2022 оны 09 дүгээр сарын 09-ний өдөр Барилга, хот байгуулалтын сайдаар батлуулсан. 3. Улсын хэмжээнд хот суурины төвийн 1:1000-ны масштабтай байр зүйн зураг, газар доорх шугам сүлжээний зургийг солбицлын ITRF2020 эринд шилжүүлэх ажлыг 2023 оноос эхлэн орон нутгийн төсвөөр хийх чиглэлийг Нийслэл болон 21 аймгийн Засаг дарга нарт хүргүүлэх ажлыг зохион байгуулсан. Үүнд, тус яамны харьяа Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газраас боловсруулсан нийслэл Улаанбаатар хотын 1:500-ны масштабтай байр зүйн зургийг, 21 аймгийн төвийн 1:1000-ны масштабтай байр зүйн зураг, газар доорх, дээрх инженерийн шугам сүлжээний зургийг орон нутгийн төсвийн хөрөнгөөр солбицлын ITRF2020 эринд хийх ажлын танилцуулга болон хөрөнгө оруулалтын тооцоог Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчид 2022.10.07-ны өдрийн 1/4630, Дархан-Уул, Орхон аймгийн Засаг дарга нарт 2022.08.23-ны өдрийн 1/4036, 1/4037 тоот албан бичгээр, 21 аймгийн /Дархан-Уул, Орхон аймгаас бусад/ Засаг дарга нарт 2022.10.07-ны өдрийн 1/4631 тоот албан бичгээр тус тус хүргүүлсэн.		
89	6.1.6. Цахим үйл ажиллагаатай газрын биржийг газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын эрхлэх асуудлын хүрээнд байгуулан газрын биржийн үйл ажиллагааны тодорхой хувиар газар хөгжүүлэх санг бүрдүүлж, газрыг эдийн засгийн эргэлтэд оруулах	Цахим үйл ажиллагаатай газрын биржийг газрын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын эрхлэх асуудлын хүрээнд байгуулж, газар, үл хөдлөх хөрөнгийн зах зээлийг нэг цэгт төвлөрүүлэх боломж бүхий газрын нэгдсэн системийг хэрэглээнд нэвтрүүлэн улсын хэмжээний газрын санг бүрдүүлж, газар хөгжүүлэлтийн ажлыг зохион байгуулж хийдэг болсон байна.	-	-	1.Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтын XII.4.5-д тусгагдсан “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар дараа онуудад хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв /Улсын хэмжээнд/” төсөл, арга хэмжээний хүрээнд хэрэгжүүлэх зураг төслийн жагсаалтыг Барилга, хот байгуулалтын сайдын 2022 оны “Жагсаалт батлах тухай” 37 дугаар тушаалаар баталсан. Энэхүү тушаалын дагуу Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн А/39 дүгээр тушаалаар байгуулагдсан үнэлгээний хороо “Цахим үйл ажиллагаатай газрын биржийг газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын эрхлэх асуудлын хүрээнд байгуулж, газрын сан бүрдүүлэх, газар хөгжүүлэлт хийх ажлын техник эдийн засгийн үндэслэл” боловсруулах зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчээр “Ланд овнер” ХХК-ийг шалгаруулж, 2022/283 тоот гэрээг байгуулан ажлыг гүйцэтгэж байна. Зөвлөх үйлчилгээний эхлэлийн шатны тайланг 2022 оны 09 дүгээр сарын 15-ны өдөр хүлээн авсан. 2. Газрыг эдийн засгийн эргэлтэд оруулах хүрээнд Газрын биржээр дамжуулан 2022 онд улсын хэмжээнд нийт 3786 удаа цахимаар болон танхимаар газрын дуудлага худалдаа зарлаж 6458 оролцогч орсон. Эдгээр зарлагдсан дуудлага худалдаанаас 998 газар буюу нийт 135 472 648 м2 талбай дуудлагаар худалдагдаж 26,500,966,000 төгрөг төсөвт төвлөрүүлсэн.	БХБЯ	90.0
Зорилт 6.2.Засгийн газрын бүтэц, зохион байгуулалтад цогц шинжилгээ хийж, үнэлэлт, дүгнэлт өгч, оновчтой бүтцийг тогтоон, төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшил, мэргэжлийн холбоодод шилжүүлнэ.							
90	6.2.1. Мэргэжлийн холбоонд эрхээ шилжүүлэн хийлгэх боломжтой төрийн чиг үүргийн талаарх судалгааг салбар бүрээр гаргаж, шилжүүлэх ажлыг үе шаттайгаар эхлүүлэх	Төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшил, мэргэжлийн холбоонд шилжүүлж, төр-хувийн хэвшлийн түншлэлийг өргөжүүлэх, төрийн	-	-	Эрүүл мэндийн тухай хуулийн 22.6 дахь заалтад нэмэлт, өөрчлөлт оруулснаар Мэргэжлийн нийгэмлэг, холбоод, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх нөхцөлийг бүрдүүлэхээр судалгаа гаргаж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт 2022 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн 1а/4559 тоот албан бичгээр хүргүүлсэн.	ТАЗ /ЭМЯ/	30.0

		албыг цомхон, чадварлаг болгох боломжийг нэмэгдүүлсэн байна.					
Зорилт 6.3.Төрийн хяналт, шалгалтын давхардсан тогтолцоог цэгцэлж, төлөвлөгөөт шалгалтыг түр хугацаанд зогсоож, төрийн байгууллагаас шаарддаг тусгай зөвшөөрөл, техникийн нөхцөлийн тоог бууруулна.							
91	6.3.1. Төрийн үйл ажиллагааг ил тод, шуурхай болгох, төрийн хүнд суртлыг арилгах, бизнес эрхлэгчдийг дэмжих тусгай зөвшөөрөл, зөвшөөрлийн тоог 2 дахин цөөрүүлж, цахимаар олгох, сунгах боломжийг бүрдүүлэх	Хуулиар хориглосон, эсхүл зөвшөөрөл шаардахаас бусад төрлийн үйл ажиллагааг хүн, хуулийн этгээд хууль тогтоомжид нийцүүлэн чөлөөтэй эрхлэх боломжтой болсон байна.	-	-	БХБЯ: Газар, хот байгуулалт, барилгын салбарын 11 төрлийн тусгай зөвшөөрөл, мэргэжлийн эрх олгох, сунгах, нөхөн олгох, хүчингүй болгох, хянан шийдвэрлэх, хяналт тавих үйл ажиллагааг 100 хувь цахим хэлбэрт шилжүүлсэн. Газар, хот байгуулалт, барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн цахим системийг хөгжүүлэх хүрээнд 8,942 аж ахуйн нэгж, байгууллага, 44,688 инженер техникийн ажилтны мэдээллийн санг бүрдүүлж, www.mcis.gov.mn , www.opendata.gov.mn цахим хуудсаар дамжуулан тухай бүр шинэчлэлтийг хийж, мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг ханган ажиллаж байна. Мөн дээрх 11 төрлийн тусгай зөвшөөрөл, мэргэжлийн эрхтэй холбоотой хүсэлтийн холбоосыг E-Mongolia платформд холбосон. Барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн лавлагааг төрийн мэдээлэл солилцооны үндсэн системд холбож, төрийн худалдан авах ажиллагааны систем, татварын цахим системүүдтэй мэдээлэл солилцох боломжийг ханган ажиллаж байна. 2022 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн байдлаар www.license.mcis.gov.mn цахим системээр дамжуулан нийт 4,596 хүсэлтийг хүлээн авч, 1,120 ААНБ тусгай зөвшөөрөл олгосон байна. Тусгай зөвшөөрөлтэй холбоотой үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлснээр өмнө 30-45 хоног зарцуулдаг байсан хугацааг 10-15 хоногт багтаан шийдвэрлэдэг болсон ба шат дамжлага, зардал, цаг хугацааг хэмнэхээс гадна авлига, хүнд суртлыг бууруулж байна. Барилга, хот байгуулалтын яамны харьяа Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар нь газрын нэгдмэл сангийн удирдлагын системээр дамжуулан газрын харилцаатай холбоотой иргэнд чиглэсэн 42, аж ахуйн нэгж байгууллагад чиглэсэн 30 үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлээд байгаа бөгөөд үүнээс 45 үйлчилгээг Төрийн үйлчилгээний нэгдсэн систем E-Mongolia-д холбосон. Барилга, байгууламжийн үйл ажиллагаанд 9 чиглэлд зөвлөх үйлчилгээ үзүүлэх иргэн, хуулийн этгээдийн бүртгэлийн системийг хөгжүүлж, хэрэглээнд нэвтрүүлсэн. Түрээслээд өмчлөх болон түрээсийн орон сууцны хүсэлт хүлээн авах, хянан шийдвэрлэх үе шатыг бүрэн цахим хэлбэрт шилжүүлэх зорилгоор "Орон сууцны бүртгэл, мэдээллийн нэгдсэн портал, гар утасны апплейшн"-ыг хөгжүүлж байна.	БХБЯ	100.0
92	6.3.2. Дуудлага худалдаа, сонгон шалгаруулалт, мэргэжлийн шалгалтын үндсэн дээр болон газар, ашигт малтмал, газрын тос, тэсрэх бодис, тэсэлгээ, банк, санхүү, гааль, үндэсний төлбөрийн систем, хэвлэл мэдээлэл, цөмийн энерги, харилцаа холбоо, тамхи, согтууруулах ундааны үйлдвэрлэл, төлбөрт таавар, бооцоот тоглоом, эд мөнгөний хонжворт сугалааны	Бизнес эрхлэх таатай орчин бүрдсэн байна.	-	-	БХБЯ: Газар, хот байгуулалт, барилгын салбарын 11 төрлийн тусгай зөвшөөрөл, мэргэжлийн эрх олгох, сунгах, нөхөн олгох, хүчингүй болгох, хянан шийдвэрлэх, хяналт тавих үйл ажиллагааг 100 хувь цахим хэлбэрт шилжүүлсэн. Газар, хот байгуулалт, барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн цахим системийг хөгжүүлэх хүрээнд 8942 аж ахуйн нэгж, байгууллага, 44688 инженер техникийн ажилтны мэдээллийн санг бүрдүүлж, www.mcis.gov.mn , www.opendata.gov.mn цахим хуудсуудаар дамжуулан тухай бүр шинэчлэлтийг хийж, мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг ханган ажиллаж байна. Мөн дээрх 11 төрлийн тусгай зөвшөөрөл, мэргэжлийн эрхтэй холбоотой хүсэлтийн холбоосыг E-Mongolia платформд холбосон. Барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн лавлагааг төрийн мэдээлэл солилцооны үндсэн	БХБЯ, ЭМЯ	100.0

	үйл ажиллагаа эрхлэхээс бусад тусгай зөвшөөрлийг шуурхай олгох нөхцөлийг бүрдүүлж, тусгай зөвшөөрөл эзэмшигч өмнө нь тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг зөрчиж байгаагүй бол тусгай зөвшөөрлийн хугацааг иргэн, хуулийн этгээдийн хүсэлтээр эрх бүхий байгууллага анх олгосон нөхцөл, хугацаагаар шуурхай сунгах				системд холбож, төрийн худалдан авах ажиллагааны систем, татварын цахим системүүдтэй мэдээлэл солилцох боломжийг ханган ажиллаж байна. Барилга, хот байгуулалтын яамны харьяа Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар нь газрын нэгдмэл сангийн удирдлагын системээр дамжуулан газрын харилцаатай холбоотой иргэнд чиглэсэн 42, аж ахуйн нэгж байгууллагад чиглэсэн 30 үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлээд байгаа бөгөөд үүнээс 45 үйлчилгээг Төрийн үйлчилгээний нэгдсэн систем E-Mongolia-д холбосон. Барилга, байгууламжийн үйл ажиллагаанд 9 чиглэлд зөвлөх үйлчилгээ үзүүлэх иргэн, хуулийн этгээдийн бүртгэлийн системийг хөгжүүлж, хэрэглээнд нэвтрүүлсэн. 2022 оны 12 дугаар сарын 09-ны өдрийн байдлаар www.license.mcis.gov.mn цахим системээр дамжуулан нийт 4742 хүсэлтийг хүлээн авч, 1214 ААНБ тусгай зөвшөөрөл олгосон ба үүнээс зураг төслийн 291, барилга угсралтын 868, өргөх байгууламжийн 33, барилгын материал үйлдвэрлэлийн 21, хот байгуулалтын баримт бичгийн 1 ААНБ-д тусгай зөвшөөрөл олгосон байна. Цахим системээр олгосон тусгай зөвшөөрлийн 98.2 хувийг МБҮА, 1.8 хувийг МБМҮХ, ГЗБГЗЗГ-ууд хянаж, олгох ажлыг зохион байгуулан ажиллаж байна. ЭМЯ: 2022 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс https://tzmoh.gov.mn/ цахим хуудсаар Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр хүсэх, эрх сэргээх, хугацаа сунгах, хаягийн өөрчлөлт, нэмэлт чиглэл хүссэн хүсэлтийг цахимаар хүлээн авч шийдвэрлэж байна. Мөн Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-д “Хэрэв хуульд өөрөөр заагаагүй, энэ хуулийн 13.1-д заасан нөхцөл байдал илрээгүй тохиолдолд зөвхөн зөвшөөрөл эзэмшигчийн өргөдлийг үндэслэн 3 хоногийн дотор тусгай зөвшөөрлийн хугацааг сунгана”, Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.17.1-д “Тусгай зөвшөөрөл олгосон хугацаанд тухайн байгууллагын үйл ажиллагаанд явцын хяналт, шалгалт хийсэн эрх бүхий мэргэжлийн хяналтын байгууллагын дүгнэлт”, 19.18-д “Тусгай зөвшөөрлийг тухайн байгууллагад анх удаа олгож байгаа бол гурав, сунгаж байгаа бол таван жилийн хугацаагаар олгоно” гэсэн заалтуудыг тус тус үндэслэн Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комиссын даргын шийдвэрээр 55 тусгай зөвшөөрлийн хугацааг 5 жилээр сунгаж шуурхай шийдвэрлэсэн байна.		
93	6.3.3. Тусгай зөвшөөрлийн цахим нэгдсэн санг бүрдүүлж, нээлттэй байлгах	Бизнес эрхлэх таатай орчин бүрдэж, ил тод, нээлттэй байдал нэмэгдсэн байна.	-	-	БХБЯ: Газар, хот байгуулалт, барилгын салбарын 11 төрлийн тусгай зөвшөөрөл, мэргэжлийн эрх олгох, сунгах, нөхөн олгох, хүчингүй болгох, хянан шийдвэрлэх, хяналт тавих үйл ажиллагааг 100 хувь цахим хэлбэрт шилжүүлсэн. Газар, хот байгуулалт, барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн цахим системийг хөгжүүлэх хүрээнд 8942 аж ахуйн нэгж, байгууллага, 44688 инженер техникийн ажилтны мэдээллийн санг бүрдүүлж, www.mcis.gov.mn, www.opendata.gov.mn цахим хуудсуудаар дамжуулан тухай бүр шинэчлэлтийг хийж, мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг ханган ажиллаж байна. Мөн дээрх 11 төрлийн тусгай зөвшөөрөл, мэргэжлийн эрхтэй холбоотой хүсэлтийн холбоосыг E-Mongolia платформд холбосон. Барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн лавлагааг төрийн мэдээлэл солилцооны үндсэн системд холбож, төрийн худалдан авах ажиллагааны систем, татварын цахим системүүдтэй мэдээлэл солилцох боломжийг ханган ажиллаж байна. 2022 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн байдлаар www.license.mcis.gov.mn цахим	БХБЯ	100.0

					системээр дамжуулан нийт 4596 хүсэлтийг хүлээн авч, 1120 ААНБ тусгай зөвшөөрөл олгосон байна. Тусгай зөвшөөрөлтэй холбоотой үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлснээр өмнө 30-45 хоног зарцуулдаг байсан хугацааг 10-15 хоногт багтаан шийдвэрлэдэг болсон ба шат дамжлага, зардал, цаг хугацааг хэмнэхээс гадна авлига, хүнд суртлыг бууруулж байна. Барилга, хот байгуулалтын яамны харьяа Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар нь газрын нэгдмэл сангийн удирдлагын системээр дамжуулан газрын харилцаатай холбоотой иргэнд чиглэсэн 42, аж ахуйн нэгж байгууллагад чиглэсэн 30 үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлээд байгаа бөгөөд үүнээс 45 үйлчилгээг Төрийн үйлчилгээний нэгдсэн систем E-Mongolia-д холбосон. Барилга, байгууламжийн үйл ажиллагаанд 9 чиглэлд зөвлөх үйлчилгээ үзүүлэх иргэн, хуулийн этгээдийн бүртгэлийн системийг хөгжүүлж, хэрэглээнд нэвтрүүлсэн. /100 хувь/ Түрээслээд өмчлөх болон түрээсийн орон сууцны хүсэлт хүлээн авах, хянан шийдвэрлэх үе шатыг бүрэн цахим хэлбэрт шилжүүлэх зорилгоор "Орон сууцны бүртгэл, мэдээллийн нэгдсэн портал, гар утасны апплейшн"-ыг хөгжүүлж байна. ЭМЯ: Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн программыг хөгжүүлснээр Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй улсын болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагад тусгай зөвшөөрөл олгох, сунгах, нэр өөрчлөх, нэмэлт өөрчлөлт оруулах хүсэлтийг 2022 оны 4 дүгээр сараас эхлэн цахимаар хүлээн авч байна. Тусгай зөвшөөрлийн цахим нэгдсэн санг бүрдүүлж, нээлттэй байлгах ажлын хүрээнд тусгай зөвшөөрөлтэй нийт 6013 байгууллагын мэдээллийн санг тус программ хангамжид шилжүүлэн, мэдээллийг баяжуулж, үйл ажиллагаандаа ашиглаж байна.		
94	6.3.4. Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, татвар, гааль, нийгмийн даатгал болон эрүүл мэндийн даатгалаас бусад чиглэлээр төлөвлөгөөт хяналт шалгалтыг бууруулж, төрийн хяналт шалгалтыг эрсдэлд суурилж хэрэгжүүлэх, зөвлөн туслах хэв шинжтэй болгох	Ковид-19 цар тахлын улмаас эдийн засагт үзүүлж байгаа сөрөг нөлөөллийг бууруулах, эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд тодорхой хугацаанд Төрийн хяналт шалгалтын тухай хуульд заасан төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийхгүй бөгөөд зөвхөн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын өргөдөл, хүсэлт, гомдол, мэдээллээр болон хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд шууд буюу шууд бусаар хор хохирол учруулсан тохиолдолд төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг хийнэ. Ингэснээр төрийн хүнд суртлыг багасгах, бизнес	-	-	Зарим төрлийн төрийн хяналт шалгалтыг түр зогсоох тухай хуулийн төслийг боловсруулан, 2022 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, 2022 оны 03 дугаар сарын 11-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн. Улсын Их Хурлын чуулганы 2022 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар уг хуулийн төслийн анхны хэлэлцүүлэгтэй холбогдуулан Монгол Ардын Намын бүлэг 5 хоногийн завсарлага авсан.	ХЗДХЯ	100.0

		эрхлэгчид зардал, цаг хугацааг хэмнэсэн байна.					
95	6.3.5. Хувийн хэвшлийн гадаадаас авах ажиллах хүчний тоонд хязгаарлалт тогтоохгүй байх, хууль тогтоомжийн дагуу ногдуулах ажлын байрны төлбөрийг 50 хувиар хөнгөлөх	Дотоодоос хангах бололцоогүй байгаа ажиллах хүчийг гадаадаас авах боломжийг бүрдүүлсэн байна.	-	-	Гадаадад ажиллах хүч гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хуулийн дагуу ногдуулж буй ажлын байрны төлбөрийг 50 хувиар хөнгөлөх эрх зүйн зохицуулалтыг бий болгохоор Засгийн газрын 2015 оны 41 дүгээр тогтоолоор баталсан "Ажлын байрны төлбөр авах, хөнгөлөлт үзүүлэх, чөлөөлөх журам"-д нэмэлт оруулах тухай Засгийн газрын тогтоолын төслийг 2022 оны 02 дугаар сарын 16, 02 дугаар сарын 23-ны өдрүүдийн Засгийн газрын ээлжит хуралдаанд хэлэлцүүлэн, Засгийн газрын 2022 оны 80 дугаар тогтоолоор батлуулав. Журамд аж, ахуйн нэгж байгууллагуудын гадаад ажилтны ажлын байрны төлбөрийг тухайн асуудлыг эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын шийдвэрээр ажлын байрны төлбөрийг 50 хувиар хөнгөлөхөөр туссан. 2022 оны 11 дүгээр сарын 23-ны байдлаар "Ажлын байрны төлбөрөөс хөнгөлөх тухай" Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны А/85, А/117, А/124, А/126, А/132, А/142, А/156, А/166, А/173, А/195, А/197 дугаар тушаалуудаар хүсэлт ирсэн нийт 292 аж ахуйн нэгж, байгууллагын 3829 гадаад ажиллах хүч, мэргэжилтний ажлын байрны төлбөрийг 50 хувиар хөнгөлөөд байна. Цаашид төрийн захиргааны төв байгууллагуудаас ирсэн саналд үндэслэн ажлын байрны төлбөрийг хөнгөлөх шийдвэрийг тухай бүр гаргана. Хувийн хэвшлийн гадаадаас авах ажиллах хүчний тоонд хязгаарлалт тогтоохгүй байх зохицуулалтыг бий болгохоор "Гадаадаас 2022 онд авах ажиллах хүч, мэргэжилтний эзлэх хувийг тогтоох тухай" Засгийн газрын 2021 оны 11 дүгээр сарын 3-ны өдрийн 339 дүгээр тогтоолыг хүчингүй болгох, тоо хэмжээнд хязгаарлалт тогтоохгүй байх тухай Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулан, Засгийн газрын 2022 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн ээлжит хуралдаанд хэлэлцүүлж, Засгийн газраар 2022 оны 231 дүгээр тогтоолоор батлуулав. Улмаар хувийн хэвшлийн гадаадаас авах ажиллах хүчний тоонд аливаа хязгаарлалт тавихгүйгээр Монгол Улсад хөдөлмөр эрхлэх зөвшөөрлийг хүсэлт гаргасан даруйд олгож байна. Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 22 дугаар зүйлийн 22.1-д заасны дагуу "Монгол Улсад 2023 онд хөдөлмөр эрхлэх гадаад ажилтны тоо, хувь хэмжээг тогтоох тухай" Засгийн газрын 359 дугаар тогтоолыг 2022 оны 10 дугаар сарын 05-ны өдөр батлуулсан.	ХНХЯ	100.0
Зорилт 6.4.Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн үр ашиг, засаглалыг сайжруулж, олон нийтийн шууд хяналтад оруулах ажлыг зохион байгуулна.							
96	6.4.1. Улаанбаатар хотоос бусад орон нутагт ажиллах төрийн албан хаагч Төрийн албаны тухай хуульд заасан ажилласан жилийг тогтоосон тусгай шаардлагын 50 хувийг хангасан бол хугацаанаас өмнө шатлан дэвшүүлэх	Төвлөрлийг сааруулах, ажиллах хүчний эрэлтийг хангасан байна.	-	-	ЭМЯ: Орон нутагт ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчдыг дэмжих, ажлын байранд тогтвортой ажиллуулах үүднээс аймгийн болон алслагдсан дүүргийн Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн даргын албан тушаалын ангилал, зэрэглэлд нэмэлт өөрчлөлт оруулж, Төрийн албаны зөвлөлийн 2022 оны 69 дүгээр тогтоолоор аймгийн Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн даргын албан тушаалын ангилал, зэрэглэлийг төрийн захиргааны дэс түшмэлийн албан тушаал (ТЗ-7 ангилал, зэрэглэл)-аас ахлах түшмэлийн ангилал, зэрэглэл (ТЗ-10)-д шилжүүлсэн. Төрийн албаны зөвлөлийн ЭМЯ-ны дэргэдэх салбар зөвлөлөөс 2021-2022 онд Төрийн албаны тухай хуульд заасан ажилласан жилийг тогтоосон тусгай шаардлагын 50 хувийг хангасан албан хаагчдыг шатлан дэвшүүлэх зорилгоор 18 аймгийн Эрүүл мэндийн	ТАЗ /ЭМЯ/	90.0

					даатгалын хэлтсийн даргын сонгон шалгаруулалтын тусгай шалгалтыг зохион байгуулж, томилсон.		
97	6.4.2. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр байнгын хэрэгцээтэй бараа, ажил, үйлчилгээг худалдан авах гэрээг үнэ болон бусад нөхцөлийг нийлүүлэгч, үйлчилгээ үзүүлэгчтэй тохирч 3 жилээр байгуулах зарчимд бүрэн шилжиж, тендерт оролцогчид тавигддаг шаардлагагүй хязгаарлалтыг халж, тендерийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй, шуурхай болгох	Тендерт оролцогчид тавигддаг шаардлагагүй хязгаарлалтыг халж, зарим төрлийн гэрээг шууд 3 жилээр байгуулах боломж бүрдсэнээр тендерийн үйл ажиллагаа хялбар, хүртээмжтэй болно.	-	-	СЯ: Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Засгийн газрын 2022 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн ээлжит хуралдаанаар хэлэлцэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтсон. Уг хуулийн төсөлд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр байнгын хэрэгцээтэй бараа, ажил, үйлчилгээг худалдан авах гэрээг үнэ болон бусад нөхцөлийг нийлүүлэгч, үйлчилгээ үзүүлэгчтэй тохирч 3 жилээр байгуулах зарчимд бүрэн шилжиж, тендерт оролцогчид тавигддаг шаардлагагүй хязгаарлалтыг халж, тендерийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй, шуурхай болгох зохицуулалтыг тусгасан болно. ЭМЯ: Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 195.2 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 65 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/755 дугаар тушаалаар батлуулж Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем /www.tender.gov.mn/, Мөн Засгийн газрын 2021 оны 396 дугаар тогтоолын дагуу холбогдох газруудад эрхийг шилжүүлсэн бөгөөд 161.4 тэрбум төгрөгийн 36 барилга байгууламж, 16.9 тэрбум төгрөгийн 5 их засвар, 17.0 тэрбум төгрөгийн 24 тоног, төхөөрөмжийн төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг tender.gov.mn буюу худалдан авах ажиллагааны цахим системээр 100 хувь зохион байгуулж, ил тод байдлыг хангах, тендер шалгаруулалтын үр дүнг олон нийтэд нээлттэй мэдээлэн ажиллаж байна. Төрийн худалдан авах ажиллагааны газрын Цахим дэлгүүрээс ерөнхий гэрээгээр худалдан авах эм, эмнэлгийн хэрэгслийн нэр төрлийг 2022 онд шинээр 31 нэрийн эм, 7 нэрийн эмнэлгийн хэрэгслээр нэмэгдүүлсэн. Цахим дэлгүүрт 2022 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн байдлаар 116 нэрийн эм, эмнэлгийн хэрэгсэл байршиж, төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагууд 38.4 тэрбум төгрөгийн худалдан авалт хийж, улсын төсвийн 9.9 тэрбум төгрөгийг хэмнэсэн байна.	СЯ, ЭМЯ	100.0
98	6.4.3. Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагаанд оролцогч нь нийслэл, дүүргээс бусад орон нутагт, эсхүл орон нутагт чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг, татвар төлдөг кластер бүхий аж ахуйн нэгж бол тендерийн үнэлгээ хийхэд давуу эрх үзүүлэх	Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ, гарааны бизнесийг дэмжиж, орон нутагт ажлын байрыг нэмэгдүүлсэн байна.	-	-	СЯ: Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд нийслэл, дүүрэг болон улсын зэрэглэлтэй хотод хамаарахгүй орон нутагт үйлдвэрлэсэн түүхий эд, бараа, материалыг ашиглан үйлдвэрлэсэн бараа санал болгосон тендерт оролцогчийн тендерт 10 хувиар, хэрэв уг үйлдвэрлэгч нь жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч бол 5 хувиар давуу эрх олгож үнэлгээ хийхээр тусгасан болно. БХБЯ: Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төсөлд "Нийслэл дүүргээс бусад орон нутагт үйл ажиллагаа явуулдаг тендерт оролцогчдод давуу эрх олгох" гэсэн заалтыг дэмжиж Барилга, хот байгуулалтын сайдын 2022 оны 1/317 тоот албан бичгээр санал хүргүүлсэн. Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хууль, Барилга, хот байгуулалтын Сайдын багцад нийт 124 төсөл, арга хэмжээ, үүнээс багцын задаргааны 46 нийт 170 төсөл, арга хэмжээ, "Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар дараа онуудад хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний ТЭЗҮ, зураг төсөл" төсөл арга хэмжээний хүрээнд батлагдсан 115 зөвлөх үйлчилгээний ажил, нийт	СЯ, БХБЯ	90.0

					285 ажлаас Засгийн газрын 2021 оны 359, 2022 оны 61 дүгээр тогтоолуудын дагуу 79 төсөл, арга хэмжээний эрхийг орон нутагт шилжүүлсэн, 25 төсөл, арга хэмжээг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Төрийн худалдан авах ажиллагааны газарт, 181 төсөл, арга хэмжээг Барилга, хот байгуулалтын яаманд хэрэгжүүлэхээр шийдвэрлэгдсэн ба 2022 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн байдлаар нийт 248 ажлын тендер зарласан байна. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулиар холбогдох асуудлыг зохицуулаагүй тул орон нутагт, эсхүл орон нутагт чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг, татвар төлдөг кластер бүхий аж ахуйн нэгжид үнэлгээний давуу эрх олгох зохицуулалтыг худалдан авах ажиллагааны тендерийн баримт бичигт тусган хэрэгжүүлэх боломжгүй байна.		
99	6.4.4. Хэрэг, маргааныг урьдчилан шийдвэрлэх механизмын үр нөлөөг сайжруулах, шүүхийн бус журмаар өр барагдуулах арга замыг боловсронгуй болгож, иргэд, арилжаа эрхлэгчдийн хэрэг, маргааныг шүүхээр хянан шийдвэрлэх процессыг хөнгөвчлөх	Иргэд, хуулийн этгээд өр, авлагаа барагдуулахдаа шүүх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын оролцоогүйгээр асуудлаа шийдвэрлэх боломжтой болно.	-	-	Энэ асуудлын хүрээнд тус яамнаас Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хуулийн төсөл боловсруулах ажлын хэсгийг Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2022 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн А/84 дүгээр тушаалаар шинэчлэн байгуулсан. Хуулийн төслийн үзэл баримтлалын төслийг ажлын хэсгийн гишүүдэд 2022 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр танилцуулж, хэлэлцүүлсэн. Ажлын хэсэг 2022 оны 09 дүгээр сарын 26-ны өдөр хуралдав. Хурлаар хуулийн үзэл баримтлалын төсөл болон зарчмуудын талаар танилцуулж, хэлэлцүүлсний үндсэн дээр боловсруулж байна. Мөн Шүүхийн бус журмаар өр барагдуулах үйл ажиллагааны тухай хуулийн төслийг боловсруулах ажлын хэсгийг байгуулан төслийг боловсруулан холбогдох байгууллагаас саналыг авч, Засгийн газрын 2022 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлсэн. Уг хуулийн төслийг Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр нарын нэр бүхий гишүүдээс Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн.	ХЗДХЯ	100.0
100	6.4.5. Төр хувийн хэвшилтэй өрсөлдөж үйл ажиллагаа эрхлэхгүй, зөвхөн стратегийн ач холбогдол бүхий салбарт, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх чухал ач холбогдолтой томоохон төслийг хэрэгжүүлэх зорилгоор, мөн төрөөс үнэ тарифын зохицуулалт хийдэг, хувийн салбар дангаараа эрхлэх боломжгүй, нийтийн ашиг сонирхлын үүднээс зайлшгүй эрхлэх үйл ажиллагааны чиглэлд компани байгуулдаг байх, бизнесийн үйл ажиллагааны удирдлагад хөндлөнгөөс оролцох, нөлөөлөх байдлыг хязгаарлаж, бизнесийн шийдвэр нь улс төрийн нөлөөллөөс ангид байх, төрийн өмчит хуулийн этгээдийн засаглалыг сайжруулж, нээлттэй хувьцаат компани болгох ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэх	Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компанийн засаглал сайжрах, ил тод байдал хангагдах, ашигтай ажиллах нөхцөл бүрдсэн байна.	-	-	Төрийн өмчит хуулийн этгээдийн засаглалыг сайжруулж, нээлттэй хувьцаат компани болгох хүрээнд Улсын Их Хурлын 2021 оны 1 дүгээр сарын 29-ний өдрийн хуралдаанаар баталсан Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар системийн нөлөө бүхий банкууд нээлттэй хувьцаат компани хэлбэртэй байхаар, мөн хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулиар энэхүү шилжилтийг буюу компанийн хэлбэрээ өөрчлөх асуудлыг 2022 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн дотор багтаж өөрчилсөн байхаар тус тус зохицуулсан. Арилжааны банкуудыг нээлттэй хувьцаат компанийн хэлбэрт шилжихээс өмнө Монголбанкнаас эдгээр банкуудад активын чанарын үнэлгээг хийх шаардлага тавигдсаны дагуу банкуудын IPO хийх хугацааг нэг жилээр буюу 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдөр хүртэл сунгах зохицуулалтыг УИХ-ын 2022 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн хуралдаанаар хэлэлцсэн Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиар баталсан. Хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд Төрийн банк олон нийтэд нээлттэй хувьцаат компанийн хэлбэрт шилжих анхдагч арилжааны нээлтээ Монголын Хөрөнгийн биржид 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдөр хийн, хувьцаагаа олон нийтэд санал болгон, IPO амжилттай хийгээд байна.	СЯ	100.0

Зорилт 6.5.Авлига, албан тушаалын гэмт хэрэгт оногдуулах ялын бодлогыг чангатгана.							
101	6.5.1. Авлига, албан тушаалын гэмт хэрэгт оногдуулах ялын бодлогыг чангатгах	Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлэг буюу Авлигын гэмт хэрэг бүлэгт хамаарах эрүүгийн гэмт хэргийн ялын бодлогыг чангатгасан байна.	-	-	АТГ: Эрүүгийн хууль тогтоомжийн уялдаа холбоог хангах, боловсронгуй болгох чиг үүрэг бүхий байнгын ажлын хэсгийн бүрэлдэхүүнд тус газрын Мөрдөн шалгах хэлтсийн дарга, эрхэлсэн комиссар Х.Буянтүмэн томилогдон ажиллаж байна. Тус байгууллагаас Эрүүгийн хууль /шинэчилсэн найруулга/-ийн Хорин хоёрдугаар бүлэгт заасан "Авлигын гэмт хэрэг"-т ногдуулах ялыг чангатгах, хуулийн үйлчлэлд хамаарах этгээдийг тодорхой болгох, зарим гэмт хэргийн бүрэлдэхүүнийг өөрчлөн тодорхойлох, мөн хөөн хэлэлцэх хугацааг нэмэгдүүлэх саналыг Хууль зүй, Дотоод хэргийн яаманд хүргүүлсэн. Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг УИХ-аар хэлэлцэх асуудлыг 2022 оны 06 дугаар сарын 16-ны өдөр хэлэлцсэн болно.	АТГ	70.0
Зорилт 6.6.Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага /ФАТФ/-аас гаргадаг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх стратегийн дутагдалтай улсын жагсаалт /саарал, хар жагсаалт/, Европын холбооны "Татварын зорилгоор хамтран ажилладаггүй бүс нутгуудын жагсаалт"-д орохгүй байх, түүнчлэн Монгол Улсын зээлжих зэрэглэлийг бууруулахаас сэргийлнэ.							
102	6.6.1. Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага /ФАТФ/-аас гаргасан мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх олон улсын стандарт /40 зөвлөмж/-ыг Монгол Улс мөрдөж ажиллах, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх стратегийн дутагдалтай улсын жагсаалт /саарал, хар жагсаалт/, Европын холбооны "Татварын зорилгоор хамтран ажилладаггүй бүс нутгуудын жагсаалт"-д орохоос сэргийлэх	Монгол Улсын эдийн засгийн тогтвортой байдлыг хангаж, гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага /ФАТФ/-аас мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх стратегийн дутагдалтай улсын жагсаалт /саарал, хар жагсаалт/-д орохгүй байх үр дүнд хүрсэн байна.	-	-	1.Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог бэхжүүлэх, дараагийн шатны харилцан үнэлгээний үр дүн амжилттай байх, олон улсын байгууллагын хориг жагсаалтад орохгүй байх зорилгоор Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төслийг олон улсын туршлагад үндэслэн, Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд нийцүүлэн Санхүүгийн мэдээллийн албанаас холбогдох байгууллагуудтай хамтран боловсруулав. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хөтөлбөр нь нийт 8 зорилго, 48 зорилтоос бүрдсэн бөгөөд олон улсын стандартын шаардлагыг хангах, Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог бэхжүүлж, сайжруулах арга хэмжээг багтаасан. Улмаар үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хөтөлбөрийг Засгийн Газрын хуралдаанаар хэлэлцэж, 2022 оны 7 дугаар сарын 05-ны өдрийн 265 тоот тогтоолын хавсралтаар баталсан. Иймд Хамтын ажиллагааны зөвлөлийн гишүүн байгууллагуудын төлөөллийг оролцуулан хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төслийг эцэслэх хүрээнд нийт 4 өдрийн хэлэлцүүлгийг 2022 оны 9 дүгээр сарын 16-20-ны өдрүүдэд зохион байгуулж, эцэслэсэн бөгөөд төлөвлөгөөний төслийг Үндэсний зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж батлуулахаар ажиллаж байна. 2.Монгол Улс Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (ФАТФ)-ын Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлэгт Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх олон улсын стандарт болох 40 Зөвлөмжийн хэрэгжилтийг жил бүр тайлагнах үүрэгтэй. Энэ хүрээнд Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Үндэсний зөвлөл, Хамтын ажиллагааны зөвлөлийн гишүүн байгууллагууд хамтран Монгол Улсын 2022 оны Явцын тайланг боловсруулж, Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлэгт 2022 оны 02 дугаар сарын 01-ний өдөр хүргүүлэн, холбогдох тайлбар мэдээллийг өгч ажилласан. Үүний дүнд 2022 оны 7 дугаар сард болсон Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлгийн жилийн уулзалтаар Монгол Улсын 2022 оны Явцын тайланг баталж, 2022 оны 8 дугаар сарын 02-ны өдөр өөрийн цахим хуудаснаа нийтлэв. ФАТФ-ын Зөвлөмж 15-ын үнэлгээг ахиулсны үр дүнд ФАТФ-ын техник хэрэгжилтийн 40 Зөвлөмжийн нийт 39 Зөвлөмжийн хувьд "Дийлэнхийг биелүүлсэн" болон "Бүрэн биелүүлсэн" гэсэн үнэлгээтэй болсон.	Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Үндэсний зөвлөл, Хамтын ажиллагааны зөвлөлийн гишүүн байгууллагууд: Хууль зүй, дотоод хэргийн яам, Тагнуулын ерөнхий газар, Санхүүгийн мэдээллийн алба, Улсын ерөнхий прокурорын газар, Авлигатай тэмцэх газар, Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Сангийн яам, Гадаад харилцааны яам, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Шүүхийн ерөнхий зөвлөл, Цагдаагийн ерөнхий газар, Улсын дээд шүүх, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Гаалийн ерөнхий газар, Татварын ерөнхий газар, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Терроризмтой тэмцэх зөвлөл, Нийслэлийн прокурорын газар,	100.0

					3. ФАТФ-ын 40 зөвлөмжийг мөрдөж ажиллах хүрээнд Зөвлөмж 15-ын шаардлагад үндэслэн боловсруулсан Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийг УИХ-аар баталсан. Үүнтэй холбоотойгоор Санхүүгийн мэдээллийн албанаас Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчид мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог хэрхэн үр дүнтэй хэрэгжүүлэх тухай хэлэлцүүлгийг Санхүүгийн зохицуулах хороонд бүртгэлтэй 9 биржийн нийт 20 гаруй төлөөллийг хамруулан 2022 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр зохион байгуулсан. Түүнчлэн Санхүүгийн зохицуулах хорооноос боловсруулсан "Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр банкнаас бусад мэдээлэх үүрэгтэй этгээдэд зайны болон газар дээрх хяналт шалгалт хийх журам"-ын шинэчилсэн найруулгын төсөлтэй танилцаж, санал өгөхөөр ажиллаж байна. 4. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Хамтын ажиллагааны зөвлөлийн ээлжит хурлыг 2022 оны 11 дүгээр сарын 04-ны өдөр зохион байгуулсан бөгөөд тус хурлаар Монгол Улсын Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Үндэсний зөвлөлөөр батлуулах талаар хэлэлцсэн. Түүнчлэн, Монгол Улс 2023 оны Харилцан үнэлгээний тайланг Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлэгт 2023 оны 02 дугаар сарын 01-ний өдөр хүргүүлэх зорилгоор ФАТФ-ын Зөвлөмж 8-ын техник хэрэгжилтийн тайланг бэлтгэж хамгаалах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулахаар шийдвэрлэсэн. Тус ажлын хэсэгт орж ажиллах байгууллагуудын төлөөлөл 2022 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр уулзалт хийж, олон улсын зөвлөхөөс зөвлөмж аван ажиллаж байна. 5. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр Монголын Мэргэшсэн Нягтлан Бодогчдын Институт, Монголын Хуульчдын Холбоо, Монголын Өмгөөлөгчдийн Холбоо, Монголын Нотариатчдын Танхим гэсэн 4 мэргэжлийн холбоодтой хамтран нотариатч, хуульч, нягтлан бодох бүртгэлийн болон санхүүгийн зөвлөх үйлчилгээ үзүүлэгчдийн үйл ажиллагаанд газар дээрх хяналт шалгалт хийж ажиллаж байна. Энэ хүрээнд газар дээрх хяналт шалгалтын удирдамжийг боловсруулж батлуулах, шалгалтын цар хүрээг тодорхойлох, хамтарсан уулзалтуудыг хийх арга хэмжээг авч ажиллав. 6. Монгол Улс Евро-Азийн мөнгө угаахтай тэмцэх бүлгийн ажиглагч улсаар 2012 онд элссэн бөгөөд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр авсан арга хэмжээний талаар чуулга уулзалтаар жил бүр тайлагнаж хамтран ажилладаг. Тажикистан Улсын Душанбе хотноо 2022 оны 11 дүгээр сарын 21-25-ны өдрүүдийн хооронд зохион байгуулагдсан Евро-Азийн мөнгө угаахтай тэмцэх бүлгийн 37 дахь чуулга уулзалтад Санхүүгийн мэдээллийн албаны төлөөлөл оролцсон. Монгол Улсаас Евро-Азийн мөнгө угаахтай тэмцэх бүлгийн Чуулга уулзалтын оролцогчидтой мэдээлэл солилцож, улс орнуудын сайн туршлага судлах байдлаар хамтын ажиллагааг сайжруулснаар Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог бэхжүүлэхэд эерэг нөлөөтэй.	Нийслэлийн эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх	
103	6.6.2. Монгол Улсын зээлжих зэрэглэлийг сайжруулах талаар арга хэмжээ авч ажиллах	Монгол Улсын зээлжих зэрэглэл одоогийн байгаа Мүүдис /В3, тогтвортой/, Фитч болон Эс энд Пи	-	-	Монгол Улсын зээлжих зэрэглэлийг олон улсын зээлжих зэрэглэл тогтоогч Фитч, Эс энд Пи болон Мүүдиз агентлагуудтай хамтран ажиллаж байгаа бөгөөд дээрх агентлагууд доорх байдлаар Монгол Улсын зээлжих зэрэглэлийн үнэлгээг хийж гүйцэтгэсэн. Үүнд: 1. Фитч агентлаг Монгол Улсын зээлжих зэрэглэлийн үнэлгээг 2022 оны 4 дүгээр сард үнэлж, 5 дугаар сард Монгол Улсын зээлжих	СЯ	100.0

		/В, тогтвортой/ түвшнээс буураагүй байна.			зэрэглэлийг "В/Тогтвортой" төлөвт хэвээр хадгалах шийдвэрийг гаргаж, олон нийтэд зарласан. 2. Эс энд Пи агентлагын зүгээс мөн Монгол Улсын зээлжих зэрэглэл тогтоох үнэлгээг 2022 оны 5-6 дугаар сард хийж гүйцэтгэсэн бөгөөд энэ хүрээнд Сангийн яам болон Монголбанктай цахим хурлуудыг зохион байгуулан ажилласан. Улмаар Эс энд Пи агентлаг нь 2022 оны 7 дугаар сард Монгол Улсын зээлжих зэрэглэлийг "В/Тогтвортой" төлөвт хэвээр хадгалах шийдвэрийг гаргаж, олон нийтэд мэдээлсэн. 3. Мүүдиз агентлагын хувьд Монгол Улсын зээлжих зэрэглэлийн үнэлгээг хийх зорилгоор тус байгууллагын шинжээчид 2022 оны 9 дүгээр сард Монгол Улсад хүрэлцэн ирж, 2 өдрийн турш Сангийн яам, Монголбанк, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Олон Улсын Валютын сан, Эрдэнэс Монгол ХХК, Худалдаа хөгжлийн банк зэрэг төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудтай уулзаж үнэлгээг хийсэн. Улмаар 2022 оны 11 дүгээр сард Монгол Улсын 2022 оны зээлжих зэрэглэлийн үнэлгээний тайланг өөрийн цахим хуудсанд нийтэлсэн. Мүүдиз агентлагын Монгол Улсын зээлжих зэрэглэлийн төлөвт өөрчлөлт оруулах эсэх тухай шийдвэр гаргах захирлуудын зөвлөлийн хурал нь 2023 оны 1 дүгээр улиралд хуралдах төлөвтэй байгаа тул Монгол Улсын зээлжих зэрэглэл 2022 онд "МЗ/тогтвортой" төлөвт хэвээр хадгалагдаж байна.		
--	--	---	--	--	---	--	--

oOo